

**Редакцийн зурvas**

**“Халдварт өвчний тулгамдсан асуудалууд” эрдэм шинжилгээ,  
онол практикийн 5 дугаар бага хурал**

ХӨСҮТ-өөс Монгол оронд тохиолдож буй халдварт өвчний асуудлаар “Халдварт өвчний тулгамдсан асуудалууд” эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгуулж байна. 2002 оноос эхлэн 2 жил тутамд зохион байгуулж байхаар шийдвэрсэний дагуу энэ оны 11 дугаар сард тавдахь удаагийн бага хурлыг хийж байгаа нь энэ юм.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд АЦХаХ, томуугийн H1N1, ХДХВ, шувууны томуу зэрэг урьд нь мэддэггүй байсан буюу шинээр илэрсэн халдвирууд, тарваган тахал, boom, Нипа вирусын халдвэр, паразитын өвчинүүд, эхинококын халдвэр зэрэг урьд нь бидний мэддэг байсан халдвирууд дахин гарах, тоо нь нэмэгдэх зэргээр шинэ ба дахин сэргэж буй халдвирууд гарсаар байна.

Дэлхийн хэмжээнд хүмүүсийн ажил, амьдралын хэв маяг, хоолхүнс, газар нутаг, хүмүүсийн хоорондын болон хүрээлэн буй орчинтойгоо харьцаа харилцаа өөрчлөгдэж хотжилт, агаарын бохирдол, цаг уурын өөрчлөлт, олон улсын аялал жуулчлал, худалдаа, хүн амзүй, зан үйл, эдийн засгийн хөгжил, газар ашиглалт, ойгүйжилт, микробын дасан зохицол зэрэг хөгжил, даяаршлын эерэг ба сөрөг үйл явууд ч халдварт өвчний гаралт, хувьсал, тархалтанд нөлөөлж байна.

Дэлхий дээр бүртгэгдэж буй халдварт өвчний бараг тал хувийг шинээр тархаж буй халдвэр эзэлж байгаагийн 75%-ийг мал, амьтнаас халдвэрлэдэг өвчинүүд (зоонозын) эзэлж байна.

Манай оронд шувууны томуу, баруун Нилийн халуурлын байгалийн голомт тогтоогдож холер, АЦХаХ, томуугийн H1N1-ын халдвартын тохиолдлууд гарч хүний амь эрсэдсэн.

Халдварт өвчин нь хүн амын дунд хурдаатай

тархаж нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа өнөө үед эрдэм шинжилгээ судалгааны ажлыг гүйцэтгэн үр дүнг практик үйл ажиллагаанд ашиглах явдал чухал юм. ЭМЯ-ны харьяа мэргэжлийн байгууллагууд “Зоонозын халдвартын тулгамдсан асуудлууд”, “Вирус судалын тулгамдсан асуудлууд” “Шинээр тархаж буй халдварт өвчин” зэрэг эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байдааг ХӨСҮТ талархан дэмжиж байдаг билээ.

Нутагшmal болон шинэ ба сэргэн тархаж буй халдвирууд, ялангуяа мал, амьтнаас хүнд халдвэрлэдэг халдвируудын чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд энэхүү бага хурлын гол ач холбогдол оршино гэж үзэж байна.

Дэлхий дахинд анхаарал татаж буй шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчний байгалийн голомтууд сэргэж, судалгаа шинжилгээ эрдэм судалалын ажлыг өргөжүүлж, олон улсын түвшинд хамтын ажиллагааг бэхжүүлэх судалгаа шинжилгээг хамтран зохион байгуулах, хамтран тэмцэх сэргийлэх шаардлага тулгарч байгаа нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ болж байна гэж дүгнэж байна.

Монгол оронд зонхилон тохиолдож буй халдвируудаас гадна шинэ ба сэргэн тархаж буй өвчний байгалийн голомтууд идэвхжиж хүрээгээ тэлж хүн амын дунд өвчлөл нэмэгдэх, зөөвөрлөгдөн орж ирэх магадлал өндөр байгаа нь тэдгээр өвчнийг эрдэм шинжилгээ судалгааны нотолгоонд сууринлан үе шаттайгаар судлах явдал бидний хойшлуулшгүй зорилт болж байгаа юм. Олон сайхан илтгэл хэлэлцүүлж байгаа эрдэмтэд судлаачид, эмч нартаа сэтгүүлийн редакцаас талархал илэрхийлье.

Сэтгүүлийн дэд эрхлэгч,  
ХӨСҮТ-ийн Ерөнхий захирал,  
анаагаах ухааны доктор,  
**Д.Нямхүү**

**Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв**

**“Халдварт өвчний тулгамдсан асуудалууд”  
Эрдэм шинжилгээ, онол практикийн 5 дугаар бага хурал**

**Улаанбаатар хот,  
2010 оны 11-р сарын 5**

**“Халдварт өвчний тулгамдсан асуудалууд” Эрдэм шинжилгээ, онол практикийн 5 дугаар бага хурал 2010.11.5**

### **Редакцийн зөвлөл**

#### **Ерөнхий редактор:**

Д.Нямхүүг - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн захирал

Б.Цацрагт-Од - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн эрдэм шинжилгээ сургалт, гадаад харилаа эрхэлсэн дэд

захирал,

#### **Гишүүд:**

Н.Цэнд - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн зөвлөх

М.Алтанхүүг - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн НЛА-ны дарга

Р.Оюунгэрэл - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, ЭМШҮИС-ийн халдварт өвчин судалын тэнхмийн багш

Н. Хоролсүрэн - АҮ-ны доктор, ЭМШҮИС-ийн халдвартын тэнхмийн багш

Л. Энхбаатар - АҮ-ны доктор, Халдварт Өвчинтэй тэмшэх Монголын Үндэсний Холбооны гүйцэтгэх захирал

Д. Абмэд - Биологийн Ухааны доктор, ХӨСҮТ-ийн Шимэгч судалын лабораторийн тасгийн эрхлгэч,

Р. Туул - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн Вирус судалын лабораторийн их эмч

Ч. Мөнхцэцэг - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн Тандалтын үндэсний нэгжийн дарга

М. Оюунгэрэл - АҮ-ны доктор, ХӨСҮТ-ийн Чанарын менежер

Д. Өлзиймаа - ХӨСҮТ-ийн гадаад харилаа хариуцсан мэргэжилтэн

## Илтгэлийн товчлолууд

### В вирүст хепатитын эсрэг вакшины эдийн засгийн үр ашиг

Ж. Баярсайхан<sup>1</sup>, Ч. Бямбасүрэн<sup>2</sup>, П. Цэдэн<sup>3</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Улсын Клиникийн Төв Эмнэлэг

<sup>3</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Манай улс 1923 оноос цагаан цэцэг өвчний эсрэг, 1962 оноос полиомиелитийн эсрэг, 1966 оноос сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг, 1974 оноос улаанбурханы эсрэг, 1986 оноос сүрьеэгийн эсрэг, 1991 оноос В вирүст хепатитын эсрэг, 2005 оноос эхлэх үе шаттайгаар тавт вакшин (сахуу-хөхүүл ханиад-татран-В хепатит-хемофилиос инфлюенза В) вакшиныг тус тус дарлаажуулалтанд нэвтрүүлсний үр дүнд 1940 онд цагаан цэцэг, 2000 онд халдварт саа өвчнийг устгасныг тус тус баталгаажуулсан. Гэвч дархлаажуулалтын хамралтын хувь өндөр боловч түүний эдийн засгийн ач холбогдолыг харуулсан судалгаа тэр бүр байдаггүй.

**Зорилго:** В Вирүст хепатитын эсрэг вакшины эдийн засгийн үр ашигийг тооцох

**Материал арга зүй:** Судалгаанд ХӨСҮТ-д В вирүст хепатит оноштойгоор хэвтэн эмчлүүлсэн 0-2 насны 134 хүүхдийн өвчний түүх, санхүүгийн мэдээ, тайланд эргэмж судалгааг хийж дундаж ор хоног болон эмчилгээний зардалыг, эдийн засгийн зардал хувиарлах дээрээс доош тооцох арга, доороос дээш тооцох арга, тохиолдлыг холих арга болон жигнэсэн дундажийн аргаар (onoшлогоо болон цалин хөлс, гэрэл цахилгаан, халаалт дулаан зэрэг бусад зардлыг оролцуулан) "Эмнэлгийн туслаж үйлчилгээ, (бүтээгдэхүүний өртөг тооцох гарын авлага" –ыг ашиглаж Microsoft office Excel 2007 праграмм дээр тооцоололсон хийв.

Үр дүн: В вирүст хепатит өвчнөөр өвчилж хэвтэн эмчлүүлсэн 0-2 насны хүүхдийн дундаж ор хоног 20.4 хоног, оношлогоо эмчилгээний зардал нь 21 958 төгрөг болж байна. В вирүст хепатит өвчний эсрэг дарлаажуулалтын бэлдмэлийн нэг хүн тунг 214.6 төгрөгөөр худалдан авч байгаа нь вакшин хийлгэсэнээр эдийн засгийн хувьд 21743.4 төгрөгний хэмнэлт гаргаж болох нь тогтоогдож байна. В вирүст хепатитын оношлогооны зардал 5200 төгрөг. В вирүст хепатит өвчнөөр өвчилсөн тохиолдолд эмчилгээний зардал 10260.6 төгрөг байна.

**Дүгнэлт:** В вирүст хепатитын эсрэг вакшин нь эдийн засгийн хувьд ашигтай байгаа нь вакшинжуулалтын зардалаар 21546.8 төгрөгний хэмнэлтийг улсын эдийн засагт бий болгож байгаагаар нотлогдож байна.

"Халдварт өвчний тулгамдсан асуудалууд" онол- практикийн 5 дугаар бага хурал

### Дархан-Уул аймагт тархсан томуугийн цартахлын А(H1N1)v вирусийн халдварын дарамт

Б.Дуламжав<sup>1</sup>, О.Дулмаа<sup>1</sup>, Р. Оюунгэрэл<sup>2,3</sup>,

Н. Хоролсүрэн<sup>2</sup>

<sup>1</sup>Дархан-Уул аймагийн Нэгдсэн эмнэлэг,

<sup>2</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль,

<sup>3</sup>Халдварт Өвчин Судалалын Үндэсний төв

2009 оны 4-р сард анх Мексикээс эхэлсэн томуугийн цартахлын А(H1N1)v вирусийн халдварын давалгаан 2009 оны 10-р сарын дунд үеэс манай орныг хамарч эхэлсэн. Монгол оронд тархсан энэхүү халдварын тархвар судал, эмнэлзүй онцлогийг хүн ам нягт суурьшсан хот, хүн ам тархай буттархай хөдөө орон нутгуудаар ялгавартай тодорхойлон харуулах нь дэлхий дахинаа шинэ халдвар хэмээн тооцогдож байгаа тухайн халдварын онцлогийг тодорхойлоход тус дэм болох болно.

**Зорилго:** Дархан-Уул аймагт тархсан томуугийн цартахлын А(H1N1)v вирусийн халдварын үеийн эмнэлзүйн явц, хүндэрэл, оношлогоо, эмчилгээний байдлыг судлах

**Материал, арга зүй:** 2009 оны 10 дугаар сарын 19-нөөс 2010 оны 1 дүгээр сарын 15-ны хоорона Дархан-Уул аймагийн Нэгдсэн Эмнэлгийн томуугийн тасагт томуугийн А(H1N1)v вирусийн халдвар оноштой хэвтэн эмчлүүлсэн насанд хүрсэн 181 өвчтөний өвчний түүхэнд эргэмж судалгааг хийлээ.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт өвчтөний 64% нь (116) эмэгтэй, 36% (65) нь эрэгтэй ба 19.3% (35) жирэмсэн эмэгтэй байв. Өвчлөгсөдийн дунд 6-24 насныханы (44.7%) өвчлөл зонхицж байсан. Эмнэлзүйн хувьд хүнд хэлбэрээр 11 хүн ( 6,2%), хүндэвтэр - 47 (25,9%) , дунд - 123 ( 67,9%) хүн өвдөж, 41,4% (75) нь хүндэрлгүй явагдаж, 41,9% (76) нь хатгалгаагаар , 16,5% (30) нь гуурсан хоолойн үрэвсэлээр хүндэрсэн. Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 20 нь хүндэрлгүй, 8 нь гуурсан хоолойн үрэвсэлтэй, 7 нь хатгалгаагаар хүндэрсэн байлаа. 25-44 насныханд томуугийн хүндэрэл элбэг тохиолдсны 16-24 насныханд хатгалганы 37%, 25-44 насныханд 47,7% нь тохиолдсон байна. Хүндэрлгүй хэлбэрийн томуугийн үед халуурах шинж 80,6%-д илэрч байсан бол хатгалгаагаар хүндэрсэн тохиолдолд 88,1%, ханиах 79% ба 77,6%, цээжээр өвдөх 49,7% ба 68,4%, хамар битүүрч нус гоожих 28,7% ба 60%, амьсгаадах 23,2% , хоолой өвдөх 23,7% , толгой өвдөх 31,4%, булчин өвдөх 19,3% , бачуурах давчдах 11,6%

ба 18,4% , тамирдах сульдах 12,7% , хоолонд дургүй болох 11% ба 22,3% тус тус тохиолдсон байна. Харин бөөлжих, суулгах, ухаан алдах, ам хатах, цэр гарах, хоолой сөөх, нойронд муудах, хөлрөх, чих дүлийрэх, чичрэх шинж цөөн тоотой гарчээ. Амьсгалын цочмог дистресс хамшинж 19 (10,4%) өвчтөнд илэрсэнээс 11 нь хүндэвтэр, 8 нь хүнд явтай байлаа. Томуу өвчнөөр өвчлөгсөдийн 19,3% буюу 35 өвчтөн ямар нэгэн хавсарсан өвчтэй байсан. Үүнд: цээжний сүрьеэ 6 , багтраа 5, гуурсан хоолойн архаг үрэвсэл 7 , чихрийн шижин 2 , төрөлхийн лордиоз 1, архаг пиелонефрит 3, хепатитын С вирусийн архаг үрэвсэл 1 , нойр булчирхайн архаг үрэвсэл 1, даралт ихдэх өвчин 5, зүрхний архаг эмэг (ХИБС) 4 тохиолдол байлаа. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн дундаж ор хоног 7,7, хүндрэлгүй хэлбэрийн томуугийн үед 5,6 хоног, гуурсан хоолойн үрэвсэлээр хүндэрсэн үед – 7,5, хатгалгатай үед 9,9 хоног байв. ЦЕШ-нд бүх өвчтөний 77,9% хамрагдсан ба цагаан эсийн хэмжээ 88,9% -д нь өөрчлөлтгүй, харин УЭТХ нь 60,2 % -д ихэссэн, биохимийн шинжилгээ 27 хүнд хийснээс 44,4% -д нь АлАТ AcAT ферментийн идэвх өндөрсчээ. Уушгинь хатгалгаар хүндэрсэн өвчтөний рентген шинжилгээнд 2 талын доод дэлбэнгийн нэвчдэст сүүдэр 31, хоёр талын уг ба дуна доод дэлбэнгүүдэд тархсан нэвчдэс 2, хоёр талын доод дунд дээд дэлбэнд тархсан нэвчдэс /үүлэн сүүдэр/ 1, зүүн талын доод дэлбэнгийн нэвчдэс 24, зүүн талын уушгийг нилд нь хамарсан нэвчдэс 2, баруун талын доод дэлбэнг хамарсан нэвчдэс 14, баруун талын дунд дэлбэнгийн нэвчдэс 1 тохиолдолд тус тус илэрсэн. Судалгаанд хамрагдсан өвчтөний 7,1% (13)-д УТ-ПГУ шинжилгээг хийхэд 53,8% (7)-д нь онош батлагдсан. 84 өвчтөнд тамифлю эмийг уулгаж түүнэдээ 2487600 төг, 1 хүний эмчилгээнд 53319 төг, нийт 9650742,52 төг эмчилгээнд зарцуулсан байна. 5 их эмч, 13 сувилагч нийт 742 цаг илүү ажилласан. Эмнэлгийн ажилчдын ажлын хөлс болон эмийн зардлыг тооцож үзэхэд халдвартын тасгийн улирлын эмийн зардалаас ойролцоогоор 3 дахин илүү зардал заршуулжээ.

**Дүгнэлт:**

1. Дархан-Уул аймгийн томуугийн тасагт хэвтэн эмчлүүлсэн насанд хүрсэн хүмүүсийн дунд 15-24 насныхан зонхиц, 25-44 насныханд хатгалганы хүндэрл илүүтэй тохиолдажээ.
2. Эмнэлзүйн хувьд дунд болон хүндэвтэр хэлбэр давамгайлсан боловч амьсгалын дистресс хамшинж цөөнгүй тохиолдож хүндэвтэр явтай байна.
3. Хатгалганы үед 2 талын уушгийг хамарсан үрэвсэл зонхиц байна.
4. Эмнэлгийн ажилчдын нөөц болон эдийн засгийн зардлыг Томуугийн Үндэсний зөвлөлгөөний үед боловсруулсан нөөцийн төлөвлөгөөний загварын дагуу аливаа нийгмийн онц ноцтой байдлын үед

бэлтгэн хангах нь эмнэлгийн ажилчадад болон эдийн засагт үзүүлэх дарамтыг багасгах болно.

**Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн Оншлогоо Эмчилгээний Төвийн эмнэлэгт томуугийн A(H1N1) вирусын халдвараар хэвтэн эмчлүүлэгсдийн өвчний түүхэнд хийсэн судалгааны дүн**

С.Энхтуяа, А.Бурмаа, А.Билэгт  
Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв

Томуугийн A(H1N1)v вирусын халдвартын анхны тохиолдол нь манай улсад 2009 оны 10 сард бүртгэгдэж нийт 1384 тохиолдол лабораториор батлагдсанаас 30 хүн нас барсан. Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгууд нь нийслэл хотод ойр, дэд бүтэц сайн хөгжсөн, хүн ам ихээр дамжин өнгөрдөг ба томуугийн цартахлын үед 2009 – 2010 онд лабораториор батлагдсан 131 тохиолдол бүртгэгдэж, 6 хүн нас баржээ.

**Зорилго:** Томуугийн A(H1N1)v вирусын халдвартын үед Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймгийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн өвчтүүдийн өвчний түүхийг судлан, эмнэлзүйн явц онцлогийг тогтоох

**Материал, арга зүй:** Томуугийн A(H1N1)v вирусын халдвараар Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгуудын нэгдсэн эмнэлэгт 2009 оны 10 сараас 2010 оны 3-р сарыг хүртэлх хугацаанд хэвтэн эмчлүүлсэн 571, нас барсан 8 өвчтний өвчний түүхэнд эргэмж судалгаа хийв.

**Үр дүн:** Өвөрхангай аймагт томуугийн A(H1N1)v вирусын халдвартын анхны тохиолдол 2009 оны 10 сарын 13-ний өдөр мэдээлэгдсэн ба 2009 оны 10 сараас 2010 оны 3 сарыг хүртэлх хугацаанд Бүсийн Оншлогоо Эмчилгээний Төвд томуугийн цартахлын халдвартын сэжигтэй, уушигны хатгалгаатай, ТТӨ-тэй нийт 258 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн, нас барсан 5 тохиолдол байна. Хэвтэн эмчлүүлэгсдийн 63,5% нь эмэгтэйчүүд байна. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт томуугийн A(H1N1) вирусын халдвартай 112 тохиолдол хэвтэн эмчлүүлэн, 2 нас барсан байна. Эмчлүүлэгсдийн 63,5% нь эрэгтэйчүүд эзлэж байна. Архангай аймгийн нэгдсэн эмнэлэгт томуугийн A(H1N1) вирусын халдвартай 201 тохиолдол хэвтэн эмчлүүлэн, 1 нас барсан байна. Эмчлүүлэгсдийн 76,1% нь хүүхдүүд байна. Дээрх 3 аймгийн хэвтэн эмчлүүлэгсдийг оношоо авч үзэхэд: ОРВИ пневмони

- 56%, бронхит -14%, ларинготрахеобронхит -21,4%, томуу А(H1N1)v -8,6%, хүндрэл ( менингит 1,3%, энцефалит 1,1%) хавсарсан өвчин 31% (пиелонефрит, ангина, ХИБС, ХОБЛ, Ожирение) -ийг тус тус эзлэж байна. Эмнэлзүйн хувьд хүнд хэлбэр - 78 (13,6%), хүндэвтэр - 83 (14,5%), дунд зэрэг- 410 (71,8%) ба дундаж ор хоног 7 – 8 хоног байв. Архангай аймагт 0-16 насыхан 76,1%, насанд хүрэгчид 23,8%, Баянхонгор, Өвөрхангай аймгуудад 0-4 насыхан 30%, 16-24 насыхан 26,5%, 25-34 насы 19,3%, 35-44 насыхан 11,6%, 45-54 насыхан 4,1%, 55 дээш 7,2% -ийг тус тус эзлэж байна.

Эмчилгээний зорилгоор тамиифлю эмийг 295 (51,6%), антибиотик хэрэглэсэн 511 (89,4%) тохиолдолд хэрэглэсэн. Дээрх 3 аймагт томуугийн цартахлын халдвартын үед нас барсан 8 тохиолдол бүртгэгдсэнээс эрэгтэй 5 (62,5%), эмэгтэй 3 (37,5%), 4 сараас – 4 нас хүртэлх хүүхэд 4 (50%), 17-22 насыхан 3 (37,5%), 51 настай 1 (12,5%) тохиолдол, ор хоногийн хувьд 13 шагаас 3 хоногт 87,5%, 4-6 хоногт 12,5% нь тус тус эмнэлэгт байсан.

#### Дүгнэлт:

1. Баянхонгор, Архангай, Өвөрхангай аймагт томуугийн цартахлын халдвартын үед өвчлөлийн тоо өндөр, Баянхонгор аймагт эрэгтэйчүүд, Өвөрхангай аймагт эмэгтэйчүүд, Архангай аймагт хүүхдийн өвчлөл өндөр байлаа.
2. Судалгаагаар өвчлөгслийн 98% нь амьсгалын замын үрэвсэлтэй байна.
3. Нас барсан тохиолдын 62,5 % нь хүүхэд, насанд хүрэгчид 37,5% ба эмнэлэгт хожуу хандсаны улмаас эмнэлэгийн тусламж авсан боловч үр дүнгүй байсан.

### Шинээр илэрсэн сүрьеэ өвчний мэдээлэлд хийсэн дүгнэлт

Д.Наранзул, Н.Наранбат

Халдварт өвчин судалын үндэсний төв

“Шинээр илэрсэн сүрьеэ өвчний мэдээлэх хуудас”-ыг 2005 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Эрүүл мэндийн статистик мэдээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 34 тоот тушаалаар дахин батлан ашиглаж байна. Энэ мэдээлэх хуудас нь сүрьеэ өвчний тандалт судалгааны суурь баримт бичиг бөгөөд цаашид сүрьеэтэй тэмцэх, хянах ажлын чиг хандлагыг тодорхойлоход ач холбогдолтой.

**Зорилго:** “Шинээр илэрсэн сүрьеэ өвчний мэдээлэх хуудас”-д судалгаа хийж оюутан, сургачид болон эрүүл мэндийн ажилтаны сүрьеэгийн өвчлөлд дүгнэлт хийх

**Материал, арга зүй:** 2007-2009 онд 21 аймаг,

Улаанбаатар хотын 9 дүүргээс Халдварт өвчин судалалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт, судалгааны албад ирүүлсэн 10237 ширхэг “Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх” хуудсанд эргэмж судалгаа хийв. 2007-2009 онуудад ХӨСҮТ-ийн эмч, эрүүл мэндийн ажилтанаас “Хөдөлмөрийн чадвар түр алдсан ажилтаны нэгдсэн бүртгэл”-ийг Хүний нөөц, хөгжлийн албанаас авч эргэмж судалгаа хийсэн.

**Үр дүн:** 2007-2009 онд улсын дүн бүртгэлийн мэдээгээр нийт 12802 сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдсэнээс 10237(79%) нь “Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас”-аар мэдээлэгдсэн байна. 2007-2009 онуудад мэдээлэгдсэн тохиолдолын 43.3% (4436)-ийг тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд, 9.7% (994)-ийг оюутан, 8.8% (901)-ийг ерөнхий боловсролын сургуулийн сургачид, 7.0%(712)-ийг өндөр насны тэтгэвэрт байгаа иргэд эзэлж байна. Мөн хугацаанд улсын хэмжээнд нийт 111 эрүүл мэндийн ажилтан сүрьеэгээр өвчилсөн нь нийт өвчлөлийн 1.1%-ийг эзэлж байна.

Эрүүл мэндийн ажилтаны сүрьеэгийн өвчлөлийн 30.6%(34)-ийг сувилагч, 28%(31)-ийг их эмч, 15.3%(17)-ийг асрагч эзэлж байна.

Эрүүл мэндийн ажилтанаас сувилагч нар арай илүү өвчилсөн байна. Эмч нарын сүрьеэгийн өвчлөлийг нарийн мэргэжлийн чиглэлээр авч үзэхэд сүрьеэ, шүүхийн шинжээч, мэс засал, шүд, эрүүлжүүлэх төвийн эмч, сум, өрхийн эмч нар давамгай өвчилсөн байна.

ХӨСҮТ болон ШШГЕГ-ын харьяа эмнэлгийн эрүүл мэндийн ажилтаны дундах сүрьеэгийн өвчлөл бусад төрөлжсөн мэргэжлийн болон тусгай эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас өндөр байна.

Эрүүл мэндийн ажилтаны 48.7% нь уушгины, 42.3% нь уушгины бус эрхтэний сүрьеэгээр өвчилсөн байна. Уушгины бус эрхтэний сүрьеэгийн өвчлөлийн дотор 57.4%(27)-ийг плеврит, 29.7%(14)-ийг лимфаденит, 6%(3)-ийг ясны сүрьеэ эзэлж байна.

2007-2009 онд ХӨСҮТ-ийн эрүүл мэндийн ажилтанаас сүрьеэгээр өвчилсөн байдлыг судлахад нийт их эмч нарын 1.6%, нийт сувилагч нарын 4.1% нь сүрьеэгээр өвчилсөн байна. Харин өвчлөлийг нэгж салбараар нь авч үзвэл нийт сүрьеэгийн тохиолдын 79.0% нь Сүрьеэгийн Клиникээс бүртгэгджээ.

Сүрьеэгийн клиникт бүртгэгдсэн нийт 11 тохиолдолын 4(37.0%) нь мэс заслын тасаг, 2(18.0%) нь уушгины II тасаг, 3(27.0%) нь уушгины III тасаг, 1 (9.0%) хүүхдийн уушгины тасаг, 1 (9.0%) нь СТСА-ас бүртгэгдсэн байна.

Мөн мэдээлэгдсэн сүрьеэгийн өвчлөлийн тохиолдол ХӨСҮТ-д 8 байгаа боловч 2007-2009 онд ХӨСҮТ-ийн эмч, ажилтанаас “Хөдөлмөрийн чадвар түр алдсан ажилтаны нэгдсэн бүртгэл”-ийг судлахад Сүрьеэгийн клиник болон халдвартын клиникин эмч,

ажилтанаас сүрьеэгээр өвчилсөн нийт 6 тохиолдол бүртгэгдсэн боловч мэдээлгээгүй байна.

#### Дүгнэлт

1. 2007-2009 оны байдлаар шинээр сүрьеэгээр өвчлөгсөдийн 43.3%-ийг тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд, 9.7%-ийг оюутан, 8.8%-ийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, 7.0%-ийг өндөр насны тэтгэвэрт байгаа иргэд, 1.1%-ийг эрүүл мэндийн ажилтан эзэлж байна.

2. Оюутан, сурагчын өвчлөлийн эзлэх хувь 18.5 байгаагаас гадна нийт өвчлөлийн дотор оюутаны эзлэх хувь жил бүр нэмэгдэж байгаад нэмэлт судалгаа явуулж, дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

3. Эрүүл мэндийн ажилтаны сүрьеэгийн өвчлөлийн 30.6%-ийг сувилагч, 28%-ийг эмч, 15%-ийг асрагч нар эзэлж байна. Сүрьеэгийн халдварт авах, өвчлөх эрсдэл өндөртэй эрүүл мэндийн байгууллага, нэгж салбаруудын халдвартын хяналтын арга хэмжээг нэн даруй сайжруулах шаардлагатай байна.

### Улаанбаатар хотын эмч, эмнэлгийн ажиллагсдын дунд хепатитын В, D вирусийн тархалтыг илрүүлсэн дүн

Б.Отгонбаяр<sup>1</sup>, Т.Хосбаяр<sup>2</sup>, Ц.Гэрэлмаа<sup>2</sup>, Э.Аззаяа<sup>2</sup>, Б.Сувдаа<sup>2</sup>, М.Пүрэвдорж<sup>2</sup>, Б.Мөнгөнцэцэг<sup>1</sup>, Т.Буянхүү<sup>1</sup>, Ж.Сарантуяа<sup>2</sup>, Н.Бира<sup>2</sup>, Вонкю Чой<sup>1</sup>

<sup>1</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Эмч, эмнэлгийн мэргэжилтүүд ажил үүргээ гүйштгэх үедээ бохирлогдсон зүү тариуранд хатгагснаас цусан халдварт авах эрсдэлтэй байдаг бөгөөд ΔЭМБ-ын мэдээгээр анхаарал болгоомжгүйгээс энэ төрлийн гэмтэлд өртөж жил бүр эмнэлгийн 66000 ажиллагсад хепатитын В вирус (HBV), 200-5000 ажиллагсад ХДХВ-ийн халдвартыг авдаг байна.

Манай орны хүн амын дунд HBV, хепатитын D вирус (HDV)-ийн халдвартын тархалт харьшангий өндөр хувиар буюу HBV-ийн халдвартын тархалт 10.7% (Б.Цацралт-Од 2006., Такахashi 2004), HDV-ийн тархалт 6.1-8% (Б.Цацралт-Од 2006., Такахashi 2004., Д.Даваалхам 2004) байдаг. Манай оронд Г.Соёлгэрэл, S.Logez (2006 он) нарын судалгаагаар шаардлагагүй тарилга ихтэй, Ш.Энхцэцэг нар (2008)-ын судалгаагаар эрүүл мэндийн салбарт эмнэлгийн хог хаяглын менежмент (ЭХХМ)-ийн зохисгүй систем байгаа нь тогтоогджээ.

Энэ бүхэн нь манай оронд хүрч үзүүртэй багаж хэрэгслийн гэмтлийн улмаас эмч, эмнэлгийн

мэргэжилтнүүд ажил үүргээ гүйштгэх явцдаа цусаар дамжих халдварт авах эрсдэл өндөр байгааг харуулж байна.

**Зорилго:** УБ хотын эмч, эмнэлгийн ажиллагсдын дунд HBV, HDV-ийн халдвартын тархалтыг тодорхойлох.

**Материал, арга зүй:** Судалгаанд Улаанбаатар хотын I, II, III шаталын эрүүл мэндийн тусламж үйлчилгээгүүдэлэг 354 эмнэлгүүдийн нийт 354 эмч, ажиллагсдыг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамрууллаа. Судалгаанд оролцогчийн ийлдсэнд В вирусийн HBsAg, Anti-HBs, Anti-HBc, HBeAg маркеруудыг, болон D вирусийн Anti-HDV маркерыг ФХҮ-ын аргаар илрүүлээ (Diagnostic Automation, Inc, USA). HBV-ийн HBsAg, Anti-HBc эерэг оролцогчдод вирусийн нуклейн хүчлийг ПГҮ-ын шинжилгээгээр илрүүлээ (ДНК-Технологи, OХҮ).

**Үр дүн:** Судалгаанд Улаанбаатар хотын I, II, III шаталын 9 эмнэлгийн 94 нь эмч, 183 нь дунд мэргэжилтэн, 77 үйлчлэгч нийт 354 эмч, эмнэлгийн ажиллагсдыг хамрууллаа. Нийт судалгаанд хамрагдагсдын 28.4% (n=100)-д HBV-ийн халдварт илэрсэн бөгөөд үүнээс ийлдээс судалалын шинжилгээгээр HBV-ийн HBsAg маркер 9.5%-д, Anti-HBc маркер 83.3%-д, anti-HBs маркер 36.4%-д, HBeAg 0.3%-д нь тус тус тодорхойлогдоо. Молекул биологийн шинжилгээгээр Anti-HBc болон HBsAg эерэг тодорхойлогдсон 178 сорыны 84-д нь В вирусийн нуклейн хүчил илэрсэн ба HBV-ийн ДНХ эерэг 66 тохиолдолд гадаргуугийн эсрэг төрөгч (HBsAg) илрээгүй байсан нь бидний судалгааны хамгийн сонирхолтой үр дүн байсан. Манай судалгаагаар Anti-HBc маркер элэгний архаг эмгэгтэй өвчтөнүүдтэй (86% Б.Цацралт-Од) ойролцоо буюу 83.3%-д илэрсэн нь манай орны нийтээс, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд HBV-ийн тархалт өндөр байж болзошгүйг нотолж байна (эрүүл хүн ам - 73% Б.Цацралт-Од). Нийт оролцогчийн 7% (n=24)-д HDV-ийн anti-HDV маркер тодорхойлогдсон бөгөөд В вирусийн гадаргуугын эсрэг төрөгч (HBsAg) эерэг эмнэлгийн мэргэжилтний 68.6%-ны HDV-ийн халдвартыг давхар авсан байв. Цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэх, мэс ажилбар хийлгэх нь гептитийн вирусүүдийн халдварт өртөх эрсдэл болж байгаа нь О.Цацралт-Од нарын (2006) судалгаатай дүйж байна.

#### Дүгнэлт:

1. Бидний судалгаанд хамрагдсан 354 эмнэлгийн ажиллагсдын дунд хепатитын В вирусийн (28.4%) илрэлийг эрүүл хүн ам дахь тархалт (HBV-10.7% Б.Цацралт-Од 2006., Такахashi 2004)-тай харьцуулахад өндөр байна ( $p < 0.05$ ).

2. В вирусийн халдвартыг зөвхөн гадаргуугийн эсрэг төрөгч (HBsAg)-ийн илрэлтээр дүгнэх нь S генийн мутаци (HBsAg-ний бүтцийн өөрчлөлт), архаг

тогтонги халдварт, HBV-ийн халдварын цонх үед байгаа HBV-ийн халдварыг илрүүлж чадахгүй, учир дутагталтай байна.

3. Цус цусан бүтээгдэхүүн хэрэглэх, мэс ажилбар хийлгэх, шөнийн ээлжинд ажиллах, илүү цагаар ажиллах нь хепатитын вирусийн халдварын эрдэлт хүчин зүйл болж байна ( $p<0.05$ ).

## **Улаанбаатар хотын 53-р сургуульд бүртгэгдсэн хоолны хордлогын дэгдэлтэнд хийсэн эпидемиологийн судалгааны дүн**

А.Амбасэлмаа, Г.Цэрэндолгор, Д.Бадрал, В.Байгал, Д.Мөнхцэцэг, А.Баасанжав, А.Билэгт, Б.Дэлгэрмаа, Н.Хандсүрэн, Э.Оюунтуяа, Д.Цэцэглэн, Г.Сүрэнханд  
Халдварт Өвчин Судалалын Үндэсний Төв

Хоолны хордлогот халдварт нь тодорхой цаг хугацаанд тодорхой газарт тодорхой хүнсний зүйл хэрэглэсэн хамт олны дунд мэдэгдэхүйц дэгдэлт хэлбэрээр тохиолддог.

Америкийн Нэгдсэн Улсын 43 мужид 2009 оны байдааар 1-98 насны 529 хүн Salmonella Typhimurium-ийн халдвараар өвчилсөн ба 22% нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 8 хүн нас барсан байна. Халдварын эх уурхайг судалж үзэхэд газрын самар, түүгээр хийсэн бүтээгдэхүүнүүд хэрэглэсэн ажээ. Австралид 2009 онд онош тодорхойгүй хоолны хордлого гарсан ба судалгаагаар хордлогын шалтгаан нь үр тарианаас илэрсэн мөөгний овгийн Fusarium илэрсэн байна. Энэ мөөгөнцөр нь оппортунист халдварыг дамжуулдаг ба үр тариа буудайна ягаан өнгийн толбо үүсгэдэг байна. ОХУ-ын Свердловск хотод хоолны хордлого бүртгэгдэж 6 хүн өвчилснөөс 1 хүн нас баржээ.

Манай улсын хэмжээнд 2004-2009 онуудад 26 удаагийн хоолны хордлогот халдварын дэгдэлт бүртгэгдэж, 2276 хүн өвчилиж, 1 хүн нас баржээ. Дэгдэлтүүдийн 19,2% нь Salmonella enteritidis, 23,0% нь Salmonella bovismorbificans, 7,6% нь Citrobacter freundii, 3,8% нь Salmonella albicans-aap үүсгэгдсэн хоолны хордлогот халдварт байжээ. Халдварт нь үхрийн мах, бялуу, өндөг, элэгний нухаш, нийслэл салат, хуушуур, зраз гэсэн бохирлогдсон хоол хүнс хэрэгслэснээс дамжсан гэж үзжээ.

2010 онд Монгол-Оросын хамтарсан 3-р сургуульд Shigella flexneri-ээр үүсгэгдсэн дэгдэлт 123 хүн, Ховд аймгийн Булган сумын сургуулийн дотуур байранаас бүртгэгдсэн шалтгаан тодорхойгүй дэгдэлт 170 хүн, Баянзүрх дүүргийн 53-р сургуульд Citrobacter freundii үүсгэгдсэн дэгдэлт 30 хүн, Сүхбаатар

дүүргийн Баянбулаг зусландаа Salmonell Bovismorbificans-ээр үүсгэгдээн дэгдэлт 17, Хүчин Шонхор захын ажилчдын цайны газарт Salmonell. typhimurium-ээр үүсгэгдсэн дэгдэлт 37 хүнийг тус тус хамарсан хоолны хордлогот халдварын томоохон дэгдэлтүүд бүртгэгдсэн.

**Зорилго:** Улаанбаатар хотын 53-р сургуульд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварын дэгдэлтэнд нөлөөлсөн хүчин зүйлийг судалж, зөвлөмж боловсруулах.

**Материал арга зүй:** Өвчлөгсдийн тархвар судалалын судалгааны хуудас (66), эрүүл зүйн болон нян судалалын лабораторийн шинжилгээний дүнэ Когорт судалгааны аргаар эргэмж судалгааг хийж Microsoft Excel программыг ашиглан боловсруулах хийв.

**Үр дүн:** Тус сургуулийн 1-5-р ангийн 26 бүлгийн 881 хүүхдээс "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд "Мон сүү" ХХК-нд үйлдвэрлэсэн зөгийн балтай сүү, хорхой ааруулыг идсэн нь 66 хүүхдүүдээс бөөлжих, суулгах, гэдэс нь өвдөх, халуурах шинж тэмдэг илэрчээ.

Дээрхи хүүхдүүдийн гэрээр тархвар судалалын асуумж судалгаа, халдвартын эмчийн үзлэг хийж, нян судалалын шинжилгээнд шулуун гэдэсний арчдас авснаас 30 хүүхдэд эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн ба 13 (1 хүүхэд эрчимт эмчилгээний тасаг) нь халдвартын эмнэлэгт хэвтэж, 17 хүүхдэд халдвартын эмчийн зөвлөгөө өгч, өрхийн эмчийн хяналтанд гэрээр эмчилсэн байна.

Өвчилсөн 30 хүүхдүүдээс 6 настай 43%, 7 нас 37%, 8 нас 7%, 9 нас 3%, 11 нас 3%, 12 нас 7% -ийг тус тус эзэлж, үүнээс эрэгтэй 8 (26,6%), эмэгтэй 22(73,4%) өвдэжээ.

Өвчлөгсдийн 96.0%-д нь суулгах, 76.0%-д нь гэдэээр базалж өвдөх, 60.0%-д нь дотор муухайрах, 40.0%-д нь халуурах, толгой өвдөх, 32.0%-д нь бөөлжих, чичрэх, бие суурлах, 16%-д нь ам цангах, 12%-д нь гэдэс дүүрэх, нүд бүрэлзэх, хоолона дургүй, аюулхай орчимд өвдөх, 8%-д нь царай цайх, тэнцвэрээ алдах, 4%-д нь гар хөл гүйвах, ханиалгах, хөлрөх зэрэг шинж тэмдгүүд илэрчээ.

Дээрхи шинж тэмдэгүүд 72.0%-д нь 30 минутаас 1 цагийн дотор, 28.0%-д нь 1 цагаас дээш хугацаанд шинж тэмдэг илэрсэн байна.

Лабораторийн шинжилгээний хариунд ХӨСҮТ-ийн нян судалалын лабораторид 66 хүүхдийн 99 удаагийн сорьзонд шинжилгээ хийснээс 11 хүүхдийн шулуун гэдэсний арчдасанд "Citrobacter freundii" илэрсэн бол Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын "Эрүүл зүйн лаборатори"-д "Мон-сүү" ХХК-ны сүү, хорхой аарууланд хийсэн шинжилгээгээр сүүнд Citrobacter freundii, E.Coli илэрсэн байна.

### **Дүгнэлт**

1. "Мон сүү" ХХК-ны хүнсний бүтээгдэхүүн

сүү, хорхой ааруул өвчлөлд хэрхэн нөлөөлсөн хамаарлыг эргэмж Когортын судалгаагаар тооцоход: сүү: өртөлтийн түвшин: OR =2,2; харьцангуй эрсдэл: RR=1.6; Хорхой ааруул: OR = 0,75; RR =0,7 Тайлбар: Тухайн өдөр уусан сүүний ялааны харьцаа (OR), харьцангуй риск (RR) нь 1-ээс дээш байгаа нь өвчлөлд хамааралтай буюу эрсдэлт хүчин зүйл байх өндөр магадлалтай ба сүү уусан хүүхдүүдийн хоолны хорлогод орох эрсдэл сүү хэрэглээгүй хүүхдүүдтэй харьцуулахад 1.6 дахин их буюу 60 хувиар их байна.

2. “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн сүү нь гашуун, исгэлэн, амттай, өвөрмөц хурц үнэртэй, савлагсан сүүний таг нь овойсон хэзээ, хаана, хэн үйлдвэрлэсэн, үйлдвэрлэгчийн хаяг, байршил нь тодорхойгүй, бүтээгдэхүүний шошго (хаяг) нь хүнсний бүтээгдэхүүний шошгоны стандартын шаардлага хангагүй байна.

## Мал аж ахуйн мэргэжилтнүүдийн дунд хийсэн бруцеллёзын судалгааны дүн

С. Бүжинлхам, Ц.Сэлэнгэ, Ж.Батсаа, Д.Гомбожав, Ц.Даариймаа, П.Энхцэцэг

Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

Хүний бруцеллөз өвчин нь нас баралт багатай ч архагших хандлагатай, хувь хүн болон эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг төдийгүй нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг байсаар байна. Манай улс нь хүний бруцеллёзын өвчлөлөөр дэлхийд 2 дугаарт орж, жил тутамд хүний бруцеллөз өвчиний 300-500 шинэ тохиолдол бүртгэгддэг. Өвчтэй мал, амьтантай шууд харьцаж, бруцеллээр халдвартлагдсан орчинд ажил, хөдөлмөр эрхэлдэг малын эмч, мал аж ахуйн мэргэжилтнүүд, малчид болон фермерийн аж ахуй эрхлэгчид бруцеллёзын халдварт өртөх өндөр эрсдэлтэй байна. Иймд манай улсын мал эмнэлгийн салбарт ажиллаж буй малын эмч, мал аж ахуйн мэргэжилтнүүдийн дундах бруцеллөз өвчиний халдварталтын түвшинг тогтоох нь чухлаар тавигдаж байна.

**Зорилго:** Монгол улсын малын эмч, мал аж ахуйн мэргэжилтнүүдийн дундах бруцеллөз өвчиний халдварталтын түвшинг тогтоох

**Материал, арга зүй:** 2009-2010 онд малын эмч, мал аж ахуйн мэргэжилтнүүдийн дунд бруцеллөз өвчиний халдварталтын түвшин тогтоох судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хот, Мал эмнэлгийн хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Нийслэл, улсын мал эмнэлгийн газрын малын

эмч, мал аж ахуйн мэргэжилтэн нийт 642 хүнийг хамруулсан. Судалгаанд хамрагдгасдаас стандарт аргачлалын дагуу вакуумтейнерын иж бүрдэл ашиглан шус авч ийлдсийг яланг ХӨСҮТ-ийн Бруцеллэзын ийлдэс судалалын лабораториид Энэтхэг улсын “Тулип диагностик” пүүст үйлдвэрлэсэн Br.abortus, Br.melitensis, Розе бенгалын оношлуураар тавиур болон хуруу шилний тунадасжих урвал, бруцеллын эсрэг иммуноглобулин G илрүүлэх шинжилгээг Франц улсын “Нова Лиза” пүүсийн оношлогооны цомог ашиглан үйлдвэрлэгчийн зааврын дагуу фермент холбоот урвалаар хийсэн.

### Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан нийт малын эмч, мал аж ахуйн мэргэжилтний дундах бруцеллэзын халдварталтын түвшин өндөр байна. Нас, хүйсээр авч үзвэл 55,9% эмэгтэйчүүд, 44,1%-ийг эрэгтэйчүүд эзэлж, 20-30 нас 11,6% (75), 30-40 нас 18,8% (121), 40-50 нас 36,6% (235), 50 ба түүнээс дээш насанд 32,8% (211) байна.

2. Бруцеллэзын халдварталт Баян-Өлгий аймгийн малын эмч, мэргэжилтнүүдийн дунд 30,5%, Баянхонгор 56%, Завхан 59,4%, Ховд 31,3%, Увс 42,3% байна.

3. Нийт судалгаанд хамрагдсан малын З. эмч, мэргэжилтэний 35,7% нь бруцеллэзын халдварталттай байна.

## Бруцеллөз өвчиний тархалтыг тогтоох судалгаа

Ц.Сэлэнгэ<sup>1</sup>, Ц.Нарангарав<sup>1</sup>, Б.Золзаяа<sup>2</sup>, Д.Ганцэцэг<sup>3</sup>,  
Д.Эрдэнэчимэг<sup>4</sup>, Ж.Батсаа<sup>1</sup>, С.Бүжинлхам<sup>1</sup>,  
Д.Даваалхам<sup>5</sup>, Феликс Рот<sup>6</sup>, Эстер Шеллинг<sup>6</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>2</sup> Швейцарийн Хөгжлийн Агентлагийн Мал аж ахуйн төсөл, <sup>3</sup> Улсын Мал Эмнэлгийн Ариун Цэврийн Лаборатори

<sup>4</sup> Мал Эмнэлгийн Хүрээлэн, <sup>5</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

<sup>6</sup>Швейцарийн Тропик Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Монгол улсад хүний бруцеллөз өвчинийг 1949 оноос бүртгэж эхэлсэн. Манай улс 1964-1969 онуудад бруцеллөз өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимтэй зохион байгуулсны дунд хүний бруцеллёзын өвчлөл 4 дахин буурсан. 1970-1980 онуудад Монгол улсад малыг нийтээр вакцинжуулах, халдварт авсан малыг хэрэгцээлэх, хүн, малын дунд бруцеллөз өвчинийг илрүүлэх үзлэг, шинжилгээ хийх, эрүүлжүүлэх ажлыг сайн зохион байгуулж, 1989 он

гэхэд 10,000 хүн ам тутамд ногдох хүний бруцеллёзын өвчлөл 0,01 болтоо буурсан. Гэвч 1990 оноос хойш мал хувьчлагдан, малыг бруцеллёзын шинжилгээнд хамруулах, вакцинжуулах, халдварт авсан малыг хэрэгшээлэх ажилд бэрхшээл учирсан нь хүн, малын бруцеллёзын өвчлөл нэмэгдэх шалтгаан болсон (Энхбаатар.Л, бусад, 2004).

Манай улсад сүүлийн 10 жилийн байдлаар хүний бруцеллөз өвчнөөр жилд 300-500 хүн шинээр өвчиж, өвчлөгсийн 53%-ийг малчид эзэлж, 66% нь эмэгтэйчүүд байна (Батсаа.Ж, бусад, 2009). Монгол улсад хүний бруцеллөз өвчнийг мэдээлэгдэхгүй байгаа тохиолдлын тоо нэн өндөр ба 1:40 байна (Рот Феликс, 2006). Иймд хүн, малын дундах бруцеллөз өвчний бодит тархалт, өвчлөлд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлах зайлшгүй шаардлага тулгарч байна.

**Зорилго:** Хүн, мал, амьтны дундах бруцеллөз өвчний тархалт, малаас хүнд халдварт дамжихад нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлсийг судлах

**Материал, арга зүй:** Сүхбаатар аймгийн Дарьганга, Сүхбаатар, Түвшинширээ, Халзан зэрэг 4 сумын 8 багийн 83 хот айлын нийт 318 малчид, тэдгээрийн гэр бүлийнхнийг энгийн санамсаргүй аргаар сонгон, судалгаанд оролцох талаар таниулах зөвшөөрөл авч, хот айл, мал, хувь хүнээс авах 50 асуулт бүхий 3 төрлийн асуумжаар нүүр тулж харилсан ярилцах байдлаар судалгаа авсан. Судалгаанд хамрагдагсдаас стандарт аргачлалын дагуу вакуумтейнерын иж бүрдэл ашиглан цус авч, ийлдсийг хурилдуурдан ялан, зөөврийн хөргүүрт тээвэрлэн ирж, ХӨСҮТ-ийн Бруцеллёзын ийлдэс судалын лабораториод Энэтхэг улсын "Тулип диагностик" пүүст үйлдвэрлэсэн Розеベンгалын оношлуураар тавиур шилний тунадасжих урвал тавьж, уг урвалаар зэрэг гарсан ийлдсүүдэд шингэрүүлсэн Розеベンгалын урвалаар шинжилгээг давтан хийсэн. Мөн нийт ийлдсэнд бруцеллын эсрэг иммуноглобулин G илрүүлэх шинжилгээг АНУ-ын "Диагностик автомешн" пүүсийн оношлогооны цомог ашиглан үйлдвэрлэгчийн зааврын дагуу шууд бус фермент холбоот урвалаар шинжилсэн. Стандарт болон шингэрүүлсэн Розеベンгалын урвалаар зэрэг, бруцеллын эсрэг иммуноглобулин G илрүүлэх шинжилгээгээр сөрөг гарсан нийт 20 ийлдсэнд Франц улсын "Nova Liza" пүүсийн оношлогооны цомгийг ашиглан бруцеллын эсрэг иммуноглобулин M илрүүлэх шинжилгээг фермент холбоот урвалаар хийсэн. Судалгаанаа 260 (81,8%) малчин, 58 (18,2%) тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулсаны 50,6% (161) эрэгтэй, 49,4% (157) нь эмэгтэй байна. Дээрх 4 сумаас 1682 хонь, 1671 ямаа, 359 үхэр, 118 тэмээ, 228 адуй, 65 гэрийн тэжээмэл нохой нийт 4123 толгой мал, амьтныг санамсаргүйгээр сонгон авч ийлдэс судалын шинжилгээнд хамруулж, халдварталтын

түвшинг тогтоосон. Судалгааны мэдээллийг Аксесс-2007 программ дээр давхар оруулж, Эпи-Инфо программ дээр ялгааг шалган, Стата 10.1 программ дээр боловсруулалт хийсэн. Өвчлөлд нөлөөлж буй хүчин зүйлийг хи квадрат, фишерс экзаст тестээр тооцсон.

### **Дүгнэлт**

1. Малчид тэдгээрийн гэр бүлийнхний дунд хүний бруцеллёзын тархалтыг 95%-ийн итгэх хязгаарт тооцож үзэхэд 28,6% байна (95% CI 23.9-33.8).
2. Ийлдэс судалын шинжилгээгээр ээрэг гарсан 91 хүнд судалгаа хийхэд нуруу өвдөх ( $p=0.004$ ), ядрах ( $p=0.006$ ) зэрэг эмнэл зүйн шинж тэмдгүүд илрэх нь бруцеллөз өвчний үед зонхилон тохиолдож байна.
3. Бог малын шүүрхий элэг идэх нь бруцеллёзын халдварт өртөхөд нөлөөлж байна ( $p=0.027$ ).
4. 45 бат түүнээс дээш насны малчид бруцеллёзын халдварт илүүтэй өртөж байна ( $p=0.001$ ).

## **ХДХВ/БЗДХ-ын харуулдан тандалтын судалгаа 2009**

**Б.Оюунбилиг<sup>1</sup>, Э.Долгион<sup>1</sup>, Ч.Байгалмаа<sup>1</sup>, Ч.Бямбаа<sup>2</sup>**

<sup>1</sup> Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>2</sup> Глобаль сан

ХДХВ-ийн халдварт нь дэлхийд хурдаштай тархаж буй улс орнуудын нийгэм, эдийн засагт ихээхэн хор хохирол учруулж байна. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хийсэн тооцоололтоор дэлхий дахина 33.4 сая хүн ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа бөгөөд жил бүр 2.7 сая хүн шинээр халдварт авч, 2 сая хүн ДОХ-ын улмаас нас барж байна. Монгол улсад 2010 оны 10 сарын 15-ны байдлаар ХДХВ/ДОХ-ын 83 тохиолдол бүртгэгдсэнээс 22 хүн ДОХ-ын шатандаа шилжиж ретровирусийн эсрэг эмчилгээ (РВЭЭ) хийлгэж байна. НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр болон ДЭМБ-ын хийсэн тооцоололтоор 2010 онд Монгол улсад < 500 хүн ХДХВ-ийн халдвартай байна. ХДХВ-ийн халварын тархалтыг харуулдан тандах судалгаа нь ХДХВ-ийн халварын тархалтыг хянах, зорилтот үйл ажиллагааг төлөвлөх, үнэлэхэд шаардлагатай тархварзүйн мэдээний эх сурвалж болдог.

**Зорилго:** ХДХВ/БЗДХ-ын харуулдан тандалтын судалгааг хүн амын тодорхой бүлгийн дундах ХДХВ, БЗДХ-ын тархалтыг тогтоох, халдварт өртөх эрсдэлтэй зан үйлийг тодорхойлох.

**Материал, арга зүй:** Уг судалгааг нэг агшны арга ашиглан хийв. Судалгааны хүн амыг Улаанбаатар хот, 21 аймгаас энгийн санамсаргүй түүвэрлэлтээр сонгон авав.

Энэ удаагийн харуулдан тандалтын судалгаагаар

ХДХВ, тэмбүүгийн халдварт илрүүлэх ийлдэс судаллын тандалт судалгаа (ИСС), БЗДХ-ыг илрүүлэх молекул биологийн судалгаа (МБС), Зан үйлийн тандалт судалгааг (ЗҮС) хийв. ИСС болон МБС-нд судалгаанд хамрагдсан хүн амаас цус, үтрээ болон умайн хүзүүний сувгаас сорыц цуглуулж ХДХВ, тэмбүү, заг хүйтэн, хламид, трихомониазийн халдварт илрүүлэх шинжилгээ хийв. ЗҮС-нд тусгайллан боловсруулсан асуумж, яриллагаар хэлбэрээр мэдээллийг цуглуулав.

ХДХВ, тэмбүүгийн халдварт илрүүлэх ийлдэс судаллын шинжилгээнд эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ) 858, эрэгтэйтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэй (ЭБЭ) 167, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгч 2141, хөдөлгөөнт эрэгтэй 829, жирэмсэн эмэгтэй 409, цусны донор 400, сүрьеэтэй 143 өвчтөнийг хамруулав.

**Үр дүн:** ХДХВ-ийн халдварт ЭБҮ, хөдөлгөөнт эрэгтэйчүүд, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчид, жирэмсэн эмэгтэйчүүд, цусны донор, сүрьеэтэй өвчтөнүүдийн дунд 0%, ЭБЭ-ийн дунд 1.8%-тай илэрсэн. Тэмбүүгийн халдварт ЭБҮ-ийн дунд 18.3%, хөдөлгөөнт эрэгтэйчүүдийн дунд 1.7%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчдийн дунд 6.9%, ЭБЭ-ийн дунд 5.4%, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 1.7%, цусны доноруудын дунд 1.5%-тай байв. Заг хүйтэн, трихомониаз, хламидийн халдварт илрүүлэх полимеразын гинжин урвалын шинжилгээнд 257 ЭБҮ-ийг хамруулснаас хламидын халдвартархалт 25.5%, трихомониазын халдварт 14.8%, заг хүйтний халдварт 15.6%-тай байна.

Зан үйлийн тандалт судалгааг ЭБҮ 722, ЭБЭ 209, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчид 2172, хөдөлгөөнт эрэгтэйчүүд 939 болон 15-24 насын гэр бүлгүй 2068 залуучуудын дунд явуулав.

ХДХВ-ийн халдварт, бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүмүүсийн эзлэх хувь ЭБҮ-ийн дунд 50.4%, ЭБЭ-ийн дунд 56.3%, хөдөлгөөнт эрэгтэйчүүдийн дунд 24%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчдийн дунд 29.6%, 15-24 насын залуучуудын дунд 20.3%-тай байсан.

ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан хувь ЭБҮ-ийн дунд 74%, ЭБЭ-ийн дунд 78.6%, хөдөлгөөнт эрэгтэйчүүдийн дунд 27%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчдийн дунд 31.5%, 15-24 насын залуучуудын дунд 11.7%-тай байв.

#### Дүгнэлт:

1. ЭБЭ-ийн дунд ХДХВ-ийн халдвартархалт 1.8%-тай байгаа нь өмнөх онуудын ХТС-тай харьцуулахад ХДХВ-ийн халдвартархалт нэмэгдэх хандлагатай байна.

2. ЭБҮ-ийн дунд тэмбүүгийн халдвартархалт

бусад судалгаанд хамрагдсан бүлэгтэй харьцуулахад хамгийн өндөр, өмнөх онуудтай харьцуулахад түүштэй буурахгүй байна.

3. 15-24 насын залуучуудын ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан байдал болон ХДХВ/ДОХ-ын талаар шогц, зөв мэдлэгийн түвшин өмнөх онуудтай харьцуулахад буурсан, судалгаанд хамрагдсан бусад бүлэгтэй харьцуулахад доогуур байна.

4. Иймд цаашид эрсдэлт бүлгийн хүн ам тэр дундаа ЭБҮ, ЭБЭ болон залуучуудын дунд ХДХВ-ийн халдвараас сэргийлэх, БЗДХ-ийг чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үлажиллагааны хүрээг өргөжүүлж эрчимжүүлэх шаардлагатай байна.

## Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дундах ХДХВ, тэмбүү, хепатит В, С вирусийн халдвартын тархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийн судалгааны дүн

Г.Эрдэнэтүяа<sup>1</sup>, Д.Наранзул<sup>1</sup>, Б.Цогтбаатарт<sup>2</sup>,  
Ч.Эрдэнэчимэг<sup>1</sup>, Д.Даваалхам<sup>3</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв,

<sup>2</sup> Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэтэй  
тэмцэх төсөл,

<sup>3</sup> Эрүүл Мэнд Шинжлэх Ухааны Их Сургууль

Манай улсалд ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2010 оны 3 сарын байдлаар 64 тохиолдол бүртгэгдэж, 9 хүн нас барсан байна. ХДХВ/ДОХ-тай бүртгэгдсэн хүмүүсийн 75.0% эрэгтэйчүүд байна. Үүний 84.0% нь эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүд байна.

**Зорилго:** Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, хепатитын В, С вирусийн халдвартархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийг тогтоох зорилгоор дараахъ зорилтуудыг шийдвэрлэв:

1. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, хепатитын В, С вирусийн халдварт ийлдэс судаллын аргаар тогтоох

2. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд хепатитын В, С вирусийн халдвартархалтын зарим эрсдэлт хүчин зүйлийг судлах

**Материал, арга зүй:** Улаанбаатар хотод амьдарч буй эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, хепатитын В, С вирусийн халдвартархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийг тогтоох судалгааг нэг агшингийн загвараар хийж

гүйцэтгэв. Шинжилгээг БНСҮ-ын Standart Diagnostics, INC-д үйлдвэрлэсэн өвөрмөц болон мэдрэг чанар 99%-тай SD Bioline хурдавчилсан оношлуураар хийж гүйцэтгэв. Судалгааг 2010 оны 4 дүгээр сараас 8 дугаар сарын 1-ийг хүртэл 4 сарын хугацаанд Улаанбаатар хотын 9 дүүргэгт амьдарч буй 16-50 насны эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 180 эрчүүдийг хамруулан хийв.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д хепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg эерэг, 15%(27)-HCV эерэг, 13,3% (24) ХДХВ-ийн халдварт, 14%(25)-д нь тэмбүүгийн халдварт тус тус илэрсэн. ХДХВ-ийн халдварт илэрсэн эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 3% нь шинэ халдварт, 10% нь өмнө нь ХДХВ-ийн халдварт оношлогдож одоо хяналтанд байгаа хүмүүс хамрагдсан. Энэхүү судалгааны ажлын явцад ХДХВ-ийн халдвартын 6 шинэ тохиолдлыг эрт илрүүлэн хяналтанд авсан нь хувь хүнд төдийгүй нийгэм, хамт олны эрүүл мэндэд ихээхэн ач холбогдолтой, цаг үеэ олсон судалгаа болохыг харуулж байна. ХДХВ-ийн халдварт илэрсэн ЭБЭ нь 20-45 насны залуучууд байгаа бөгөөд шинээр ХДХВ-ийн халдвартай болох нь оношлогдсон 6 хүн нь 20-42 насны эрчүүд байна. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д хепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg эерэг, 15%(27)-HCV эерэг, 8%-хепатитын В, С вирусийн хавсарсан халдварт илэрсэн. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д тэмбүүгийн халдварт илэрсэн байна. Үүний 4%(8) шинэ, 10%(17) нь өмнө нь тэмбүүгийн халдварт авсан нь оношлогдож хяналтанд байгаа хүмүүс хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан эрчүүдийн 8%-д ХДХВ, тэмбүүгийн хавсарсан халдварт оношлогдсон байна.

#### Дүгнэлт

1. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 13,3%-д ХДХВ-ийн халдварт илэрч үүний 3% нь шинэ халдварт байгаа нь ЭБЭ олон нийтийн дунд ХДХВ-ийн халдварт үргэлжлэн тархсаар байгааг харуулж байна.

2. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 14%-д хепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg эерэг, 15%-д HCV эерэг, 8%-д нь хепатитын В, С вирусийн хавсарсан халдварт илэрсэн нь хепатитын вирусийн халдварталт өндөр байгааг нотолж байна.

3. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 14%-д тэмбүүгийн халдварт илэрч, 8%-д ХДХВ, тэмбүүгийн хавсарсан халдварт оношлогдсон нь ЭБЭ олон нийтийн дунд БЗДХ өндөр байгааг харуулах үзүүлэлт юм.

## Монгол хүүхдүүдийн дундах Кавасакийн өвчиний эргэмж судалгаа

Д.Байгалмаа<sup>1</sup>, Б.Отгончимэг<sup>2</sup>, Д.Даваалхам<sup>3</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв,

<sup>2</sup> Эх Нялхасын Эрдэм Шинжилгээний Төв

<sup>3</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуул

Кавасакийн өвчиний (КӨ) анх 1967 онд Японы хүүхдийн эмч, эрдэмтэн Томисаку Кавасаки илрүүлсэн бөгөөд эдүгээ дэлхий даяар уг өвчиний шинэ тохиолдлууд бүртгэгдэх болжээ. КӨ нь зүрхний титэм судсыг гэмтээх аюултай ба өндөр хөгжилтэй орнуудын хүүхдийн зүрх судасны олдмол гажгийн тэргүүлэх шалтгаан болоод байна.

КӨ нь өндөр халуурах, уруул ба амны хөндийн салст улайх, мөчдөл өөрчлөлт гарах, арьсан дээгүүр янз бүрийн хэлбэр бүхий тууралт гарах, тунгалагийн булчирхай томрох шинжүүдээр илэрдэг. Эрт үед нь оношлож, тохирсон эмчилгээг хийгээгүйн улмаас өвчлөгсдийн 20-25% нь зүрхний титэм судасны цүлхэн, өргөсөлөөр хүндэрч, улмаар зүрхний шигдээс, цус тасалдал өвчинөөр нас барахад хүрдэг.

Нийт өвчтэй хүмүүсийн 85% нь 5 хүртэлх насны хүүхдүүд байдаг ба өвөл, хаврын цагт өвчлөл оргил үедээ хүрдэг ажээ. КӨ-ний тохиолдол Америк, Европ, Ази тивийн 60 гаруй оронд бүртгэгдэж, 10 гаруй оронд энэ өвчиний дэгдэлт гарсан. Өнөө үед дэлхийд жил бүр 100,000 хүн амд 3,4-186,0 шинэ тохиолдол бүртгэгдэж байна.

Манай хөрш зэргэлдээ улсууд болох Оросын Холбооны Улсад 100,000 хүн амд 18,2, Хятад улсад 30,2 КӨ-ний шинэ тохиолдол гарч байна.

Гэтэл манай улсын хувьд өнөөг хүртэл КӨ-ний талаар мэдээлэл байхгүй, энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй бөгөөд КӨ-ний талаарх эмч нарын мэдлэг хангалтгүй байгаагаас буруу оношлох, тохирсон эмчилгээ хийгдэхгүй байх, улмаар өвчин хүндэрч, нас баралтанд хүргэх зэрэг асуудлууд тулгамдаж байна.

**Зорилго:** Улсын хэмжээнд Монгол хүүхдийн дундах КӨ-ний тохиолдлыг илрүүлэн судлах.

**Материал, арга зүй:** Бид судалгаандаа Монгол улсын 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл, ЭНЭШТ-ийн зүрх судас, хүүхдийн тасгууд, ХӨСҮТ-ийн амьсгалын замын халдвартын тасгуудад 1996-2008 оны хооронд хэвтэж эмчлэгдсэн 0-16 настай 241705 хүүхдүүдийн өвчиний түүхэнд эргэмж судалгааг хийж, Японы Кавасакийн Өвчин Судаллын Төвөөс боловсруулсан Кавасакийн өвчиний оношлогооны удирдамжийг ашиглан КӨ-ний тохиолдлыг илрүүллээ.

**Үр дүн:** Нийт 241705 өвчтний түүхэнд судалгаа хийж, Кавасакийн өвчний 9 тохиолдлыг илрүүлсэн ба КӨ-тэй хүүхдүүдийн насыг авч үзэхэд 1 нас 4 сартайгаас 14 насны хооронд хэлбэлзэж, дийлэнх нь (77,8%) нь эрэгтэй хүүхдүүд байлаа. КӨ-ний 6 (67%) тохиолдолд үндсэн 6 шинжүүд бүгд илэрсэн ба бусад тохиолдуудад 4 ба 5 шинжүүд илэрчээ. Халуурах, нүдний салст улайх, уруул амны хөндийд өөрчлөлт гарах шинжүүд нь хамгийн элбэг тохиолдож байсан бол хүзүүний тунгалгийн булчирхай томрох шинж нь харьцангуй цөөн илэрсэн байв. Зүрхний эхокардиографийн шинжилгээ хийлгэсэн 5 хүүхдэд бүгд зүрхний талаас хүндрэл гарч, зүрхний титэм судасны өргөсөл, цүлхэн үүссэн байна.

**Дүгнэлт:** КӨ-ний тохиолдлыг илрүүлэх үндэсний судалгаагаар КӨ-тэй хүүхэд Монгол Улсад байдаг болох нь тогтоогдоо. Иймд цаашид КӨ-ний үндэсний судалгааг үргэлжлүүлж, тохиолдуудыг бүртгэж мэдээлдэг, шалтгааныг нь тогтоох шаардлагатай байна.

## Нийслэлийн Хан-Үул дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг үнэлсэн судалгаа

Ж. Баярсайхан<sup>1</sup>, Ч. Бямбасүрэн<sup>2</sup>, Д.Өлзиймаа<sup>1</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Улсын Клиникийн Төв Эмнэлэг

Өсвөр үеийнхний “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн талаарх мэдлэг хандлагыг тогтоох, гэр бүл төлөвлөлт болон, бэлгий харьцаа, жирэмслэлтээс сэргийлэх аргын мэдлэг тогтоох зорилгоор олон улсын болон Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн төслийн үр дүнг төсөлхөрөгжсэн болон төсөлхөрөгжээгүй газрын хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлагын түвшинг тогтоох замаар үнэлэв. Үг судалгааг системчилсэн түүврийн аргаар ХҮД-ын өрөнхий боловсролын сургуулиудын НҮЭМ-н төсөлд хамрагдсан болон төсөлд хамрагдаагүй 15, 52, 7-р сургуулийн нийт 102 хүүхдээс системчилсэн түүврийн аргаар судалгааг авч, шуглуулсан мэдээ баримтаа Microsoft Excel, Microsoft Word программуудыг ашиглан боловсруулалт хийв.

Судалгааны ажлын таамаглал

Н0: НҮЭМ-ийн төсөл сургалтанд хамрагдсан эсэхээс үл хамаарч судалгаанд хамрагдсан ХҮД-ийн арван нэгэн жилийн гурван сургуулийн 14-17 насны сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин ижил байна.

H1: НҮЭМ-н төсөл сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялаатай байна.

**Үр дүн:** НҮЭМ-тэй холбоотой мэдээлэл хангалтгүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 38.1%, төсөлд хамрагдаагүй сурагчдын 26.6% нь тус тус үзэж, тэдний 11.5% нь илүү ихээр мэдээлэл шаардлагатай байна гэж хариулжээ. Төсөлд хамрагдсан сурагчдын 56.3% нь хамрагдаагүй сурагчдын 65.9% нь хэвлэлээс мэдээлэл олж авдаг гэсэн бол НҮЭМ-ийн талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцаггүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 53.7% нь төсөлд хамрагдаагүй сурагчдын 55.5% нь тус тус хариулсан нь төсөлд хамрагдсан сурагчдын 1.8% нь гэр бүлийнхэнтэйгээ бага ярилцдаг ажээ. БЗХӨ-ний талаар зохих хэмжээний ойлголттой гэж төсөлд хамрагдсан сурагчдын 87.5% нь, хамрагдаагүй сурагчдын 75% нь хариулсан нь төсөлд хамрагдсан сургачдын мэдлэг хамрагдаагүй сургачдаас 12.5%-иар илүү байгааг харуулж байна. БЗХӨ авсан байж болзошгүй гэж үзвэл хамгийн түрүүнд эмнэлэгт хандана гэж төсөлд хамрагдсан сургуулын сурагчдын 38.1% нь төсөлд хамрагдаагүй сургуулын сурагчдын 35.1% нь эмнэлэгт хандана гэж хариулсан нь төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургуулийн сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэг хандлага ялаатай байгааг харуулж байна.

**Дүгнэлт:** H1 таамаглал буюу НҮЭМ-н төсөл сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялаатай байна.

## HBsAg илэрсэн Монгол хүүхдүүдийн цочмог А вирусийн халдварын эмнэлзүйн онцлог

Ж.Улаан<sup>1</sup>. Я.Давгадорж<sup>2</sup>, Д. Чимэдноров<sup>1</sup>, Б.Батсүх<sup>1</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Монгол улсад В вируст хепатит нь нутагшмал халдварт. Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 1991 оноос В вируст хепатитын вакцинаар шинээр төрсөн хүүхдүүдийг дархлаажуулж эхэлсний дүнд цочмог вируст хепатитын өвчлөл, элэгний дутагдлын улмаас нас барах нь эрс буурсан. Гэвч практикт цочмог А болон В вируст хепатитын хавсарсан хэлбэрийн өвчлөл бүрэн зогсоогүй байна.

**Зорилго:** HBsAg илэрсэн хүүхдүүдээд цочмог А вирусийн халдварын эмнэлзүйг судлах

**Үр дүн:** 1-р бүлгийн хүүхдүүдээд хүнд хэлбэр 7.8%, хүндэвтэр хэлбэр 23,5%, 2-р бүлэгт хүнд хэлбэр 50%,

хүндэвтэр хэлбэр 12,5%, харин 3-р бүлэгт нэн хүнда хэлбэр 25%, хүнд хэлбэр 15% байсан. Нэн хүнда хэлбэрийн тохиолдол нь зөвхөн цочмог В вирусийн халдвартай байсан. Эмнэлзүйн шинж тэмдэгийн

	HBsAg(+), anti-HAV(+), anti-HBcIgM(-)	HBsAg(+), anti-HAV-IgM(+),anti-HBcIgM(+)	HBsAg(+), anti-HAV-IgM(-),anti-HBcIgM(+)
Хордлого ургажилсан хугацаа	4 өдөр	6 өдөр	7 өдөр
Шарлалт үргэлжилсан хугацаа	7 өдөр	11 өдөр	12 өдөр
АЛАТ хэвийн болсон	20.2 өдөр	24.6 өдөр	33.4 өдөр

явшыг бүлгүүдээс нь хамааруулан хүснэгтэнд үзүүлэв

**Дүгнэлт:** HBsAg илэрсэн хүүхдүүдэд цочмог А вирусийн халдвартын шарлалттай хэлбэр нь цочмог А вируст хепатитын адил хөнгөн хэлбэрээр явагдаж байна.

## **Халдвартай хэлбэрийн сүрьеэгийн өвчлөлийн судалгаа**

*П. Нямхишиг, Х. Одсүрэн, Д.Долгормаа, Х.*

*Давааням, М. Нансалмаа*

*Халдварт Өвчин Судалалын Үндэсний Төв*

Монгол улсад жилд 10000 хүн амд тутамд 217 хүн сүрьеэ өвчнооэр шинээр өвчилж байна. Хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор халдвартай хэлбэрийн сүрьеэ, олон эмийн дасалтай сүрьеэ (ОЭДС)—ийн өвчлөл нэмэгдэж байгаа нь сэтгэл эмзэглүүлсэн асуудал болж байна. Сүүлийн 3 жилд нийт 731 хүүхэд хэвтэн эмчлүүлснээс 19.2% (140) хүүхэд XTH+/+ сүрьеэгээр өвчилсөн байна.

**Зорилго:** Хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн дундах хүчилд тэсвэртэй нян эерэг (XTH+/+) сүрьеэ, ОЭДС-н өвчлөл, цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян эерэгээс сөрөгт шилжих хувь, ОЭДС-р өвчилсөн хувийг тодорхойлох, өвчлөлд нөлөөлж буй зарим шалтгааныг судлах.

**Материал, арга зүй:** 2005-2007 онд XHCYT-ийн хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн бүртгэлд эргэмж судалгааг хийв.

**Үр дүн:** Хүүхдийн сүрьеэгийн тасагт 2005 онд 255 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 16.5%(42), 2006 онд 218 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 19.7% (43), 2007 онд 258 хүүхэд хэвтэж эмчлүүлсний 21.3% (55) нь тус тус XTH+/+ сүрьеэгээр өвчилсөн байв. Эмчлүүлэгчдийг насны бүлгээр үзэхэд 0-5 насныхан 19.6% (143), 6-10 нас -18.3%, (136), 11-15 нас-46.6% (343), 16-18 насныхан 15.5% (114)-ийг тус тус өзүүлж байна.

XTH+/+ сүрьеэгээр өвчлөгсөдийн дотор 0-5 насныхан 0%, 6-10 насныхан 7.8% (80), 11-15 насныхан 52.1%(73), 16-18 насныхан 31.4%(51) байна. XTH+/+ сүрьеэгээр өвчлөгсөдийг хүйсийн байдлаар авч үзвэл: 2005 онд эмэгтэй 24(57.2%), эрэгтэй 18 (42.8%), 2006 онд эмэгтэй 24(55.8%), эрэгтэй 19 (44.2%), 2007 онд эмэгтэй 31(56.2%), эр 24(45.6%) байна. Хүүхдийн сүрьеэгийн тасагт 2 дахь сардаа хэвтэн эмчлүүлэгсэдийн цэрний түрхэцийн 140 шинжилгээгээр XTH+/+ гарсан тохиолдолийн цэрийг өсгөвөрлөхөд өгөхөд 16 (2006 онд - 4, 2007 онд 12) нь эмийн дасалтай болох нь батлагдсан. Үүнээс 12 хүүхэд ОЭДС-н эмчилгээнд хамрагдаж эдгэрч гарсан ба 4 хүүхэд нас барсан.

### **Дүгнэлт:**

1. Уушгини хэлбэрийн түрхэц зэрэг сүрьеэгээр өвдсөн хүүхдүүдийн цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян эерэгээс сөрөгт шилжих хувь багасч байгаа нь хүүхэд хүндэрсэн үедээ оношлогдож байгаатай холбоотой байна.
2. Уушигны хэлбэрийн түрхэц зэрэг сүрьеэгээр өвдсөн хүүхдүүдийн дотор 11-18 насны эмэгтэй хүүхэд зонхилон өвчиж байна.
3. Хүүхдүүдийн дунда ОЭДС-н өвчлөл нас баралт жил ирэх тусам нэмэгдэж байна.

## **Цээжний хөндийн идээт үрэвсэлийн үүсгэгч, түүний антибиотик мэдрэг чанарыг судалсан нь**

*О.Жавзандулам Х. Эрдэнэцэцэг*

*Э. Сүхээ, Ж. Алтанбагана*

*Халдварт Өвчин Судалалын Үндэсний Төв*

XHCYT-ийн мэс заслын тасагт 2005–2009 оны хооронаа цээжний хөндийн идээт үрэвсэл оноштойгоор нийт 155 эмчлүүлэгч хэвтэж эмчлүүлснээс мэс засал эмчилгээг 102 тохиолдолаа хийсэн байна. Энэ нь сүүлийн 4 жилд хийсэн мэс засал эмчилнгээний 6% -г эзлэж байна. 2005-2009 оны хооронаа цээжний хөндийн идээт үрэвсэлээр өвчилсөн тохиолдолуудын өвчний түүхэнд судалгаа хийж үзэхэд 155 тохиолдолоос 6 (3%) нь нас барсан, 102 (65,8%) нь мэс засал эмчилгээ хийлгэсэн байна. Эдгээр мэс засал хийлгэсэн өвчтөнүүдэд хагалгааны өмнө болон дараа өргөн хүрээний антибиотикуудыг сонгон хэргэлсэн боловч цээжний хөндийн идээнд бактериологи шинжилгээ хийж эмгэг төрүүлэгч нянг илрүүлэгч, эмгэг төрүүлэгч нянгын антибиотик мэдрэг чанарыг үзэж тохирсон антибиотикуудыг сонгон авч хэргэлсэн тохиолдол таарсангүй.

**Зорилго:** Цээжний хөндийн идээт үрэвсэлийн зонхилон үүсгэх эмгэгтөрөгч нян, тэдгээрийн мэдрэг

антибиотикийг судлан тодорхойлж, хагалгааны дараах эмчилгээг боловсронгуй болгох

**Материал, арга зүй:** 2008 - 2009 онд ХӨСҮТ - ийн мэс заслын тасагт цээжний хөндийн идээт үрэвслийн улмаас хэвтэж мэс засал эмчилгээ хийлгэсэн 71 эмчлүүлэгчээс санамсаргүй түүврийн аргаар проспектив судалгаа хийлээ.

Эмнэлэгт хэвтсэн цээжний хөндийн идээт үрэвслэлтэй өвчтнүүдээс таниулсан зөвшөөрөл авсны дагуу судалгаанд хамруулан, хагалгааны үед ариун нөхцөлд цээжний хөндийн идээнээс соруулан ариун шилэнд авч, сорьшийг бактериологи лабораторид идээний үүсгэгчийг тодорхойлуулж, антибиотикт мэдрэг байдлыг Керби Бауэрийн (диски нэвчүүлэх) аргаар бидний өргөн хэрэглэдэг Penicillin, Ampicillin, Ciprofloxacin, Erytromycin, Chloramphenicol, Cefazolin, Vancomycin, Cefataxime, Cotrimaxozole, зэрэг антибиотикийн дискийг сонгон нянгуудад үйлчилсэн диаметрийн хэмжээгээр нь судлав.

**Үр дүн:** Бидний судалгаанд 20-52 насын 71 эмчлүүлэгч хамрагдсаны 46(65,67%) нь 20-37 насын эмчлүүлэгч, 41(58,2%) нь эрэгтэй, 30(41,8%) нь эмэгтэй байв. Нийт 71 эмчлүүлэгчийн 7(9,85%) нь өвчин эхэлсэнээс хойш 14 хоногийн дотор, 64(90,1%) нь 28-аас дээш хоногийн хугацаанд мэс засал эмчилгээнд хамрагджээ.

Цээжний хөндийн идээт үрэвслэлийн нян судаллын шинжилгээнд *Staphylococcus aureus* 22,53%, *Ps. Aureginosa* 11,5%, *C.Pneumonlae* 5,6%, *E.Coli* 48,9%, *Enterococcus* 4,2%, *M.Luteus* 2,8%-ийг эзлэж 5,6%-д нян илгээргүй. Судалгаанд сонгон авсан өргөн хүрээний үйлчилгээтэй түгээмэл хэрэглэгдэг антибиотикуудаас цефазолин (76%), цефатаксим (77,5%) -д нийт нянгийн дийлэнх хамгийн их мэдрэг, гентамицин, хлорамфениколд мэдрэг биш, ванкомицин, эритромицин, котримексазолд дуна зэрэг мэдрэг байв. *E.Coli* нь Cefazolin, Cefataxime, Vancomycin-д -ийн өндөр мэдрэг, Cotrimaxazole, Gentamycin-д дуна зэрэг мэдрэг, Erytromycin, Chloramphenicol-д сүл мэдрэг, Enterobacter болон Staphylococc-оор үүсгэгдсэн үед нянгууд Chloramphenicol, Cefazolin, Vancomycin, Cefataxime-д тус тус мэдрэг байна. Пенициллин, ампициллин (98,25%), амоксациллин (98,24%), эритромишин (87,71%) гэх мэт антибиотикуудад мэдрэг бүс байна.

**Дүгнэлт:** Цээжний хөндийн идээт үрэвслийн үед цефалоспорин, макролидийн бүлгийн антибиотикуудыг эхний ээлжийн антибиотик эмчилгээг болгон сонгох нь эмчилгээний хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзэж байна.

## Олон эмийн дасалтай сүрьеэгийн тасагт эмчлүүлэгчийн сүрьеэгийн эхний эмчилгээний үр дүнг судлах нь

А.Оюунчимэг, Д.Должинсүрэн, Уранчимэг,

Т.Алимаа, Н.Эрдэнэбүлэг

Халдварт өвчин Судаллын Үндэсний Төв

Сүрьеэгийн үүсгэгчийн гол онцлог нь сүрьеэгийн эсрэг эмэнд амархан дасалтай болдог. Үүний гол шалтгаан нь сүрьеэтэй өвчтөн ДОТС хөтөлбөрийн дагуу хяналттайгаар эмийг зөв горимоор, хангалттай тунгаар өдөр бүр тасалгүй ууж чадаагүйгээс хүн өөрөө дасал үүсгэж байна. Ихэнх тохиолдол сүрьеэгийн эмийг зөв горимын дагуу уухад 1 сарын дотор зовиур арилдаг учраас эмээ таслах, мартах, зогсоох тохиолдол байдалг нь эмчилгээ үр дүнгүй болж архагшин, эмийн дасалтай сүрьеэ үүсгэн халдварт ялгаруулсан хэвээр улмаар олон хүнийг Олон эмийн дасалтай сүрьеэ (ОЭДС)-гээр өвдөх аюулыг үүсгэж байна.

ОЭДС-гийн эмчилгээний үргэлжлэх хугацаа урт (18-24 сар), гаж нөлөө ихтэй, өртөг өндөр, эмчилгээний үр дүн 60-70% байдалг ба ОЭДС-тэй 1 хүнийг эмчлэх зардлаар шинэ сүрьеэгийн 60 тохиолдлыг бүрэн эмчлэх боломжтой. Иймд ОЭДС-гээс сэргийлэх хамгийн оновчтой арга нь ДОТС-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд оршино.

**Зорилго:** ОЭДС-гийн тасагт хэвтэн эмчлүүлэгчийн урдах эмчилгээний үр дүнг тооцсоноор дасал үүсэж буй шалтгааныг тогтоох

**Материал, арга зүй:** Судалгааг 2006 оны 6 сараас 2008 он хүртэлх хугацаанд хэвтэн эмчлүүлж байсан 84 эмчлүүлэгчийн хяналтын карт болон өвчтөний түүхэнд эргэмж судалгааг хийж статистик боловсруулалтыг SPSS программаар хийж нэгтгэн дүгнэв.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан эмчлүүлэгчийн 49 (58.3%) эрэгтэй, 35 (41.7%) эмэгтэй байв. Насны хувьд 16-20 хүртэлх насныхан 9 (10.7%), 20-35 нас 45 (58.3%), 35-45 нас 21 (25%), 45-55 нас 7 (8.3%), 60-дээш 2 (2.4%) байна. Урдах эмчилгээний үр дүнг үзэхэд 1-р бүлгийн эмчилгээ дуусгасан 28 (15.5%) үр дүнгүй 49 (58.3%) эмчилгээ тасалсан 7 (8.5%) байв. Судалгаанд хамрагдагсадын 65 (77.4%) нь 2-р бүлгээр эмчилгээнд орсон ба үүнээс 2-р бүлгийн эмчилгээ дуусгасан 13 (15.5%), үр дүнгүй 47 (55.9%) эмчилгээ тасалсан 5 (5.9%) тус тус байна. 2-р бүлгээр эмчилгэдэх явцад эмэнд дасалтай нь тогтоогдсон 18 (21.4%) байв. Судалгаанд хамрагдсан эмчлүүлэгчдээс дур мэдэн эм худалдан авч уусан 1 (1.2%), эм зогсоож тан уусан 2 (2.4%), сүрьеэ нь оношлогасон боловч

Хөх хот, Бээжинд эмчилгээ (1-8 сар) хийлгэсэн 7 (8,3%), хувийн эмнэлэгт эмчилүүлсэн 3 (3,6%) байгаа нь эмийн дасал үүсчэд нөлөөлж байна.

**Дүгнэлт:**

1.ОЭДС-тэй өвчтөний дийлэнх хувьд нь сүрьеэгийн эхний эмчилгээ үр дүнгүй байсан .

2. Эмчилгээ таслах болон эмчилгээний стандарт горим(тан уух, хувийн эмнэлэгт стйндарт бус горимоор эмчлэх, гадаад улсад эмчилүүлэх г.м) мөрдөөгүй нь эмэнд дасал үүсчэд нөлөөлж байгаа нь харагдаж байна.

**Олон эмийн дасалтай сүрьеэтэй  
эмчилүүлэгчдийн тулгамдсан  
асуудлууд**

3.Уранчимэг, Р.Болор, А.Оюунчимэг, Б.Дариймаа  
Халдварт өвчин Судалын Үндэсний Төв

Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөн эмчилүүлэгүй тохиолдолд жилд дунджаар 15-20 хүнд халдварт тараадаг ба улмаар 10% нь буюу 1-2 хүн сүрьеэгээр өвдөх магадлалтай. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүний хавьтлыг халдварт авах эгзэгээр нь 4 хүрээ болгон хуваадаг. Үүнээс халдварт авах хамгийн өндөр эгзэгтэй хүрээний хүмүүст хамт амьдрагсад, эмнэлгийн мэргэжилтэнүүд, ах дүүс, ойрын хамаатан ордог. Нярай буюу бага насны хүүхдэд дархлалын систем сүл байдаг учир халдварт авах эрсдэл өндөр байдал.

**Зорилго:** Олон эмийн дасалтай сүрьеэ (ОЭДС)-гээр өвчилсөн эмчилүүлэгчдийн хавьтлын түвшинг судалж тогтоох

**Материал, арга зүй:** ОЭДС-гийн тасагт 2010 оны 1-р сараас 8-р сар хүртэл хугацаанд хэвтэн эмчилүүлсэн 60 хүнд тусгай судалгааны асуумж бүхий карт, ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандаалт судалгааны албаны өсгөврийн шинжилгээний картанд эргэмж судалгаа хийж SPSS программаар дүнг нэгтгэв.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан 60 хүнээс 40 (66.7%) тохиолдолд гэр бүлийн гишүүдээс 1-2 хүн сүрьеэгээр өвчилсөн хэмээн анамnez өгсөний 61 хүн сүрьеэгээр өвдсөн нь тогтоогдсон байсан нь 1 эмчилүүлэгчийн хавьтлаас сүрьеэгээр өвдөх тохиолдол 1.5 байна. Сүрьеэгээр өвдсөн 61 хавьтлын эмчилгээний үр дүн дүгнэлт хийхэд 29 (47.5%) нь сүрьеэ өвчний улмаас нас барсан, эдгэрсэн 10 (16.3%), урьдчилан сэргийлэх эмчилгээ хийлгэсэн 4 (6.5%), сүрьеэгийн эмчилгээ хүлээж байгаа 6 (9.9%) байна. Хавьтлыг эмэнд дасалтай сүрьеэтэй эсэхийг тооцож үзэхэд 10 (6.3%) нь ОЭДС-тэй байснаас 6 (60%) нь нас барж тэдний 5 (91.7%) эмчилгээнд орж чадаагүйн улмаас, 1 (8.3% ) нь ОЭДС-гийн эмчилгээ

тасалсаны улмаас нас барсан, үлдсэн 4 тохиолдол нь одоо ОЭДС-гийн эмчилгээ хийлгэж байна.

**Дүгнэлт:** ОЭДС-тэй эмчилүүлэгчийн ар гэр болон хамаатнуудаас сүрьеэгээр өвдөх эгзэг нь өндөр байгаа нь хавьтлын үзлэг шинжилгээ зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

**Цочмог вируст хепатит В-ийн  
халдвартай хүүхдүүдийн  
маркерийн шинжилгээнд дүгнэлт  
өгөх нь**

Ж.Улаан, Д.Чимэдноров, Б.Батсүх  
Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

Манай улсад 1991 оноос дархлаажуулалтын үндэсний товлолд В вирусийн эсрэг вакцин нэвтэрсэн. Үүний дүн өвчлөл 4 дахин буурсан. Гэвч вакцинда хамрагдсан хүүхдүүдийн дунд В вирусийн халдварт өвчнүүдийн бүртгэгдэж байна.

**Зорилго:** Цочмог вируст хепатит В вирусийн халдварт оношоор эмчлэгдсэн хүүхдүүдийн вирусийн маркерийн шинжилгээнд дүгнэлт өгөх

**Материал, арга зүй:** 2005-2009 оны хооронад ХӨСҮТ-д Цочмог В вирусийн халдварт оношоор эмчлэгдсэн 138 хүүхдийн өвчний түүхэнд эргэмж судалгаа хийлээ.

**Үр дүн:** В вирусийн халдвартай хүүхдүүдийн дундаж нас  $8,7 \pm 4,3$ . Хүйсний хувьд 63% нь эр, 37% нь эм хүйсний хүүхдүүд эзэлж байна. Вирусийн маркерийн шинжилгээнд : В болон А вирусийн халдварт хавсарсан байдлаар 110 буюу 79,7%, В вирусийн халдвартангаар 5,6%, В, Д вирус хавсарсан байдлаар 3,6% илэрсэн байна. Цочмог В вирусийн халдвартыг илтгэх HBcIgM 24 хүүхдэд буюу 17,4%-д илэрсэн. Д вирусийн халдвартай хүүхдүүдийн 1 нь В болон Д вирусийн хам халдвараар өвчилсөн байхад 4 хүүхэд буюу 2,9%-д вируст хепатит А, В, Д вирусийн халдварт хавсарсан байдлаар өвчилсөн. Элэгний үйл ажиллагааны биохимиийн шинжилгээнд өвчний эхлэл үед билирубин  $4,45 \pm 2,59$ , ГОТ  $3,63 \pm 1,4$ , ГПТ  $5,57 \pm 2$ , өвчний эдгэрлийн үед билирубин  $1,6 \pm 0,51$ , ГОТ  $0,9 \pm 0,7$ , ГПТ  $1,37 \pm 1,14$  болсон буурсан.

**Дүгнэлт:**

1. Цочмог В вирусийн халдвартай хүүхдүүдийн дундаж нас  $8,7 \pm 4,3$ , хүйсний хувьд эрэгтэй хүүхдүүд зонхилон өвчилсөн байна.

2. В болон А вирусийн халдварт хавсарсан байдлаар давамгайлан илэрч байна.

## 2009 онд Монгол оронд илрүүлсэн салхинцэгийн вирусийн генотипийг тодорхойлсон дүн

Д.Энхсайхан<sup>1</sup>, Ч.Майцэцэг<sup>1</sup>, В.Демкин<sup>3</sup>,  
П.Нямдаваа<sup>2</sup>,

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup>Монголын анагаах ухааны академи,

<sup>3</sup>ОХУ-ын ШУА харьяа Молекул Генетикийн  
Хүрээлэн, Москва хот

Салхин цэцгийн вирусийн генотипийг ангилдаг олон ангилалын нэг нь АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төв(ÖХСТ)-өөс гаргасан ангилал юм. Энэхүү ангилалаар салхин цэцгийн вирусийн генотипийг Европ 1 (E1), Европ 2 (E2) , Япон (J), Холимог 1 (M1), Холимог 2 (M2) [1], Холимог 3 (M3) ба Холимог 4 (M4) (Loparev, V et all, 2004; Sergeev, N et all, 2006; Loparev, V et all, 2006) гэсэн 7 хэв шинжид хуваадаг. Монгол хүнд 2004-2007 онд халдвартлагдсан салхин цэцгийн зарим вирусийн генотипийг энэхүү ангилалаар тогтоосон юм (Д. Энхсайхан и др, 2010; P. Nyamadawa et all 2010 ). 2008 онд Англи улсын Лондон хотноо болсон Салхин цэцгийн вирусийн ангилалын хурлаар олон ангилалыг нэгтгэж 1,2,3,4,5, VI, ба VII гэсэн 7 клейд буюу бүлэглэлд хувахаар тогтож, 2010 оноос эхлэн албан ёсоор мөрдөж эхэлсэн байна (Breuer, J et all, 2010).

**Зорилго:** Монгол оронд 2009 онд илрүүлсэн салхин цэцгийн хоёр вирусийн генотипийг ORF22 ампликоны нуклеотидийн дарааллын өвөрмөсийн байдлаар (SNP) тодорхойлж, шинэ ангилалаар ангилах. Энэ бол манай судлаачид салхин цэцгийн вирусийн нуклеотидын дарааллыг бие даан өөрийн орны нөхцөлд тодорхойлсон анхны ажил юм.

**Материал, арга зүй:** Судалгаанд 2009 онд салхин цэцгийн халвар авч ХӨСҮТ-д хэвтэн эмчлүүлж байсан 2 өвчтний цэврүүний шингэнийг ашигласан. Цэврүүний шингэнийг Хенксийн уусмалд авч хадгалсан. Вирусийн ДНХ-г QiAmp-DNA-Mini цомог ашиглан үйлдвэрлэгчийн зааврын дагуу ялгав.

Салхин цэцгийн вирусийн генүүдийн нуклеотидын дарааллыг тогтооходоо АНУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн төвлөрөөн боловсруулсан протокол [2]-ын дагуу ORF22 фрагмент таних праймерүүдээр секвенсинг хийж, ампликонуудыг Qiagen PCR цомог, MWG Pioneer, Primus 96-plus, Korea термосайклер ашиглан ПГУ-аар олшруулж, ПГУ-ын бүтээгдэхүүнийг Pioneer, Korea корпорацийн AccuPrep PCR purification цомог ашиглан үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэв. Цэвэрлэсэн ПГУ-ын бүтээгдэхүүнийг Applied Biosystem BigDye Terminator V3.1 Cycle Sequencing цомог ашиглан ABI 3130 xl Genetic An-

alyzer-аар нуклеотидийн дараалалыг тодорхойлов. Био-информатикийн анализыг ABI-ийн SeqScape v2.5 программ, MEGA 4 программыг тус тус ашиглан гүйцэтгэв.

**Үр дүн:** Салхин цэцгийн хоёр вирусийн ДНХ-ийн ORF22-ийн нуклеотидын дарааллыг тодорхойлж, 2 ба 4 бүлэглэлд багтаж байгааг тогтоов.

**Хэлцэмж, дүгнэлт:** Бреуер нарын судлаачид шинээр санал болгосон [6] салхин цэцгийн вирусийн 7 бүлэглэл болгосон ангилалаар манайд илрүүлсэн вирусийг ангилахад бидний судласан нэг вирус 2 дугаар, нөгөө нь 4 дүгээр бүлэглэлд хамаарч, хуучин ангилалаар M2 ба J бүлэглэлд тус тус хамаарч байна. Энхүү судалгааны дүн бидний урд хийсэн [4,5] судалгааны дүгнэлттэй бүрэн дүйж, баталгаажуулж байна.

## ВАСТЕС 9120 Машиныг нян судлалын шинжилгээнд хэрэглэсэн нь

Д. Алтанцэцэг, Д.Ану, М.Алтанхүү  
Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

Орчин үед шинжлэх ухааны дэвшлийн үр дүнд микробиологийн шинжилгээний шинэ арга техник практикт нэвтэрч байна. Үүний нэг жишээ нь шус болон биеийн шингэн дэх нянг өсгөвөрлөн хянах халуун тогтоогуур юм. Пневмококт тандалт төслийн хүрээнд ХӨСҮТ-ийн нян судлалын лабораторид 2009 оноос нян өсгөвөрлөх халуун тогтоогуур ВАСТЕСТМ 9120 төхөөрөмжийг ашиглаж эхлэсэн ба ВАСТЕСТМ 9120 төхөөрөмж нь:

• Тэжээлт орчинд нян ургалтын задралын бүтээгдэхүүн болох CO<sub>2</sub>-ийн агууламж нэмэгдэхийг мэдэрдэг мэдрэгчтэй ба түүнийг флюресцент түяаны тусламжтайгаар 10 минут тутамд хянана. CO<sub>2</sub>-ийн агууламж нэмэгдэхэд тэжээлт орчинд өсгөвөрлөгдэж байгаа нянг мэдэрч төхөөрөмж дохио өгнө.

• Шинжлэгдэж байгаа сорьшонд нян өсгөвөрлөгдэж эхлэх явшад CO<sub>2</sub> үүсч эхэнэ. Нян CO<sub>2</sub> -оор амьсгалж өсөж үржинэ

**Зорилго:** ВАСТЕСТМ 9120 төхөөрөмжөөр цус өсгөвөрлөх шинжилгээний үргэлжлэх хугацаа, үр дүн, эдийн засгийн үр ашгийг нян судлалын уламжлалт аргатай хариуулан судлах зорилгын үндэс дээр дараах зорилтыг тавьж байна.

-Цусыг ВАСТЕСТМ 9120 төхөөрөмж болон нян судлалын уламжлалт аргаар өсгөвөрлөж үр дүнг харьцуулан дүгнэх

-Цусны ариун чанарын шинжилгээг ВАСТЕСТМ 9120 төхөөрөмж болон нян судлалын аргаа өсгөвөрлөх зарцуулсан эдийн засгийн үр ашгийг тооцоох

**Материал, арга зүй:** Дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт хөвтэн эмчлүүлсэн уушгины хатгаа оноштой өвчтөнүүдээс цусны сорьсыг авч ВАСТЕСТМ 9120 төхөөрөмж болон уламжлалт аргаар өсгөвөрлөв.

ВАСТЕС 9120 машин DOS программ дээр ажиллах ба F3 Culture товчуурыг дарж сорьсыг оруулна. Сорьс авах Эерэг сорьс авах бол: Vial Remove хэсгээс Vial positive гэсэн barcode үншуулна Сөрөг сорьс авах бол: Vial Remove хэсгээс Vial negatives гэсэн barcode үншуулна.

**Үр дүн:** Уламжлалт аргаар цусны ариун чанарын шинжилгээ хийхэд: Сөрөг тохиолдол 7 хоногт, эерэг тохиолдол 72-96 цагт шинжилгээний хариу гарч байв.

ВАСТЕС 9120 төхөөрөмжөөр сөрөг тохиолдол 5 хоногийн дараа, эерэг тохиолдлын шинжилгээний хариу 48-58 цагт гарах боломжтой байв.

Цусны ариун чанарын шинжилгээг ВАСТЕС 9120 төхөөрөмжөөр хийхэд үйл ажиллагааг 2 дахин хөнгөвчилиж, зардал 2 дахин хямдarch байна.

**Дүгнэлт.** ВАСТЕС 9120 төхөөрөмжинд цусны ариун чанарыг шинжилэхэд цаг хугацаа, үйл ажиллагааг 2 дахин хөнгөвчилиж, эдийн засгийн хувьд 2 дахин хямд болж, лаборантын гардан хийх үйл ажиллагааг хөнгөвчилиж байна.

Талархал энэ судалгааг хийхэд гүн туслашаа үзүүлсэн лаборант С. Болормаа , А. Азжаргал нарт талархал

илэрхийлье

## Бактерт менингит ба уушгины хатгаа өвчний үүсгэгчийг тодорхойлох лабораторийн тандалт

Д.Алтаншээг<sup>1</sup>, Д.Содбаяр<sup>3</sup>, М.Алтанхүү<sup>1</sup>,  
О.Баатархүү<sup>2</sup>, Ж.Сарантuya<sup>2</sup> Д.Булган<sup>2</sup>  
С.Бүжинлхам<sup>1</sup>, Д.Нямхүү<sup>1</sup> Г.Сүрэнхан<sup>1</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв,

<sup>2</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль  
<sup>3</sup> ДЭМБ-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

Амьсгалын замаар *Neisseria meningitidis*, *Haemophilus influenzae*, *Streptococcus pneumoniae* зэрэг нянгууд зөөгдөн хүүхдээд нярай үеэс нь эхлэн менингит, уушгины хатгаа, цусан үжил дунд зэрэг өвчнүүдийн үүсгэх гол шалтгаан болдог. Манай оронд менингококт халдвараар ихэвчлэн 0-5 наасны хүүхдүүд өвчилдөг бөгөөд энэ нь нийт тохиолдлын 91.5%-ийг эзэлж байна.

**Зорилго:** Бактерт менингит, уушгины хатгаа,

цусан үжил оноштой өвчний цус, тархи нугасны шингэнээс *N. meningitidis*, *H. influenzae*, *S. pneumonia* нянгуудыг илрүүлэн, полимеразын гинжин урвалаар ийлдэст хэв шинж, даслын МесА генийн идрэлтийн хувийг тогтоох.

**Материал, арга зүй:** 2002 – 2010 онд Улаанбаатар хотын 5 хүртлэх наасны хүүхдийн дундах бактерт менингит өвчний тандалтанд хамрагдсан ЭНЭШТ, ХӨСҮТ, СХДНЭ, СБДНЭ, ХУДНЭ, БЗДНЭ эмнэлгүүдээс ТНШ (n=355) цус (n= 7171)-ны сорьсыг цуглуулж шинжилгээ хийв. Шинжилгээг нян судал, латекс наалдуулах урвалын аргаар *H. influenzae* (HI), *N. meningitidis* (NM), *S. pneumonia* (SP) болон бусад нянгуудыг илрүүлэн антибиотикийн мэдрэг чанар, шингэрүүлэлтийн аргаар нянг үхүүлэх хамгийн бага тунг тодорхойлов. Полимеразын гинжин урвалаар Антибиотикт тэсвэртэй *N. meningitidis*, *H. influenzae*, *S. pneumonia* нянгуудын МесА гений идрэлтийн хувийг тогтоож, ийлдэс хүрээг тодорхойлов.

**Үр дүн:** 2002-2010 онд 310 өсгөвөр илэрснээс Hib 67(21,6%) *N. Meningitidis* 66(21,3%) Str. Pneumoniae 69 (22,5%), *S.aureus*, *S. pyogenes* B group Streptococcus, *E.Coli*, *Klebsella* зэрэг бусад нянгууд 108(34,8%) өсгөвөрлөгдөв. Үүнээс нян судал, Эмнэлэгт хэвтэхээс өмнө ТНШ өгсөн өвчтний 52,0% нь антибиотик хэрэглэсэн бол цусны 45,8% нь эмнэлэгт хэвтэхээс өмнө антибиотик хэрэглэсэн ба антибиотик хэрэглэсэн сорьсны 70% –д нь өсгөвөр илэрсэн байна.

Эерэг шинжлэгдэхүүний 68,3%/138 (202) буюу *N.meningitidis* 44/66-д, *H.influenzae* 65/67-д, *S.pneumonia* 47/69- д өвөрмөц хэвшинж, ийлдэс хүрээ тодорхойлсон. *S.pneumoniae*-ийн 7F жэв шинж, *N.meningitidis* A ийлдэс хүрээ *H.influenzae type b* зонхилон ирэв. SP эерэг ТНШ-д MLST (Multilocus sequence typing) аргаар нуклейн хүчлийн дараалал тодорхойлсон ба үр дүн нь бусад орнуудад бүртгэгдсэн SP-ын ижил хэвшинжид хийсэн шинжилгээний дүнтэй тохирч байв ([www.mlst.net](http://www.mlst.net)). ПГУ-аар хэвшинж тодорхойлох боломжгүй нэг *Streptococcus pneumonia* SP-ийн нуклейн хүчлийн дарааллыг тодорхойлоход 27-р хэв шинжийнх байсныг тогтоолоо.

### Дүгнэлт :

1. *S. pneumonia* *N. meningitidis* *H. influenzae* зэрэг нянгууд нь уушгины хатгаа менингит өвчний гол үүсгэг нь болох нь тодорхойлогдов.

2. Хэв шинжүүдээс *N.meningitidis*-ийн A ийлдэс хүрээ, b хэвшинжийн *H.influenzae*, 7-р хэвшинжийн *S.pneumonia* зонхицж байв.

3. *S.pneumonia* –д нь *N. meningitidis* нь cephalosporins ciprofloxacin Chloramphenicol Ampicillin *H.influenzae*, нь Ciprofloxin Cefotaxime - д мэдрэг болох нь тодорхойлогдов.

## Тархи нугасны шингэнд латекс наалдуулах урвалаар *Neisseria meningitidis*, *Haemophilus influenzae*, *Streptococcus pneumoniae* илрүүлсэн нь

Д.Алтанцэцэг, Д. Ану, М.Алтанхүү, С.Бүжинлхам, Ч.  
Уранжаргал  
Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

Газарзүйн бүс нутагт болоод хүн амын насны бүлэг бүрт менингитийн шалтгаан ѿөр ѿөр байдаг. Бактерт менингитийн дэгдэлт болоогүй үед жил бүр өвчлөлийн нэг сая тохиолдол бүртгэгдэж хоёр зуун мянга нь нас бардаг бөгөөд халдварт үүсгэх нянгийн төрөл болон өвчтний наснаас хамаарч нас баралт харилсан адилгүй байдаг. Хөгжингүй орнуудад өвчлөгсдийн 3-19% нь нас бардаг бол хөгжих бүй орнуудад 37-60% байна. Мөн өвчлөгсдийн 57 хүртэл хувь нь дүлий өсвэл оюуны хомсдолтой, мэдрэлийн саажилттай тахир дутуу болдог байна.

Манай судлаачдын судалгаанаас үзэхэд 10 хүртэлх насны хүүхдүүдийн дундах нийт өвчлөлийн 78.0%-ийг *N.meningitidis*-ээр үүсгэгдсэн менингит эзлэж байжээ (Цэнд.Н1978). 1996-2000 онд эмнэлзүйгээр менингит оноштой 515 өвчтнөөс тархи нугасны шингэн авч латекс наалдуулах урвал нийт 98 өвчтнөөс тархи нугасны шингэн авч уг сорьнуудад *Neisseria meningitidis* (NM), *Haemophilus influenzae* (HI), *Streptococcus pneumoniae* (SP)-г илрүүлэх шинжилгээг Wellogen Bacterial Antigen Kit-ийг ашиглан латекс наалдуулах урвалын аргаар хийв. ТНШ-ийг зөөвөрлөж ирэнгүүт центрофугдэж хөвсөн хэсгээс авч урвалaa явуулна. Латекс наалдуулах урвалын шинжилгээг хийж гүйцэтгэхэд нийт 2 цаг зарцуулагдах ба үүсгэгчийг тодорхойлохын зэрэгцээ ийлдэс хүрээг илрүүлнэ. ТНШ-үүд нь клиник биохимийн шинжилгээгээр цагаан эсийн тоо өндөр (>100 эс(мм3), уургийн агууламж ихэссэн (>100 мг(дл), глюкозын агууламж багассан (< 40 мг(дл) зэрэг бактерт менингитийн тохиолдлын тодорхойлолтыг хангасан байв.

**Зорилго:** Бактерт менингит, Сепсис, Уушгины хатгалгаа оноштой өвчтний тархи нугасны шингэн (TNШ)-д латекс наалдуулах урвалын аргаар *Neisseria meningitidis*, *Haemophilus influenzae*, *Streptococcus pneumoniae* илрүүлэх.

**Материал, арга зүй:** Бактерт менингитийн тандалтаар Бактерт менингит, Менингококкемия оноштой 0-5 настай 98 өвчтнөөс тархи нугасны шингэн авч уг сорьнуудад *Neisseria meningitidis* (NM), *Haemophilus influenzae* (HI), *Streptococcus pneumoniae* (SP)-г илрүүлэх шинжилгээг Wellogen Bacterial Antigen Kit-ийг ашиглан латекс наалдуулах урвалын аргаар хийв. ТНШ-ийг зөөвөрлөж ирэнгүүт центрофугдэж хөвсөн хэсгээс авч урвалaa явуулна. Латекс наалдуулах урвалын шинжилгээг хийж гүйцэтгэхэд нийт 2 цаг зарцуулагдах ба үүсгэгчийг тодорхойлохын зэрэгцээ ийлдэс хүрээг илрүүлнэ. ТНШ-үүд нь клиник биохимийн шинжилгээгээр цагаан эсийн тоо өндөр (>100 эс(мм3), уургийн агууламж ихэссэн (>100 мг(дл), глюкозын агууламж багассан (< 40 мг(дл) зэрэг бактерт менингитийн тохиолдлын тодорхойлолтыг хангасан байв.

**Үр дүн:** 98 өвчтнөөс авсан ТНШ-нд Латекс наалдуулах урвалаар уг шинжилгээг тавихад 70 (71%) шинжлэгдэхүүн гурван төрлийн үүсгэгчийн аль нэгд нь эерэг дүн үзүүлсэн ба 30 (41,3%)-д нь *Neisseria meningitidis* (NM), 25 (35,7%)-д нь *Haemophilus influenzae* (HI), 15 (21,4%)-д нь *Streptococcus pneumoniae* (SP) ээрэг тодорхойлогдлов. Эдгээр ТНШ-ээс дээрх 3 нянг өсгөвөрлөхд 32(32.7%)-д илэрсэн байна.

### Дүгнэлт

1. Латекс наалдуулах урвал нь хурдавчилсан арга бөгөөд нянг судлалын шинжилгээнээс 2 дахин мэдрэг болох нь харагдаж байна.

2. Латекс наалдуулах урвалын арга нь эмгэгтөрөгчийг илрүүлэхэд үр ашигтай, энгийн арга юм.

Талархал энэ судалгааг хийхэд гүн туслацаа үзүүлсэн лаборант С. Болормаа, А. Азжаргал нарт талархал илэрхийлье

## Олон эмэнд дасалтай сүрьеэг илрүүлэх молекулын хурдавчилсан аргыг уламжлалт аргатай харьшуулан судалсан судалгааны дүн

Б.Буянхишиг<sup>1</sup>, Т.Оюунтуяа<sup>1</sup>, Б.Цэрэлмаа<sup>1</sup>, Н.Наранбат<sup>1</sup>, Ж.Сарантуяа<sup>2</sup>, С.Митарай<sup>3</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

<sup>2</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

<sup>3</sup>Япон улсын Сүрьеэгийн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн

ДЭМБ-ын тайлангаар олон эмэнд дасалтай сүрьеэжил бүр 400000 гаруй тохиолдол бүртгэгдэж байна. Одоогийн байдлаар маш олон эмэнд дасалтай сүрьеэд дэлхийн 48 орныг хамраад байгаа нь тогтоогдсон. Манай улсын сүрьеэгийн өвчлөл 1990-2007 оны хооронд 100000 хүн амд 79- 166 промиль болтол өсөж 2 дахин нэмэгдсэн ба сүүлийн жилүүдэд үрдүнгүй эмчлэгдсэн, сүрьеэ дахисан тохиолдлын тоо нэмэгдэж байна. Одоогийн эмнэлгийн практикт хэрэглэж байгаа уламжлалт арга цаг хугацаа их зарцуулдгаас олон эмэнд дасалтай сүрьеэ хүн амд тархах аюул нүүрлэж байгаа тул богино хугацаанд эмэнд дасалтай сүрьеэг илрүүлэх аргыг хэрэглэх шаардлага билэнд тулгарсан юм.

**Зорилго:** Монголын нөхцөлд олон эмэнд дасалтай сүрьеэг илрүүлэхэд изониазид, рифампицинд тодорхойлох молекулын хурдавчилсан аргыг

хэрэглэж илрүүлэлтийн байдлыг уламжлалт аргатай судлах.

**Материал, арга зүй:** Молекулбиологийн хурдавчилсан арга Geno Type ® MTBDR plus (Hain Life-science, Nehren, Germany) шомгийг ашиглаж изониазид, рифампицина тэсвэртэй мутантыг тодорхойлж уг аргын мэдрэг, өвөрмөц чанарыг өндөгтэй хатуу тэжээлт орчинд эмэнд мэдрэг чанар тодорхойлох уламжлалт аргатай харьцуулан судалсан. Судалгааг 2009 оны 7 сараас 2010 оны 5 сарын хооронд хийж Улаанбаатар хотын 8 дүүрэг, Хорихын сүрьеэгийн эмнэлгийн олон эмэнд дасалтай сүрьеэгийн сэжигтэй 14-75 насны 218 өвчтөнг хамруулсан. Элгээрийн 127 (58.3%) нь эрэгтэй, 91(41.7%) эмэгтэй байв.

**Үр дүн:** Geno Type Mycobacterium tuberculosis (MTBDR plus) assay (Hain Life-science, Nehren, Germany) цомог клиникийн 41 сорьшонд шууд, 109 ялгасан өсгөвөрт тодорхойлж уламжлалт эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний аргатай харьцуулан судалсан. GenoType® MTBDRplus цомгийн уламжлалт аргатай харьцуулан судлахад мэдрэг чанар, өвөрмөц чанар, эзэр болон сөрөг пердуктив утга, сүрьеэгийн эсрэг рифампицина тэсвэртэйг тогтооход 100%, 98.8%, 98.9%, 100%; изониазидын тэсвэртэйг тогтооход 98.6%, 100%, 100%, 98.3%; олон эмэнд дасалтай сүрьеэг илрүүлэхэд 98.3%, 100%, 98.4%, 98.7% буюу өндөр үр дүнтэй байв. Хоёр аргаар зөрүүтэй тохиолдлын өсгөврийг DNA sequence аргаар нарийвчлан судалсан.

**Дүгнэлт:**

The Genotype® MTBDRplus молекул биологийн арга нь олон эмэнд дасалтай сүрьеэг сорьшноос 1-2 өдрийн дотор илрүүлэх өндөр ач холбогдолтой, найдвартай арга болох нь тогтоогдоо. Уламжлалт аргаар эмнэлдэг чанартодорхойлох шинжилгээтэй харьцуулахад энэ арга нь шинжилгээнд зарцуулах хугацааг 1-2 сар багиносгож, халдварт тархалтыг барагсах ач холбогдолтой юм.

Лабораторийн шинжилгээний хариу богино хугацаанд гарах нь эрүүл мэндийн салбарын эмч, ажилтанда эмчилгээг зөв зохиист төлөвлөх, халдварт хяналтын арга хэмжээ цаг хугацаанд нь авч явуулахад чухал ач холбогдолтой байгаа бөгөөд эрүүлмэндийн салбарт лабораторийн чадавхийг сайжруулахад нилээд хүчин чармайлт хэрэгтэй байна.

**Талархал**

**Энэхүү судалгааг явуулахад дэмжлэг үзүүлсэн Улаанбаатар хотын сүрьеэгийн диспансер, клиникийн эмч нар болон ДЭМБ, Халуун орны өвчинтэй тэмцэх эрдэм шинжилгээний ажлыг тэтгэх сан зэрэг байгууллага, хамт олонд талархал илэрхийлье**

**Монголд ялгасан хачигт энцефалитын вирусийн омгуудын шинжүүд**

Д.Абмэд<sup>1</sup>, М.А.Хаснатинов<sup>2</sup>, Ж.Батаа<sup>1</sup>, Г.А.Данчинова<sup>2</sup>, П.Нямдаваа<sup>1</sup>, Д.Ану<sup>1</sup>, М.Ууганчимэг<sup>1</sup>, Б.Оюунбилиг<sup>1</sup>, У.Өнөрсайхан<sup>3</sup>, Х.Тунгалаг<sup>3</sup>

<sup>1</sup> Халдварт өвчин судалалын үндэсний төв,

<sup>2</sup> ОХУ-ын Анагаах Ухааны Академийн Сибирийн салбарын Халдварт нян судалалын хүрээлэн, Иркутск,

<sup>3</sup> Байгалийн голомтот халдварт өвчин судалалын үндэсний төв,

Хачигт энцефалитын вирус (ХЭВ) нь тархи нугасны нейроныг гэмтээж, цочмог халдварт өвчин-Хачигт энцефалит (ХЭ)-ын үүсгэгч болдог. ХЭВ-ийн газарзүйн тархалтад хийсэн судалгаанаас үзэхэд Алс Дорнодын, Баруун Европын, Урал-Сибирийн гэсэн өргөн тархсан хэвшинжүүд байдаг ба элгээр хэвшинжүүд эмнэлзүйн ялгаатай өвчлөлийг үүсгэдэг байна.

**Зорилго:** Монголд ялгасан ХЭВ-ийн омгуудын шинжүүдийг тодорхойлох зорилгоор Монголд ялгасан ХЭВ-ийн омгуудын удамшлын хэвшинжийг тодорхойлж, уг омгуудын үүсгэж буй ХЭ-ийн өвчлөлийн эмнэлзүйн онцлогийг тогтоож, Евразид тархсан бусад омгуудтай жиших зорилтуудыг шийдвэрлэв.

**Материал, арга зүй.** Судалгаанд 2001 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны орчмоос түүвэрлэсэн хачгаас ялгасан 92M (MNG-01-1p92), 2002 онд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутгаас түүвэрлэсэн хачгаас ялгасан 940M (MNG-02-1p940f), 2008 онд Булган аймгийн Бугат сумын нутагт хачигт хазуулж, ХЭ-р өвчилийг нас барсан хүний тархины сорьшноос ялгасан TBEV-MN-2008 омгуудыг ашиглов. Хачиг ба нас барсан хүний тархины сорьшонд хам цагийн ПГҮ-р анализ хийж, нуклейтидын дарааллыг тогтоохдоо нийтлэг аргыг ашиглов. Үдмын модны зурагалыг neigbor-joining аргаар гаргав.

**Үр дүн,** хэлшэмж. Филогенетикийн судалгаагаар 92M омог нь ОХУ-д ялгасан Заусаев, 940M омог нь Васильченко омгуудтай төстэй болохыг тогтоосон ба эдгээр омгууд нь ХЭВ-ийн Урал-Сибирийн хэвшинжид хамарагддаг. ХЭВ-ийн Урал-Сибирийн хэвшинжүүдийн анхдагч хэвшинж (prototype) нь Лесопарк-11 бөгөөд энэ омгууд нь дунд зэрэглэлийн эмнэлзүй бүхий бага нас баралттай ХЭ-ын өвчлөлийг үүсгэдэг. Бидний судалгаагаар дээрх 2 омгийг ялгасан Сэлэнгэ аймгийн нутагт ХЭ-р өвчлөгсдийн эмнэлзүй

## Элэгний цочмог дутагдлын улмаас нас барагсдын эмнэлзүй, лабораторийн онцлог

Б.Батсүх, Г.Ариунболд,  
Ц.Чинбаяр, М.Ууганчимэг, Ж.Ариунбилэг  
Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

нь мэнэнэнцефалитын хэлбэр 15%, нас баралт 1.6% байв. Ихэвчлэн толгой хүчтэй өвдөх, 39 хэмээс дээш халуурах, хүзүүний булчингийн хөшилт өгөх, бөөлжих, мөчдийн саажилт илэрч цаашид цацах, залгих рефлекс үгүй болох, эпилепсийн уналт өгөх, ухаан алдах, тархи хавагнах хүндрэлүүд ажиглагдаж байв.

Булган аймгаас ялгасан TBEV-MN-2008 омог нь ХЭВ-ийн Алс Дорнодын хэвшинжийн омгуудтай төстэй байв. ХЭВ-ийн Алс Дорнодын хэвшинжүүдийн анхдагч хэвшинж Софын ба тэдгээр омгууд нь маш хүнд зэрэглэлийн эмнэлзүйтэй, нас баралт өнөөр ХЭ-ийн өвчлөлтэй байдаг. Энэ омгийг ялгасан өвчтөн хачигт хазуулаад 11 хоногийн дараа “ХЭ-ийн мэнэнэнцефалит хэлбэр” оноштойгоор Булган аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэж, 11 хоногийн дараа нас барсан юм. Энэ өвчтний үхэлд хүргэсэн гол шалтгаан нь тархины цочмог хавагналт байв.

ХЭВ-ийн Баруун Европын хэвшинжүүдийн анхдагч хэвшинж Neudorfl, энэ хэвшинжийн омгууд нь хөнгөн хэлбэрийн өвчлөлтэй, нас баралт бараг тохиолдоггүй ба одоогоор манай улсад уг хэвшинжийн омог тодорхойлог- доогүй байна.

Хэвлэлийн тоймоос үзэхэл ХЭ-ийн өвчлөлийн эмнэлзүйн төрх нь газарзүйн байрлалуудад тархсан ХЭВ-ийн хэвшинжээс хамаарч, эрс ялаатай байдаг байна. ОХУ-д Алс Дорнодол голомтот хэлбэр давамгайлсан (30-60%), нас баралт 30-35% хүрсэн энэ өвчний маш хүнд хэлбэр бүртгэгдсэн байхад, Баруунд голомтот хэлбэр ердөө 2.2%, нас баралт бараг байдаггүй, Сибирт голомтот хэлбэр 5.4%, нас баралт 2.4% байдаг байна.

Манай оронд ялгасан ХЭВ-ийн омгууд нь ОХУ-д тархсан омгуудтай удамшлын хэвшинж ба үүсгэж буй ХЭ-ийн эмнэлзүйгээр төстэй байв. Газарзүйн тархалтаараа ХЭВ-ийн хэвшинжүүд 3 үндсэн хэсэгт хуваагддаг боловч зарим тохиолдолд өөрчлөгдөх нь ажиглагддаг. Ж: Алс Дорнодын хэвшинжийн вирусүүд Европ, Урал-Сибирт, Баруун Европын омгууд Урал-Сибирт тохиолдог. Энэ зүй тогтолын дагуу өнөөр хоруу чанартай ХЭВ-ийн Алс Дорнодын хэвшинжтэй төстэй вирус Монголд 2008 онд тодорхойлогдов.

Дүгнэлт. Монголд ялгасан ХЭВ-ийн омгууд нь удамшлын хэвшинжээрээ Урал-Сибир ба Алс Дорнодын хэвшинжийн омгуудтай төстэйг тогтоов. Тэдгээр омгуудаар сэдээгдсэн ХЭ-ийн өвчлөл нь ОХУ-тархсан омгуудынхтай ойролцообайв. Цаашид Монгол орны бусад нутгаас ХЭВ-ийн омгуудыг ялгаж судлах нь онол практикийн ач холбогдолтой.

Вируст хепатит нь манай орны төдийгүй дэлхийн хэмжээний эрүүл мэндийн тулгамдсан асуудал болсоор байна. Монгол улсын 2001-2005 оны халдварт өвчний өвчлөлийн тайлангаас үзэхэд 10000 хүн ам дахь вируст хепатитын өвчлөлийн тоо буурсан боловч элэгний дутагдлын улмаас нас барах нь 0.2%-с 0.58% болж өссөн байна.

**Зорилго:** ХӨСҮТ-ийн халдвартын клиникт 2006-2009 онуудад элэгний цочмог дутагдлын улмаас нас барагсдын эмнэлзүй ба лабораторийн үзүүлэлтүүдийг судлах

**Материал, арга зүй:** ХӨСҮТ-д 2006-2009 онуудад элэгний цочмог дутагдлын улмаас нас барсан 46 тохиолдлын өвчний түүхэнд эргэмж судалгаа хийлээ.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдагсдын 78.2% нь 15-29 насыхан, 38.5% нь 20-24 насыхан байлаа. Хүйсний хувьд ялгаа үгүй. Элэгний цочмог дутагдлын улмаас нас барагсдын тавиланд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзхэд хавсарсан эмгэгтэй 16 (бөөрний архаг эмгэгтэй 7, жирэмсэн 2), өвчин эхлэх үед архи уусан асуумжтай 8 хүн байсан. Эмнэлзүйн шинж тэмдэгүүдийг хам шинжүүдээр бүлэглэн авч үзвэл ходаод гэдэсний хямралын хам шинж 100%, бусад шинжүүд хавсарсан байдлаар 95.6%д давамгайлан илэрсэн.

Вирусийн маркерийн шинжилгээнд: В вирусийн халварыг илтгэгч HBsAg 91.3%д, HBV ба HDV вирус хавсарсан байдлаар 63%д илэрсэн байлаа.

Элэгний үйл ажиллагааны биохимийн шинжилгээнд нийт билирубины хэмжээ  $17.73 \pm 8.3$  мкмоль/л, ГОТ  $4.2 \pm 1.3$  ОУН/л, ГПТ  $5.85 \pm 2.13$  ОУН/л, нийт уураг  $58.3 \pm 19.1$  г/л, альбумин  $33 \pm 14$  г/л байв

Цусны ерөнхий шинжилгээнд лейкоцитоз, тромбоцитопени, шээсний ерөнхий шинжилгээнд гематурия, протейнурия давамгайлан илэрсэн байлаа.

### Дүгнэлт:

1. Элэгний цочмог дутагдлын улмаас 15-29 насын идэр насны залуучууд нас барсан В вирусын халдварт нь үндсэн шалтгаан болж байна.

2. Өвчний тавиланд бөөрний болон бусад эрхтний хавсарсан эмгэгтэй, архи хэрэглэдэг байх нь тавиланд муугаар нөлөөлж байна.

3. Эмнэлзүйд ходоод гэдэсний хямралын хамшинж 100%, бусад шинжүүд хавсарсан байдааар 95.6% дэвамгайллан илэрсэн.

Элэгний үйл ажиллагааны биохимийн шинжилгээнд нийт билирубины хэмжээ  $17.73 \pm 8.3$  мкмоль/л, ГОТ  $4.2 \pm 1.3$  ОУН(л, ГПТ  $5.85 \pm 2.13$  ОУН(л, нийт уураг  $58.3 \pm 19.1$  г/л, альбумин  $33 \pm 14$  г/л байв. Цусны ерөнхий шинжилгээнд лейкоцитоз, тромбоцитопени, шээсний ерөнхий шинжилгээнд гематурия, протейнурия давамгайллан илэрсэн нь бөөрний архаг эмгэг хавсарч явагдаж байгааг харуулж байна.

## ХӨСҮТ-ийн Халдвартын клиникт нас барсан тохиолдолуудын судалгаа

Ц.Оюунчимэг, М.Оюунгэрэл, Ц.Чинбаяр,

М.Уганчимэг, Б.Батсүх

Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв

Дэлхий дахина явагдаж буй нийгэм эдийн засаг, байгаль цаг уурын өөрчлөлтийн улмаас халдварт өвчний бүтэц өөрчлөгдж байна. Шинэ болон сэргэж буй зарим халдварт өвчний улмаас нас барах нь сүүлийн үед нэмэгдэх хандлагатай байна.

**Зорилго:** ХӨСҮТ-д 2006-2009 оны хооронд нас барагдын өвчний түүхэнд дүгнэлт хийж өвчний бүтэц болон нас баралтанд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах зорилго тавилаа.

**Материал арга зүй:** ХӨСҮТ –ийн Халдвартын клиникт 2006-2009 оны хооронд нас барагдын 77 өвчний түүхэнд эргэмж судалгаа хийлээ.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдагдын 50% нь 15-29 насны идэр насны залуучууд эзэлж байна. Эр :эм хүйсийн харьцаа 1:0.8 байв. Тэдгээрийн дундаж ор хоног 7.63, өвчин эхэлснээс эмнэлэгт хандсан хугацаа 7.12 хоног, эрчимт эмчилгээнд байсан хугацаа 5.3 хоног, ердийн тасагт эмчлэгдсэн хоног 1.95 байлаа. Өвчний бүтцээр нь авч үзэхэд элэгний цочмог үрэвсэл дийлэнх буюу 59% -ийг эзэлж байна. Элгээрээс оношийн бус нас баралт 16.1%, хоног болоогүй нас баралт 18%, эхийн эндэгдэл 6.5% -ийг эзлэж байв. Дээрх хоног болоогүй 14 нас барсан тохиолдолын 8 нь менингит, 3 нь элэгний цочмог үрэвсэл, 1 тохиолдол тус бүр остеомиелит болон цусан суулга оноштой байсан. Нас баралтын шалтгаанаар нь авч үзвэл 46 буюу 60% нь элэгний хүрч дутагдалын улмаас, 9 буюу 11.7% нь халдварт хорлогын шокын улмаас, 6 буюу 7.8% нь зүрхний дутагдалын улмаас нас баржээ. Нас барагдын 79% нь эмгэг судаллын шинжилгээнд хамрагдсан ба тэдгээрийн 75% нь үндсэн онош, 58% нь дагалдах онош тохирсон байна.

### Дүгнэлт:

1. ХӨСҮТ-ийн Халдвартын клиникт нас барсан тохиолдолын дийлэнхийг 15-29 насны идэр насны залуучууд эзэлж, дийлэнх нь элэгний цочмог дутагдалын улмаас нас барсан байлаа.

2. Хоног болоогүй нас баралтын 57%-ийг менингококт халдварт эзэлж байна.

3. Оношийн бус нас баралт 16%-ийг эзэлж байгаан няялан оношлогоог сайжруулах шаардлагатай гэдгийг харуулж байна.

## ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасгуудад 2005-2009 онд нас барсан тохиолдолуудын судалгаа

Ц.Оюунчимэг. С.Энхтуяа

Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв

Үндэслэл: Монгол улс нь Номхон далайн баруун бүсийн 37 орноос сүрьеэгийн өвчлөл өндөртэй эхний 7 орны тоонд орж, хүн амын нас баралтын шалтгаанаар тэргүүлэх өвчний 6 дугаарт бичигдэж байна. Эмийн дасалтай сүрьеэ шинэ бүртгэгдсэн тохиолдолын дунд 1% байхад, давтан эмчлүүлэгчдийн дунд 28% байна. Энэ нь хөдөө орон нутгаас төв суурин газарт шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой ба тодорхой харьялалгүй, хаяггүй, ажилгүй түр оршин сууҷид олширсон нь улмаар эмнэлэгийн тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй, эмчилгээг таслах, эмийн дасалтай сүрьеэ үсэх, нас баралт ихсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

**Зорилго:** Сүрьеэгийн улмаас нас барсан тохиолдолын өвчлөлийн байдал, хоног болоогүй нас баралтын шалтгааныг тогтоох, оношийн зөрөөнд дүгнэлт өгөх.

**Материал арга зүй:** ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникт 2005-2009 онд нас барсан 244 тохиолдолын өвчний түүхэнд эргэмж судалгаа хийлээ.

**Судалгааны үр дүн:** ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникт сүүлийн таван жилийн турш бүртгэгдсэн нас баралтыг оноор харьцуулахад: 2005 онд-33, 2006 онд- 52, 2007 онд- 55, 2008 онд- 47, 2009 онд- 57 байгаа нь жил ирэх тусам нас баралт өсөх хандлагатай байгааг харуулж байна. Нас барсан тохиолдолын дотор эрэгтэй 143 (58,7%), эмэгтэй 81(33,2%), хүүхэд 20(8,1%) бөгөөд 0-13 насныхан 23 (9.3%), 18-25 -35 (14.3%), 26-35 - 58 (23.8%), 36-45 - 52 (21.3%), 46-55- 43 (17.6%), 55-дээш насныхан 33 (13.5%) байна. Судалгаанд хамрагдсан тохиолдолын 151 (65,9%) нь эмчилгээний 1-р бүлгээр, 47 (20,5%) - 2-р бүлэг, 2 (0,9%) 3-р бүлгээр эмчлэгдэж байсан. Олон эмийн дасалтай сүрьеэгийн нас баралтын

тохиолдол 2006 онд 3 байснаа 2009 онд 9 болсон байна. Нас барсан тохиолдоос хоног болоогүй нас баралт 2007 онд 6 (10,9%), 2009 онд 11 (19,2%) байгаа нь эмнэлэгт оройтож хандах, хожуу оношлогдох, эмчилгээ үр дүнгүй нас барах шалтгаан болж байна. 2005, 2007-онуудад эхийн энэгдэл (3), оношийн зөрөө (15) гарсаны дийлэнх ушиг болон элэгний хавдар, хатгалганы шалтгаантай байна. Нас барсан тохиолдоос эмгэг анатомийн шинжилгээнд 2008 онд 10 (21,2%), 2009 онд 19 (33,3%) хамрагдаагүй байна. Нас баралтын шалтгааны дотор олон эрхтэний сүрьеэ -93 (56,%) , соривт хөндийт сүрьеэ-45 (27,5%)-ийг эзэлж байгаа нь өвчтөн хүндэрсэн хойноо эмнэлэгт хандах, олон эрхтэний хавсарсан тохиолдол иксэх хандлагатайг харуулж байна. Харьяа дүүрэг, орон нутгаар нь авч үзвэл: СХД, БЗД, ЧД, БГД, Дархан-Уул аймаг, Төв аймгийн харьяалал бүхий нас баралт илүү байна.

#### Дүгнэлт:

1. Шинээр илэрч буй сүрьеэгийн нас баралтын үндсэн шалтгаан нь оношийн хожимдол болж байна.

2. Сүрьеэгийн хяналттай эмчилгээг тасалсан тохиолдолд олон эмийн дасал үүсэх, дахин сэдрэх, өвчтөн эмчид хандахгүй өөрийгөө эмчлэн цаг алдаж оношлогдох, хүндэрч ирэх, хоног болоогүй нас баралт иксэх хандлагатай байна.

3. Сүрьеэгийн оношлогооны чадавхийг сайжруулах, оношийн баталгаажилтыг нэмэгдүүлэхийн тулд нас барсан тохиолдолын эмэг анатомийн шинжилгээг тохиолдол бүрт хийх шаардлагатай байна.

## Сүрьеэтэй өвчтөнүүдэл дархлаа зүгшрүүлэх эмчилгээ хийсэн дүн

П.Энхтамир<sup>1</sup>, О.Баатархүү<sup>2</sup>, Н.Наранбат<sup>1</sup>,  
П.Янжиндулам<sup>1</sup> С.Энхтуяа<sup>1</sup>, Б.Мөнхзүүл<sup>1</sup>,  
Р.Болор<sup>1</sup>, Г.Саранггоо<sup>1</sup>, Р.Оюунгэрэл<sup>1,2</sup>,  
С.Цогтсайхан<sup>2</sup>, М.Алтанхүү<sup>1</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв,  
<sup>2</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Т эсийн дэд бүлгүүдийн тоог тодорхойлох нь дархлаа чадамж, түүн дотроо эсийн дархлаа чадамжийг үнэлэх нэг чухал арга юм. Мөн дархлаа дэмжих эмчилгээ хийх нь Т эсийн дэд бүлгийн тоо хэмжээнд нөлөөлж байгаа эсэх, ингэснээр сүрьеэгийн эмчилгээний үр дүнд дүгнэлт өгөх боломж байгааг

судлах нь чухал байна

**Зорилго:** Сүрьеэгийн үндсэн эмчилгээний үед дархлаа зүгшрүүлэх эмчилгээг хавсран хийж эсийн дархлааны үндсэн үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөг тогтоох

**Материал, арга зүй:** Судалгаанд 2008 оны 8 сараас 2009 оны 3 сарын хооронд Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв (ХӨСҮТ)-ийн сүрьеэгийн клиникт урьд өмнө нь сүрьеэгийн эмчилгээ нэг сараас дээш хугашаагаар хийлгэж байгаагүй шинэ, түрхэц эерэг 17-61 насны (дундаж нас  $31,7 \pm 12,1$ ), эрэгтэй 26(52%), эмэгтэй 24(48%) нийт 50 өвчтөнийг хамруулав. Сүрьеэгийн эмчилгээний эхэнд болон эрчимт эмчилгээний төгсгөлд /56 дахь хоногт/ захын цусны сорьц цуглуулж ХӨСҮТ-ийн дархлаа судаллын лабораториод Becton Dickinson пүүсийн FACS Count багажаар урсгал эс тоолуурын аргаар үйлдвэрлэгчийн дагалдуулсан зааврын дагуу эсийн дархлааны зарим үзүүлэтийг (CD4, CD8, CD3 эсүүдийн үнэмлэхүй тоо, эс/мм<sup>3</sup>; CD4/CD8 харьцаа) тодорхойлсон болно

**Үр дүн:** Нийт 50 өвчтний захын цусанд Т эсийн дэд бүлгүүдийг тодорхойлоход CD4 –ийн хэмжээ  $605,1 \pm 242,8$  эс/мм<sup>3</sup>, CD8-ийн хэмжээ  $470,9 \pm 235,8$  эс/мм<sup>3</sup>, CD3-ийн хэмжээ  $1130,7 \pm 425,6$  эс/мм<sup>3</sup>, CD4/CD8 харьцаа  $1,48 \pm 0,67$  байв. Т эсийн дэд бүлгүүдийн хооронд хүйсний хувьд статистикийн үнэн магадтай ялгаа ажиглагдсангүй ( $p > 0,05$ ).

Сүрьеэтэй өвчтнүүдийн Т эсийн дэд бүлгүүдийг насны ангилалаар авч үзэхэд: 20-29 насанд CD4-ийн хэмжээ  $583 \pm 180,2$  эс/мм<sup>3</sup>, CD8-ийн хэмжээ  $546,4 \pm 53,37$  эс/мм<sup>3</sup>, CD3-ийн хэмжээ  $1134 \pm 362,8$  эс/мм<sup>3</sup>, CD4/CD8 харьцаа  $1,35 \pm 0,55$  байсан бол 50-аас дээш насанд CD4 –ийн хэмжээ  $406,5 \pm 159$  эс/мм<sup>3</sup>, CD8-ийн хэмжээ  $334,5 \pm 180$  эс/мм<sup>3</sup>, CD3-ийн хэмжээ  $782 \pm 251,1$  эс/мм<sup>3</sup>, CD4/CD8 харьцаа  $1,59 \pm 1,1$  байлаа.

#### Дүгнэлт:

1. Уушгины, шинэ, түрхэц эерэг, нэвчтэст хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнд эсийн дархлаа дарангуйлагдсан нь CD4 эсийн тоо цөөрч CD4/CD8 харьцаа буурсанаар ( $p < 0,05$ ) илрэй байна.

2. Уушгины, шинэ, түрхэц эерэг, нэвчтэст хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнд эсийн дархлаа 50-аас дээш насныханд илүү дарангуйлагдаж, хүйсний ялгаагүй байдал нь тогтоогдоо ( $p > 0,05$ ).

3. Сүрьеэтэй өвчтнийг дархлаа зүгшрүүлэх үйлдэлтэй салимон бэлдмэлээр хавсран эмчилсэн эмчилгээний үр дүн CD4-ийн хэмжээ олширч болон CD4/CD8 харьцаа иксэж ( $p < 0,05$ ,  $p < 0,001$ ) байна.

## Томуугийн A(H1N1)в вирусийн халдвартын үеийн цээжний рентген зураг дахь өөрчлөлтийг судалсан дүн

Л.Тунгалааг<sup>1</sup>, Д.Гончигсүрэн<sup>2</sup>, Л.Пүрэвсүрэн<sup>1</sup>,  
С.Цацрал<sup>1</sup>, О.Оюунчимэг<sup>1</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв,  
<sup>2</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

**Зорилго:** Томуугийн A(H1N1) вирусийн халдвартай өвчтөнүүдийн цээжний рентген зураг дахь өөрчлөлтийг эмнэлзүйн хэлбэр бүрээр дүгнэн, эмнэлзүйн хэлбэр болон эрсдэлт хүчин зүйлийг уялдуулан судлах.

**Материал, арга зүй:** Судалгааг агшингийн ретроспектив судалгааны аргаар хийсэн. Энэ судалгаанд Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв (ХӨСҮТ)-ийн вирус судаллын лабораторт хамрын арчдасын сорьшонд бодит хугацааны урвуу транскриптаат полимеразын гинжин урвал (бх-YT-ПГҮ:rt-RT-PCR) эерэг байгаа A(H1N1) вирус илэрсэн, 2009 оны 10 сарын 12-ноос 2009 оны 12 сарын 31-ны хооронд цээжний рентген зураг (ЦРЗ) авахаулсан, ХӨСҮТ-д хэвтэн эмчлүүлсэн 80 өвчтөнийг хамруулсан. ЦРЗ-ийг Hitachi дижитал TU-51 рентген зураг авах суурин, BMCO маркийн зөөврийн рентген аппаратаар цээжний эгц ардаас урагш (A/Y) байрлалд авсан. ЦРЗ-ийг хоёр мэргэжсэн дүрс оношлогооны эмч туслаа уншиж, эцсийн дүгнэлтийг гаргасан болно.

Судалгаанд хамрагдсан 80 өвчтөний өвчний түүхээс тусгай боловсруулсан шалгуураар үнэлж, эмнэлзүйн хөнгөн, дунд, хүнд гэсэн 3 хэлбэрт ангилсан ба мөн өвчтөнд эрсдэлт хүчин зүйл байгаа эсэхийг үнэлсэн. Судалгааны боловсруулалтыг "SPSS 11,5", EpilInfo программ ашиглан хийсэн болно.

**Үр дүн:** Томуугийн A(H1N1) вирусийн халдвартын эмнэлзүйн дунд, хүнд хэлбэртэй харьцуулахад хөнгөн бүлгийн өвчтөнүүдийн ЦРЗ хэвийн байх нь илүү байв ( $p=0,001$ , Пирсон  $x^2$  критер). Эмнэлзүйн хөнгөн явтай үед ЦРЗ 47% хэвийн, 53% хэвийн бус, эмнэлзүйн дунд хэлбэрийн үед ЦРЗ 15% хэвийн, 85%хэвийн бус, эмнэлзүйн хүнд явтай үед ЦРЗ 100% хэвийн бус байв. Эмнэлзүйн хөнгөн, дунд хэлбэрийн үед ЦРЗ дахь хэвийн бус өөрчлөлт нь перибронхиал өөрчлөлт давамгайлж байв. Томуугийн A(H1N1) вирусийн халдвартын эмнэлзүйн хүнд хэлбэрийн үед ЦРЗ-т хоёр талын, симметрик тархалттай, олон тооны бүүдгэр шилний шинж болон хатуурал дангаараа болон хавсарсан байдлаар илэрч байна. Тархалтын хувьд авч үзэхэд бүх 3 бүлэгт хоёр талын ба хоёр талдаа ижил (симметрик) тархалт давамгайлсан

байв. Төвийн ба захын гэсэн байрлалын хувьд 3 бүлэгт ялгаа гараагүй ( $p=0,69$ ). Харин уушигны дээд, дунд, доод талбайд тархсан байрлалын хувьд 3 бүлэгт ялгаатай байв ( $p=0,012$ ). I бүлэгт илүү давамгайлсан тархалт нь уушигны доод талбайд, II бүлэгт уушигны доод талбайд, III бүлэгт уушигны дунд ба доод талбайд байв. Өвчтөнүүдийн ЦРЗ-т плеврийн шингэн, хөндий, зангилаа, пневмоторакс, лимфаденопати илрээгүй байв. Эрсдэлт хүчин зүйл бүхий өвчтөнүүд эмнэлзүйн хувьд хүндэрх тусам илүү тохиолдож байна (хүнд (III), 36,8%; дунд (II), 26,1%; хөнгөн (I), 0%) ( $P=0,037$ ,  $x^2$  критер=6,61).

### Δүгнэлт:

1. Томуугийн A(H1N1) вирусийн халдвартын эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн үед өвчтөний тал хувьд нь ЦРЗ хэвийн байв. Эмнэлзүйн хөнгөн, дунд хэлбэрийн үед ЦРЗ-т хэвийн бус өөрчлөлт нь перибронхиал өөрчлөлт давамгайлж байгаа нь бусад нийтлэг тохиолдог амьсгалын доод замын вирусийн халдвартын үед гардаг рентген шинжтэй ижил байлаа.

2. Эмнэлзүйн хүнд хэлбэрийн үед ЦРЗ-т хоёр талын, симметрик тархалттай бүүдгэр шилний шинжүүд болон хатуурал дангаараа болон хавсарсан байдлаар илэрч байна. ЦРЗ-т 2 талын тархалттай, уушгины хэд хэдэн талбайг хамарсан бүүдгэр шилний шинж нь перибронхиал ба хатууралттай хавсарсан өөрчлөлт илрэх нь амьсгалын дутагдал, цаашлын ноцтой хүндэрэлийг урьдчилан тооцож болохыг харууллаа. ЦРЗ-т гарч байгаа дээрх өөрчлөлт нь томуугийн A(H1N1) халдвартай өвчтөний оношлогоо, эмчилгээний асуудал чухал үүрэг гүйцэтгэж байна.

## Гялтан хальсны үрэвслийн шингэннийг хэт авиан шинжилгээгээр оношлох нь

О.Баатарчулуун  
Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв

Манай улсад сүүлийн жилүүдэд уушгини гялтангийн үрэвсэл ихэссээр байна. СТСА-ны дунд мэдээгээр 2005 онд уушигны бус эрхтний сүрьеэгийн 39.4%, 2009 онд уушигны бус эрхтний сүрьеэгийн 51% нь уушигны гялтангийн үрэвсэл байв. Цээжний хөндийн хэт авиан шинжилгээ (ЦХХАШ) нь манай улсын практикт бараг ашиглагдахгүй байгаа ч сүүлийн жилүүдэд зарим судлаач эрдэмтэд (Ж.Цэцэгээ Э.Амарсанаа) ЦХХАШ-ээр уушигны эмгэгийг оношлох боломжуудыг судалсаар байна. ЦХХАШ нь цээжний хөндийн зарим эмгэгүүдийн үед дүрслэл оношлогооны бусад аргуудаас илүү оношлох талтайг судалсан байна (В.И.Репик 2000 он.) Жишээ

нь: Гялтан хальсны шингэн (ГХШ)-ийг 100%, уушигны хатгааг 85-100% оношлоно.

**Зорилго:** Цээжний гялтангийн шингэнийг хэт авиан шинжилгээгээр оношлох боломж ба түүний давуу талыг судлах

**Материал, арга зүй :** Судалгааг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн Клиникт 2009.03.12-2009.06.12 нь хооронд хэвтэн эмчлүүлэгч нараас “сүрьеэгийн эхо кабинет”-д ГХШ-тэй оношлогдсон 71 эмчлүүлэгчийг тохиолдлын аргаар сонгож авсан.

Цээжний хөндийг ЦХХАШ-ээр хараадаа шинжлүүлэгчийг стандарт буюу хэвтээ байдалд элэг дэлүү харах аргачлалаар мөн уутлагдсан шингэнийг шаарлагатай тохиолдолд суугаа байрлалд хавирга хоорондын завсраар эгэмний дунд, суганы дунда, далны шугамуудаар датчикаа байрлуулж харсан.

3.5 МГц давтамжтай Хятад улсад үйлдвэрлэсэн EMPEROR-860 зөөврийн аппаратаар оношлогоог хийсэн.

**Үр дүн:** Эмчлүүлэгчдийн 42 (59.1%) нь эрэгтэй, 29 (40.9%) нь эмэгтэй байв. Насны хувьд 16 нас хүртэлх хүүхэд 10 (14.8%), 16-с дээш настай 61 (85.92%)-ийг эзэлж байв. Оношийн хувьд гялтан хальсны үрэвсэл болон цээжний хөндийн идээт үрэвсэл 50 буюу (70.4%), нэвчдэст болон голомтод сүрьеэ 15 (21.1%), тархмал хэлбэрийн сүрьеэтэй 6 (8.5%) байлаа.

ЦХХАШ-ээр судлахад янз бүрийн хэмжээтэй чөлөөт шингэн 52 (73.3%), уутлагдсан буюу хязгаарлагдмал шингэн 13 (18.3%), дотроо олон тооны таславч бүхий “зөгийн үүр мэт” эхо холимог ойлтой шингэн 6 (8.5%) тохиолдол тус тус тодорхойлогдов. Судалгаанд хамрагдсан хүмүүс 100% рентген шинжилгээгээр онош тохирч, дотроо олон тооны таславчтит ГХШ-тэй 4 өвчтөнд мэс засал хийж оношийг баталсан.

#### Дүгнэлт:

1. Цээжний хөндийн хэт авиан шинжилгээ нь ГХШ-ийг 100% оношлох боломжтой гэж үзлээ.

2. Уутлагдсан болон ГХШ-ийг үед хэт авиан шинжилгээний хяналтан дор хатгалт хийх цэгийг сонгох, цаашид эмчилгээний үр дүнг давтан хянах боломжтой.

3. Дотроо олон тооны таславчуудтай “зөгийн үүр мэт” плевритийн үед эмчилгээний тактикийг сонгоход онцгой ач холбогдолтой. Энэ нь хатгалтын тоог цөөрүүлэх эмчилгээний хугацааг бодиносгох боломжтой юм.

Сахуугийн хүнд хэлбэр (тархмал, субтоксик эсвэл хордлогын) Ig бага, гол цитокин IL-1-н дутагдалтай өвчтөнүүдэд антитоксик (хордлогын эсрэг) антител багаар үүссэнтэй холбоотойгоор илэрдэг.

Псевдотуберкулезын ужиг явцыг эмгэгийн цочмог үед эсийн ба шингэнний дархлаа хангалтгүй идэвхижиж IFN-γ ба өвөрмөц антителын ялгаралт муу байх нь нөхцөлдүүлдэг.

Нилээд халдвартуудын үеийн хүүхдийн дархлааны хариултын онцлогуудыг судалснаар иммунопатогенезын урьд нь тодорхойгүй байсан чиглэлүүдийг илрүүлж, халдвартын явцын иммунологийн алгоритмын прогноз ба эмчилгээний тактикийг санал болгох боломжтой боллоо. Өвчтөн бүрийн дархлааны хариултын онцлогийг тооцож иммуны профилыг оношилсноор, эмгэгийн хүндрэл

үүсэх эрсдэл ба төгсгөлийн орчин үеийн прогноз дэвшүүлэхэд амжилттайгаар ашиглаж болох талтай. Энэ нь иммуномодуляторуудыг үндэслэлтэйгээр зөвлөх боломжийг олгож байна.

Нилээд хэдэн халдварт эмгэгийн үед суурь эмчилгээнд өөр өөр чиглэлтэй дархлаа сайжруулах эмчилгээг бил явуулсан.

"B" ба "C" вируст цочмог хепатиттай эмгэгийн эрт үед иммунны статусын өөрчлөлттэй, дархлааны шингэнний ба эсийн салааны хангалтгүй сөдөөлтөөс шалтгаалсан эмгэгийн тааламжгүй явтай өвчтөнүүдэл дархлаа сайжруулах эмчилгээг иммунны механизмуудыг сөдөөх зорилгоор сонгон авсан Циклофероноор явуулсан. Эмгэгийн эрт үед эмчилгээ үр дүнтэй болж цочмог "B" вируст хепатиттай өвчтөнүүдэлдэгээрсэн.

Иерсиниозны халдвартын жигд бус явц, иммунореактивностийн онцлогийг харгалзан үзээд шалтгааны эсрэг эмчилгээнд иммунокорректор нэмэх зайлшгүй шаардлагатай учраас бил Циклоферон, ликопид, виферон ба полиоксидонийг эмчилгээнд хэрэглэсэн.

Циклофероны таблетик хэлбэрийг хэрэглэхэд полиморф экзантэм хурдан ( $4,9 \pm 0,5$ -н эсрэг  $3,5 \pm 0,2$  хоног) арилж, стационарын эмчилгээний үргэлжлэх хугацаа богиносож ( $18,9 \pm 0,6$  хоногийн эсрэг  $13,2 \pm 0,3$  хоног), катамнезын ажиглалтын явцад цочмог үедээ циклоферон авсан хүүхдүүдэд эмгэгийн дахилт тун цөөн (харьцуулалтын бүлэгт 18%) 9%-д нь тохиолдож байлаа.

Циклоферон эмчилгээний дүнд дархлааны хариулт сөдөөгдөж шитотоксик лимфоцитын (CD8) төвшин, интерлейкин-2-г эсэд зөөвөрлөдөг лимфоцит (CD25)-н тооны өсөлт ажиглагдаж байлаа.

Бэлдмэлийн дархлал дэмжих үйлдлийн нөлөөгөөр үрэвслийн цитокины (TNF-альфа ба IL-1b) төвшин эмчилгээний дараа хяналтын бүлгтэй харьцуулаад буурч байлаа. Циклоферон нь эсрэгбиеийн хариултыг сөдөөх нөлөөтэй нь тогтоогдсон. Ийм байдлаар, Циклофероныг эмгэгийн эхэн үед зөвлөх нь зүйтэй байна.

Ликопидын дархлааны нөлөөг иммунограммд нэг чиглэлтэйг тогтоолоо. CD3+ ба CD6+ лимфоцитын тоо мэдэгдэхүйц ихсэж, CD25+-н позитив маркер болох эсийн тоо нэмэгдэж, CD20+-н тоо буурч байлаа. Үрэвслийн цитокин TNF-альфа-гийн төвшин буурч байв. Эндээс харахад, Ликопид бэлдмэл иерсиниозын халдвартын сэдрэлт ба дахилтын комплекс эмчилгээнд заалттай байна.

Иерсин ба Эпштейн-Баррын вирусийн хавсарсан цочмог халдвартын үед вирефероноор эмчилэхэд ам, залгиурын гэмтэлд голчлон нөлөөлж өнгөр эрт арилж, хамрын амьсгал сэргэж, харин лимфопролифератив синдром удаан явагдаж,

тунгалагийн буличирхайн томролт 2 долоо хоногоос илүү үргэлжилсэн. Иерсиниоз ба Эпштейн-Баррын микст халдварын үед виферон эмчилгээ иммунны статус нөлөө үзүүлсэнгүй.

Ийм байдлаар, моно ба микст халдвартай псевдотуберкулез ба гэдэсний иерсиниозтой өвчтөнүүдэд ягаатай дархлааны эмчилгээг бил явууллаа. Суурь эмчилгээнээс (шалтгааны, харшлын, хэсэг газрын) гадна халдварт мононуклеозын цочмог ба дахилтат хэлбэрийн комплекс эмчилгээнд дархлаа зүгшрүүлэх эмчилгээ хийв.


Бид виферон, циклоферон, полиоксидоний, ликопид, лейкоцитарны интерферон ба лейкинферионыг эмчилгээнд ашигласан. Жилийн туршид хийсэн катамнезын ажиглалтаар хүүхдүүдэд дурын иммуномодуляторыг ашигласнаар халдварт мононуклеозын ужиг хэлбэртэй хүүхдийн тоо цөөрч, лейкоцитын интерферон ба лейкинферион тэдгээрийн үүсэлтийг бүрэн зогсоож байлаа. Дахилтын тоо лейкинферион лейкинферион ашигласан ўе эсвэл вифероны дараа удаан хугацаагаар Циклоференоор дархлаас сайжруулах эмчилгээ хийсэн тохиолдолд ажиглагдаж байлаа. Виференоор дангаар нь эмчилгээ явуулсан үед эдгэрэлтийн үед бактерийн халдвараар өвлөх явдал нэмэгдэж байгаа нь илэрлээ. Ийм байдлаар, халдварт мононуклеозын эмчилгээнд вирусийн эсрэг дархлаа сайжруулах эмчилгээ зайлшгүй хэрэгтэй байна. Бэллмэлийг сонгоходоо тухайн өвчтөний дархлааны урвалын вариантаас хамааруулан сонгоно. Хүүхдэд “эсийн” хариулт байгааг тодорхойлсон үед эмчилгээнд виферон, лейкоцитын интерфероныг лейкинферионтой хамт хэрэглэх нь зүйтэй. “Шингэнний” вариантыг тодорхойлсон бол вифероны 10 хоногийн курсыг Циклоференоор нэмэгдүүлж явуулах нь зүйтэй.

Ийм байдлаар, халдварын явц бие биенээ нөхөж байдаг шингэнний болон эсийн хариултын баланслагдсан байдлаас хамаардаг. Зарим эмгэгийн үед эсийн ба шингэнний дархлааны тэнцвэрт байдал тохиromжтой бол, бусад эмгэгүүдийн хувьд үр дүнтэй хамгаалалт ба халдварын агентын элиминаци Т-хелперын хариулт Th1 ба Th2-н чиглэлд трансформации болсноор нөхцөлдөж байдаг.

Иммуногенезын тодорхойлогдсон вариантаас

тухайн халдварын үед шууд ихэсгэх шаардлагатай дархлааны тэр механизмыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн өвөрмөц дархлааны эмчилгээний үр дүн шалтгаална.

**Хүснэгт 3**  
**Халдварын жигл бус явцын Иммунопатогенез**  
**Орос хэлнээс орчуулсан: ПОЛИСАН фирмийн эмч**



**Төлөөлөгч Б.Ахагвасүрэн**  
**Хянасан: Редакцийн зөвлөлийн гишүүн АҮ-ны доктор**  
**Р.Оюунгэрэл**

**Ном зүй:**

Вирусийн халдвар	Бактерийн халдвар		
Халдварын хэлбэр	Факторын цочмог үеийн дефицит	Халдварын хэлбэр	Факторын цочмог үеийн дефицит
Эпид пароитит-панкреатит	АТ лок,IgA	Дифтери,хүнд хэлбэр	ИЛ-1,АТ, IgA, IgG, IgM,
Ранний менингит	АТ лок,IgA	Псевдотуберкулез	IFN-γ,АТ
Поздний менингит	АТ лок,АТ сист	Гэдэсний иерсиниоз, ужиг хэлбэр	ИЛ-2,АТ
Ранний орхит	IFN-γ	Гэдэсний иерсиниоз, дахилтат	ИЛ-2, IFN-γ,АТ
Поздний орхит	АТ лок	Боррелиоз, хүндэртэй	IFN-γ, ФНО-α
Инф мононуклеоз, дахилт	IFN-γ, ФНО-α	Боррелиоз, архаг хэлбэр	IFN-γ, ФНО-α,ИЛ-8,АТ
Гепатит B, ужиг хэлбэр	IFN-γ, ФНО-α, ИЛ-1,ИЛ-4, IgA, IgM, IgE		
Гепатит C, архаг хэлбэр	IFN-γ, ИЛ-1,ИЛ-8, IgA, IgE		

1. М.Г.Романцов, Т.В.Сологуб, (2006): Состояние клеточного и гуморального иммунитета при инфекциях у детей и его регуляция с помощью иммуномодуляторов. Противовирусная терапия инфекционных болезней детского возраста: Сборник научных статей /Под редакцией, -М., -стр 4-19

## ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ҮЕД ПРОБИОТИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХИЙН АШИГ ТУС

Д. Цэцэглэн Э. Баттөмөр  
Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв

Орчин үед хүн ба амьтны биед ашиг тустай амьд бичил биетэн агуулсан (Probiotic), чиглэсэн үйлчилгээтэй (functional food) сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлага тавигдаж байна. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь хodoод, гэдэсний замын нянгийн тэнцвэрийг зохицуулж, хоол боловсруулах үйл ажиллагааг сайжруулж, аминдэмийгний лэгжүүлэхээс гадна дархлааны системийг сайжруулах замаар хүний эрүүл мэндэл эерэг нөлөө үзүүлдэг байна.

Дэлхий дахина цочмог суулгат өвчинеөр жилд 1 тэрбум гаруй хүн өвчилиж, хүүхдийн өвчлөл нас баралтын гол шалтгааны нэг болж байна. АНУ-д жилд 100 сая хүн суулгат өвчинеөр өвчилдэг ба үүний 10% нь эмчийн зөвлөгөө авч, 250000 өвчтөн нь хэвтэн эмчлүүлж, 3000 орчим нь нас бардаг ажээ. Хөгжиж буй орнуудын хүн амын дундах нас баралтын нэг гол шалтгаан нь цочмог суулгат өвчин бөгөөд жил бүр 5-8 сая хүн нас бардаг байна. Цочмог суулгат өвчиний гол үүсгэгчид нь *Salmonella*, *Shigella*, *E.Coli*, *Camylobacter*, *Vibriocolerae*, *Yersinia* бөгөөд үүний дотор Сальмонеллийн халдварт нь *Salmonella*-ийн төрлийн нянгаар үүсгэгдэг гол төлөв хodoод, нарийн гэдэсний үрэвслийг үүсгэдэг цочмог суулгат халдварт өвчин юм.

Сальмонеллээзын халдварт нь дэлхийд өргөн тархсан халдварт бөгөөд хоолны хордлого, эмнэлгээс шалтгаалах халдварт хэлбэрээр тохиолдож бага насын хүүхдийн нас баралтын шалтгаан болсоор байна. Халдвартын эх үүрхай нь гахай, үхэр, муур, нохой, шувуу зэрэг мал, амьтад шавьж хорхой зэргээс гадна өвчтэй хүн, нян тээгч нь мөн халдвартын эх үүрхай болдог байна. болно. Эдгээр амьтана өвчин бүдэг балархай буюу заримдаа эмнэлзүйн шинж тэмдэг тод хэлбэрээр явагддаг. Хүнсний бүтээгдэхүүнд сальмонеллын төрлийн нянгууд их хэмжээгээр агуулагдан түргэн үржих олширч байдаг. Халдвартлагдсан сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, өндгөн бүтээгдэхүүн, загас, тахианы мах зэргээр халдвартын үүсгэгч дамжиж хүн, амьтаниг өвчлүүлдэг байна.

Сальмонеллээзийн үүсгэгч болох *Salmonella choleraesuis*-ийг анх 1885 онд Дэвида Сэльмон өвчтэй гахайнаас илрүүлсэн байна. 1888 онд А. Гертнер хоолны хордлогот халдвартын дэгдэлтийн үед үхрийн махнаас *Salmonella enteritidis*-нянг илрүүлсэн тэр үес хойш өвчтэй хүн, малын бие махбол, хоолны хордлогот халдвараар өвчилсөн хүнээс

сальмонеллын бусад зүйлийг илрүүлжээ. 1900 оны үед энэ халдвартыг хоол хүнс ба усны хэрэглээнээс үүсэж байна гэж үзсэн. Сальмонеллын ангилыг Ф.К Кауффман ба П. Уайт нар боловсруулсан. *Enterobactericeae* аймгийн *Salmonell*-ийн төрлийн нян нь сунасан хэлбэртэй төгсгөл нь дүгрэг 0.7-1.5 x 2-5 мкм хэмжээтэй 8-45°C-д өсөж үрждэг онцлоготой, хөдөлгөөнтэй, факультатив анаэробик грам сөрөг савханцар юм. Глюкоз ферментлэдэг ба нүүрс ус, хүчил, хий үүсгэдэг. Лактоз ферментлэдэггүй. Үүнэд арабиноза, мальтоза, маннит, манноза, ранноза, сорбит, трегалоза, ба ксилаза зэрэг нүүрс усуудыг үүсгэдэг. Погеса-проскаурэрын урвал сөрөг, оксидаз сөрөг, каталаза эерэг байдаг. 2000 ийлдэс хүрээтэй ба их биений О эсрэгтөрөгчийн цуглуулгаар 46 ийлдэс бүлэгт хуваагдана.

Түүнчлэн Н эсрэгтөрөгчийн бүтцээрээ 2500 ийлдэс бүлэгт хуваагддаг байна. Сальмонелл нян нь гадаад орчинд удаан хугсаанд хадгалагддаг. Фекално-Оральный замаар хоол, хүнсээр халдварт дамжих үндсэн нөхцөл нь болдог. Усанда 5 сар, маханд ойролцоогоор 6 сар, махан шанз, махны салад ( үүнэд лаазалсан маханд 1 жил хүртэл ), жимс ба ногоонд 0.5- 2.5 сар, сүүнд 20 өдөр, тослог хоормогт 1 сар, цөшгийн тосонд 4 сар, бяслаганд 1 жил, өндөгний хуурай нунтагт 3-9 сар, өндөгний хальсанд 17-24 өдөр, шар айрганд 2 сар хүртэл, шороонд 9 сар хүртэл амьдарч чаддаг байна. Тахианы өндөгөнд *Salmonella enteric* нь нэвтэрч ороод цааш өндөгний хальсиг гэмтээхгүйгээр дамжиж урганд өсөж үрждэг байна. +70°C-ын температурт 4-5 минутанд үхдэг.

Үг нян нь утсан болон давсалсан бүтээгдэхүүнд өсөж үржих мөн хор төрүүлэх шинж нь сулардаг онцлоготой. Халдварт үүсгэгч нь зэрлэг амьтад тэжээмэл шувуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр, мөн шинж тэмдэггүй нян зөөвөрлөгчөөр халдварт дамжиж байна. Үүнэд үхэр болон гахайн махаар 50% дамждаг. Муур, нохой зэрэг амьтад уг нянг 10%, бусад мэрэгчилдээр 40% хүртэл зөөвөрлөдөг байна. Энэ өвчин нь цахтай, тагтаа, бор шувуу, хар тодол зэрэг шувуудад өргөн тархсан байдаг. Эмнэлгийн нөхцөлөл онцгойлон *Salmonella typhimurium*, *Salmonella* *Haifa* нянгууд халдвартыг үүсгэдэг.

Ходоод болон амны хөндий нь өвөрмөц бус хамгаалах хүчин зүйл болж өгдөг. Нянгийн эндотоксин (термостабильный, термолабильный) ялгаран гараад улаан эсийн мембранд бэхлэгддэг.

Тойм лекц, зөвлөлгөө

Үүсгэгч нь гиалуронидаза эсгэгийн тусламжтайгаар улаан эсийн дотор нэвтрэн ордог байна. Мөн уг нян нь гэдэсний хүчүүр эсүүдийн бичил цэлмэнгүүдийг гэмтээж бүтцийн өөрчлөлтөд хүргэдэг ба улмаар гэдэсний ханын салст бүрхүүл дор нуугдаж хүчүүр эсд нэвтрэн ордог, залгиур эсийн эсрэг нөлөөлдөг, үрэвслийн урвал үүсгэхийг нөхцөлбүлдэг. Өөрөөсөө дотоод хор буюу липополисахаридыг чөлөөлдөг ба энэ нь хордлогын хам шинжийг үүсгэдэг.

Липополисахаридын идэвхжилийн зам нь циклооксигеназ ба липооксигеназ замаар дамжин явагддаг. Липооксигеназын зам идэвхжсэнээр лейкотриенийг үүсгэдэг ба үүний нөлөөгөөр зүрхний шахуургыг багасгадаг, судасны ханын нэвчимтхий чанарыгнэмэгдүүлдэг. Мөндегрануляцынурвал болон хемотаксисыг идэвхжүүлдэг. Циклооксигеназын зам идэвхжүүлсэнээр простанойдыг үүсгэдэг. Үүнэд Тромоаксан, Простогландин Е, Простогландин F 2 багтдаг. Простанойд нь ялтас эсүүдийн агрегацыг идэвхжүүлж бичил судаснуудад тромбо үүсэлтийг нэмэгдүүлж АВС хам шинж болон захын судаснуудын бичил эргэлтийн алдагдалыг үүсгэдэг ба бодисын солилцооны өөрчлөлтөнд хүргэж, эд эрхтэнд хүчилэг бүтээгдэхүүнүүд хуримтлагдахыг нөхцөлбүлдэг. Үүнийг бодисын солилцооны хүчилшил гэж нэрлэдэг.

Простогландины нөлөөгөөр гэдэсний бичил сүүүдээр шингэн ба эрдэс бодисуудын ялгаралт нэмэгддэг ба гөлгөр булчингийн агшилтыг нэмэгдүүлсэнээр гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэдэг эцэст нь билемахбодийг усгүйжилтэнд хүргэж суулгалт үүсгэхийг нөхцөлбүлдэг байна. Энтеротоксины нөлөөгөөр усгүйжилт дамагайлж байгаа нь харагдаж байна. Мөн аденилатциклизын тогтолцоог идэвхжүүлдэг байна. Нянгийн хорын нөлөөгөөр зүрх судасны үйл ажиллагаа алдагддаг. Артерийн даралт буурах зүрхний цохилт олширдог байна. Эмнэлзүйн хувьд тархины хүнд хавганшилд хүргэдэг онцлоготой.

Түүнчлэн бөөрний бичил цусан хангамж алдагдаж улмаар тэжээлийн хомдолд хүргэсэнээр усгүйжилтэнд ордог байна. Цаашид бөөрний хүрц дутагдал илэрдэг ба эхний эмнэлзүйн шинж тэмдэг нь олигоурия, цаашилаад цусны тогтоц шүлтээг талрууугаа хазайна. Халдварт хүндэрвэл эсийн болон шингэний дархлааны дутагдалд хүргэдэг байна. Бичил харуурын шинжилгээгээр гэдэсний ханын салстын доорх бүрхүүлийн судаснуудад шус харвалт өгсөн байгаа нь харагдлаг байна.

Пробиотик гэдэг нь амьд бичил биетнийг агуулсан хүнсний бүтээгдэхүүн бөгөөд хүн болон амьтана бие маходод ашигтай нян юм. Сүү, сүүн бүтээгдэхүүн болгон пробиотик бүтээгдэхүүн тооцогдохгүй ба тодорхой шалгуураар гаргаж авсан

нянгийн цэвэр өсгөвөрөөр баяжуулсан хүнсний бүтээгдэхүүн гэж үздэг. Сүүн хүчлийн нянгуудын ашигтай нэг шинж бол өөрийн биеэс өвчин үүсгэгч нянгийн эсрэг үйлчилгээтэй антибиотик төст болон биологийн идэвхтэй бодис ялгаруулдаг бөгөөд стафилококк, эшерхи коли, сальмонелл зэрэг өвчин үүсгэгч нянгуудад серог нөлөө үзүүлдэгийг тогтоожээ. Сүүн хүчлийн нянгаас хамгийн их судлагдсан нь *Lactobacillus* spp омогууд ба *Bifidobacterium*, *Lactococc* – ийг эмгэг төрөгч, хоруу чанаргүй болохыг баттай тогтоожээ. Хүний хоол боловсруулах замын нянгийн бичил орчин нь эзэн биед аливаа гаж нөлөө үзүүлэхгүйгээр өөр төрлийн нянгийн үржлийн эсрэг биологийн хамгаалалт тогтоох, дархлаа идэвхжүүлэх, төрөл бүрийн бодисын солилцоог зохицуулах нөлөө үзүүлдэг нь нэгэнт тодорхой болжээ. Пробиотик бүтээгдэхүүн нь гэдэсний ханын салст бүрхүүлийн үрэвслийг багасгах, хэсэг газрын дархлаа сэдээх үр дүнтэй юм. Сүүн хүчлийн нянгууд нь үрэвсэл урвалын өмнөх цитокин буюу (IL-12) -ын үүсэлтийн төвшинг идэвхжүүлсэнээр хэсэг газрын дархлааг тогтвортой байлгахад нөлөөлдөг байна.

Мөн гэдэсний хүчүүр эсд эмгэг төрөгч нян наалдах үйл ажиллагааг saatuuulж хориглодог ба гликпротеин холбогдохыг сайжруулдаг байна. Пробиотик бүтээгдэхүүнийгэй зохистой хэрэглэх нь халдварт өвчиний сэргийлэлт, эмчилгээнд чухал ач холбогдолтой юм.

#### Ном зүй :

1. К. Д. Пяткин , Ю. С. Кривошеин (1980): Микробиологи.
2. К.Д. Пяткин (1962): Медицинская микробиология
3. С.Н. Соринсон., В.В. Шкарин., (1998): Краткий справочник по инфекционным болезням
4. Г. Санжмятав, (2007): Анагаах ухааны эмнэлзүйн бичил амь судлал
5. Монгол Улсад бүртгэгдэж байгаа хүний халдварт өвчиний өнгөрсөн, одоо, ирээдүйн төлөв байдал, (2008) Ерөнхий редактор Н. Наранбат анагаах ухааны доктор., УБ
6. Rufus K. Guthrie (1991) *Salmonella*
7. Clinical Diagnosis and Management by Laboratory Methods, (1996)
8. Gerald L. Mandell., John E. Bennett Raphael Dolin (2005): Principles and Practice of Infectious Diseases VOLUME 2.
9. Henry DIsenberg, (1992): ASM Clinical Microbiology Procedures Handbook VOLUME 1,2.

## ЦЭЭЖНИЙ РЕНТГЕН ЗУРГИЙН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛД

Г.Нандинцэцэг, Л.Тунгалаг  
Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

Цэргий түрхээний шинжилгээгээр сүрьеэгийн савханшар илрүүлэх нь ушигны сүрьеэг оношлох хамгийн чухал оношлогоо боловч цээжний рентген зургаар (ЦРЗ) уушгин дахь өөрчлөлтийн тархалтыг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг. Түүнчлэн сүрьеэ/ДОХ хавсарсан тохиолдол, хүүхдийн сүрьеэ болон ушигны бусад эмгэгийн ялан оношлогоона ЦРЗ чухал байр суурь эзэлдэг.

Эмнэлгийн 5 үндсэн боловсон хүчин чанартай ЦРЗ гарган авах үйл явцад оролцдог. Үүнэ: сүрьеэгийн хяналтын эмч, эмчлэгч их эмч/рентгений их эмч, рентген техникч, менежер, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер.

Сайн чанартай рентген зураг гаргаж авахын тулд доорх хүчин зүйлсүүд чухал нөлөөтэй. Үүнэ:

1. Рентген аппаратын зохион байгуулалт
  - Рентген хоолойн фокус болон зургийн хальс 2-ын хооронд 140-200см байх
  - KV: 100-120kV байх
  - Рентген туяа өгөх хугашаа 0.05 секундээс бага байх
  - mA: 100mA-аас илүү байх
  - mAs – нь хувь хүний байдлаас хамаарна
  - Шүүгч тор нь зургийн тод ялгарлыг сайн болгодог.
  - Рентген аппаратын хэвийн ажиллагааг хангах зориулалтын өндөр хүчдэл болон цахилгаан гүйдэл тогтвортжуулагч байх хэрэгтэй.
  - Рентген техникч рентген аппаратын хэвийн үйл/а-г хариуцах ёстай.
  - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер нь рентген аппаратыг засах, тохиргоо хийх үүрэгтэй.
2. Рентген хальс болон хальс баригчийн (кассет) эмульсэн давхаргын тохироо

Рентген туяаны тусгалд (X-ray) кассетны эмульсэн давхарга ногоон, шэнхэр өнгөөр тодорч харагддаг бөгөөд энэ шинжээр нь кассетыг ногоон ба шэнхэр гэж ангилдаг. Рентген хальс болон кассетийн эмульсэн давхарга ижил өнгөтэй байвал зохимжтой. Түүнчлэн кассетийн эмульсэн давхаргыг тогтмол цэвэрлэж байх шаардлагатай.

3. Хальс боловсруулах харанхуй лабораторийн зохион байгуулалт
  - Рентген хальс боловсруулах танк ба улаан гэрэл хоёрын хоорондын зайд 150см-аас их байх хэрэгтэй.
  - Лабораторийн өрөө 10-24%, 30-50% чийгшилтэй байх ёстай.

• Лабораторид гаднаас гэрэл орохгүй байх ёстай. Гаднаас гэрэл орсны улмаас рентгэн зурагт артефакт үүсдэг байна.

• Лабораторийн өрөөнд гар утсаар ярж болохгүй. Учир нь рентген хальсыг гэмтээнэ.

• Улаан өнгийн гэрэл 15W байх хэрэгтэй. Гар цэвэрхэн, хуурай байх хэрэгтэй.

4. Рентген хальс боловсруулах техник

• Тодруулах уусмалыг (I хор) гүйцэд уусгаж найруулан бэлтгэх ёстай. I хорыг зааврын дагуу зөв найруулаагүйн улмаас зургийн чанарт нөлөөлнө.

• I хорона өндөр температурт, урт хугашаагаар зураг угаах нь зургийг хатуу хар болгоно. Хугаша дууссан буюу муудсан хоронд зураг бүдэг шайвар гарна.

• Бэхжүүлэх уусмал (II хор) 5мин-аас доошгүй хугашаанд байлгах хэрэгтэй.

• Хатаах температур 35%-ээс ихгүй байх ёстай. 30 мин-аас доошгүй хугашаанд усаар угаах хэрэгтэй. Гүйцэд угаагаагүй зураг шар түятай болсон байдал.

• Гараар болон автомат угаагчид усны филтер холбох нь зургийн чанарыг дээшлүүлдэг.

• Автомат хальс угаагчийн хорны уусмалын температур, угаах хугашаа, хатаах температур зэргийг дагалдах зааврын дагуу суулгана. Гар угаалтыг бодвол автомат хальс угаагч нь тогтмол техникийн тусламж үйлчилгээг илүү шаардлаг. Ус болон цахилгааны тогтмол эх үүсвэртэй холбогдсон байна.

Дижитал рентген аппаратын давуу талууд

- Комьютерийн тусламжтайгаар зургийн чанарыг тохируулж болно.
- Зургийг хялбар, хурдан боловсруулна.
- Рентген зураг оношлогоо дэлгэц дээр шууд гарна. (Рентген хальс ба харанхуй лабораторийн шаардлагагүй)

### Ном зүй:

1. Handbook for district Hospitals in resource constrained settings on Quality Assurance of Chest Radiography: for better TB control and health system strengthening. +: TBCTA, p.1-25.;
2. Manual of darkroom technique. World Health Organization Basic Radiological System. (1985): p.1-23.;
3. Peter J. Lloyd. (2001): Quality Assurance Workbook for radiographers & radiological technologists. WHO.;
4. Пүрэвжав Т., Онхуудай П ба бусад. (1989): Хүн амд үзүүлэх рентген-радиологийн тусламжийн товч лавлах. Улаанбаатар, х.12-13.;
5. Гончигсүрэн., Д ба бусад. (2009) : Дурсц оношлогооны гарын авлага., Рентген анатоми, цээж болон ушигны системийн зургийг үнших, ДЭМБ, х.17-18.;

Товч мэдээ, ажиглалт

Томуугийн үндэсний зургадугаар зөвлөлгөөн

Томуугийн үндэсний зургадугаар зөвлөлгөөн 2010 оны 10 дугаар сарын 7-8-нд “Сүнжин Гранд” зочид буудалд амжилттай болж өндөрлөв. Үндэсний зөвлөлгөөн ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, профессор Н.Хүрэлбаатар нээж, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Монгол улс дахь АНУ-ын ЭСЯ-ны Эрүүл мэндийн хэлтсийн дарга К.Бурнет, ДЭМБ-ын Монгол улс дахь Суурин төлөөлөгч, анагаах ухааны доктор Р.Виват, ОБЕГ-ын дарга, тэргүүн комиссар Ц.Амгаланбаяр нар зөвлөлгөөнд оролцогсод мэндчилгээ дэвшүүлэв.

Анхдугаар нэгдсэн хуралдаанд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн зөвлөх Ж.Петрик “Томуу өвчний дэлхий дахины байдал”, ХӨСҮТ-ийн Амьсгалын замын халдварт өвчний тандалтын тасгийн эрхлэгч А.Бурмаа “2009-2010 оны томуугийн цартахлын Монгол Улс дахь эпидемиологийн тандалтын дүн”, ОБЕГ-ын дэд дарга, комиссар Т.Бадрал “2009-2010 оны томуугийн цартахлын үед Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, цаашдын зорилт”, ЭМЯ-ны Эмнэлгийн Тусlamжийн Боллогын Хэрэгжилтийг Зохицуулах Газрын орлогч дарга Я.Амаржаргал “Томуугийн цартахлын үед эмнэлгийн тусlamжийн чиглэлээр ЭМЯ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ”, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй төслийн зөвлөх, Австрали улсын Мельбурний Их сургуулийн доктор Жодиэ МакВэрнон “Монгол Улс дахь Томуугийн H1N1 халдварт тархалтын эпидемиологийн загварчлал-Халдварт дамжих гол замууд болон өвчний хязгаарлах оновчтой стратегийг тодорхойлох” нь сэдвээр видео илтгэл тавив.

Хоёрдугаар нэгдсэн хуралдаанд ЭНЭШТ-ийн дэд захирал Ш.Энхтөр “Томуугийн цартахлын үед эмнэлгийн тусlamж үйлчилгээний чиглэлээр ДЭМБ-аас өгсөн зөвлөмж, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ”, Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын орлогч дарга Г.Төгсжаргал “Томуугийн цартахлын үед Сэлэнгэ аймгийн ЭМГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, цаашдын зорилт”, Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн орлогч дарга Д.Цэвэлмаа “Томуугийн цартахлын үед Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, цаашдын зорилт”,

Гуравдугаар нэгдсэн хуралдаанд ХӨСҮТ-ийн Вирус судалын лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор Б. Дармаа “Томуугийн лабораторийн

годаад болон дотоод чанаарын хяналт, үр дүн, цаашдын зорилт”, ХӨСҮТ-ийн дэд захирал Г. Сүрэнханд “Томуугийн цартахлын бэлэн байдлын үнелгээ, үр дүн, цаашдын зорилт” илтгэлүүд тавьж хэлэлцүүллээ.

Семинарын хоёрдахь өдөр буюу 2010 оны 10-р сарын 8-ны Баасан гаригийн хуралдаан “Ширээний сургалт” хэлбэрээр явагдаж 3 бүлэг болж ажиллаа. 1-р бүлэгт: “Томуугийн дэгдэлтийн үеийн нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, цаашдын зорилт” сэдвээр тархвар судлаач эмч нар, аймаг дүүргийн ЭМГ-ийн дарга, орлогч дарга нар голлон оролцож ХӨСҮТ-ийн дэд захирал Г. Сүрэнханд, ХӨСҮТ-ийн Амьсгалын замын халдварт өвчний тандалтын тасгийн эрхлэгч, анагаах ухааны магистр А.Бурмаа нар чиглүүлэн ажиллав. 2-р бүлэгийнхэн: “Томуугийн дэгдэлтийн үед бүх шатны эмнэлгийн түвшинд авах арга хэмжээ, цаашдын зорилт” сэдүйн хүрээнд өрх, дүүргийн эмнэлгийн эмч нар голлон оролцож ХӨСҮТ-ийн Эмнэлэг үйлчилгээ эрхэлсэн дэд захирал Ц.Оюунчимэг, Клиникийн I Нэгдсэн эмнэлгийн Томуугийн тандалтын клиникийн багийн ахлагч О.Чулуунбаатар, “Манал үйлс” Өрхийн эмнэлэгийн эрхлэгч эмч Б. Сарантуяа нар, 3-р бүлэгт: “Томуугийн цартахлын үеийн салбар дундын зохицуулалт, цаашдын зорилт” сэдүйн хүрээнд аймаг, дүүргийн засагдартын орлогч нар, ОБЕГ ажилтнууд, хилгаалийн ариун цэврийн хяналтын эмч нар голлон оролцож ОБЕГ-ын Гамшигаас хамгаалах бодлого, төлөвлөлт, сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга дээд ахмад Б.Ууганбаяр, ОБЕГ-ын Гамшигтай тэмцэх газрын Халдварт өвчинтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, тэргүүн ахмад Б.Дэлгэрмаа, ОБЕГ-ын Холбоо, мэдээлэл, технологийн хэлтсийн дарга, дээд ахмад Д. Ариундалай, Улсын Онцгой Комиссын нарийн бичгийн дарга, дэд дэслэгч Г.Энх-Амар нар чиглүүлэгчээр ажиллаа. Ширээний сургалтаас гарсан үр дүнг семинаарт оролцогсод шүүн хэлэлцэж санал бодлоо солилцов. Хаалтын хуралдаанаар Зөвлөлгөөнөөс гарах зөвлөмжийг хэлэлцүүлж батлав (Зөвлөмжийг арын хавтасны дотор хуудаснаас үзнэ үү).

Хуралд тавигдсан илтгэлүүдийг томуугийн үндэсний төвийн вэб-ээс дараахи хаягаар үзэж болно.

[www.flu.mn/mgl/index.php?option=com\\_content&ask=view&id=573&Itemid=52](http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&ask=view&id=573&Itemid=52)

Л.Энхбаатар  
Халдварт Өвчинтэй Тэмцэх Монголын Үндэсний Холбооны гүйшэтгэх захирал, анагаах ухааны доктор

**Ойллого**

Мэндэлсний нь 270 жилийн ойд

**Цахар гэвш Лувсанчүлтим:  
Бодоогийн эсрэг вакшин анх бүтээсэн  
Монгол эрдэмтэн оточ**


XVIII зууны нэртэй монгол оточ, Цахар гэвш Цэгонжалын Лувсанчүлтим бодоогоос сэргийлэх ерөндөг бүтээн хэрэглэсэн тухайгаа 1785 онд түвд хэлээр нийтлүүлж байсан тухай бид өмнө нь мэдээлж байсан билээ [1:69-71 ; 2:10;].

Олон талын гарамгай авьяастан, энэ суут эрдэмтний мэндэлсний 270 жилийн ойд зориулан энэ оны 8 дугаар сарын 25-ны өдөр буюу зурхайч Тэришийн зурснаар түүний төрсөн өдрөөр нь ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн “Номун гэрэл” төвтэй хамтран олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж [3], цахар гэвшийн нэгэн шавь Лувсансамдүвнямын туурвисан түүний намтрыг монгол шинэ үсгээр хөрвүүлж, хуучин монгол эхийн хуулбарыг дагуулан хэвлэсэн [4] нь цахар гэвшийн судлал дорвитой шинэ хувь нэмэр боллоо.



“Цахар гэвшийн намтар”-т түүний бодоогоос сэргийлэх ерөндөг бүтээн хэрэглэснийг нэн тодорхой бичиглэж: “... Дөчин зургаан сүүдэр зоогlossen хөхөгчин мөгөй жилд (аргын тооллоор 1785 онд)... ...Богд ламтны дэргэд байдаг шавь Цүлтимдаржай хэмээх нэгэнд цагаан цэцэг өөрийн яригтаа гарч цэцэгт боловсорсон бөгөөд түүнээс уламжлан олон шавь нар ав амархнаа цэцэгт боловсorchээ... ...дээд Богд ламтан бээр шавь Цүлтимдаржайгийн цэцэгийн

хальс түүгээр хөрөнгө болгон шинэ эм найруулж хайрласнаар, энэ зүг дэх их, бага олон ардууд өчүүхэн гэм аюул үгүйеэ маш амархнаа цэцэгт боловсров. Тэр цагт Богд ламтнаа ирээдүйг тодорхой билэгдэхийн зүүд тэмдэг ч болсон байх бөгөөд “Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах тэргүүтний бичиг”-ийг шинэ зохиов. Хожим үед ч цагаан цэцгийг хэдэн удаа тарьсан бөгөөд тэр бүгдэл ч аюул үгүйеэ цэцэг боловсрох болсны тул тоолшгүй олон ардыг амины аюулаас авран зохиосон буйй...” [4:133-135; Зураг 1] хэмээсэн байна.

Өрнө дахинаа, түүгээр уламжлан бил ч одоо болтол мөрдсөөр явваа номлолоор бол үхрийн цэцгийн цэврүүний шингэннийг хүний бодоогоос сэргийлэхээр хэрэглэсэн тухайгаа 1798 онд нийтлүүлсэн Английн эмч Эдуард Женнериийг халдварт өвчнөөс сэргийлэх ерөндгийг анх боловсруулсан судлаач хэмээн тооцдог билээ [2:11-12]. Тэгтэл монгол оточ Лувсанчүлтим бодоогоос сэргийлэх ерөндөг боловсруулах аргыг бичиглэсэн “Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах тэргүүтний бичиг” хэмээх бүтээлээ Э.Женнерээс 13 жилийн өмнө буюу 1785 онд нийтлүүжээ. Энэ бол монгол тоолын ёсоор нэг үе мултарсан хугацааны өмнө гэсэн үг.



**Зураг 1. Лувсансамдүвнямын туурвисан “Цахар гэвшийн намтар”-т бодоогоос сэргийлэх ерөндөг боловсруулан хэрэглэсэн тухайг өгүүлсэн хэсэг [4: 436]**



**Зураг 2. Цахар гэвш Лувсанцүлтимиин 11 боть сүмбумын 6 дугаар ботид орсон “Басамын тосон эм үйлдэх ёс оршивай” хэмээх зохиол бодоогоос сэргийлэх ерөндөг боловсруулах тухай бичсэн хэсэг [5: 10]**

Бодоогоос сэргийлэх ерөндөг бүтээн хэрэглэх аргын тухай Цахар гэвш "...гүвдрүүний хуурсан цагаан хальсыг ховхлон авч дээр нь үхрийн гиван, 6 сайны найрлагыг нэмнэ. Тухайлбал, гиван 7 хувь, жуган 2 хувь, гүргэм 4 хувь, задь, лиши, сүгмэл болон гагол тус бүр 4 хувь. Гүвдрүүний хуурч унасан хальсыг 9 хувийн хэмжээгээр нэмээд адистэд бүхий үрэлтэй хольж талх болгон үйлдэхэд угаалга тэргүүтэнд ариун асар хийгээд нийлсэн аргаар дээд 3 лам ер хийгээд бат сэтгэл, номыг сахигч нугуудад залирья. Эрэгтэйн зүүн хамарт хийгээд, эмэгтэйн баруун хамраар татуулж, эцэст нь лам, ядам бурханд мөргөнө..." [5:10; Зураг 2] хэмээн бичсэнээс үзвэл энэ монголоточбодоогийнвирүстэйтөрөлүхрийнцэцгийн вирус агуулсан цэврүүний шингэннийг цагаан цэшгээс сэргийлэхэд ашиглах арга сэдсэн Э.Женинерээс дахин нэг алхам урагш гишгэж, хүний хоруу өндөр вирусийг номхотгох (attenuation) амьд вакциин бүтээн хэрэглэж байжээ. Өрнийн анагаах ухаанд бол амьтны өндөр хоруу чанартай нянг фикик, химийн аргаар нөлөөлөн номхотгох болдгийг Францийн нэрт эрдэмтэн Луй Пастер 1880 онд буюу Цахар гэвш Лувсанцүлтим цагаан цэцгийн амьд, сулруулсан вакциин хийх тухай бүтээлээ туурьвиснаас хойш бараг 100 жилийн дараа л анх нийтлүүлжээ [6]. Цахар гэвшийн боловсруулсан цагаан цэцгийн вакцинаар дархлаажуулах аргын бас нэг онцлог бол салст бүрхүүлийн дархлааг ашиглаж, бодоогийн вирус хүний биед нэвтрэн орох гол замын нэг болох хамрын хөндийн салстыг дархлаажуулах талбар болгон сонгон авсан явдал болно. ЗХҮ-ын эрдэмтэд, тухайлбал академич А.А.Сморидинцевээр толгойлуулсан Ленинградын судлаачид томуугийн сулруулсан амьд вакциныг хамарт цацах, татуулах аргыг 1938 оноос боловсруулан туршиж, 1970-1980-аад онд өргөн дархлаажуулалтын түвшинда хэрэглэж байсныг [7, 8] эс тооцвол хамарт цацах, татуулах аргаар вакцинжуулах арга одоо ч их өргөн дэлгэр хэрэглэгдэхгүй байгаа юм. Харин сүүлийн жилүүдэд хамарт цацах, уулгах зэргээр халдварт орох замыг түшин дархлаажуулах нь хэрэглэхэд хялбар,


хамгаалах үр дүн сайтай болох талаар ихээхэн бичих болсон байна [9]. Иймээс бодоо өвчнөөс сэргийлэх, хамарт цацаж хэрэглэх, номхотгосон амьд вакшин анх бүтээсэн Цахар гэвш Лувсанцүлтимиин бүтээл үнэ цэнээ одоо ч алдаагүй байгаа бөгөөд бодоогоор өвчилсөн хүний цэрүүний таванд байгаа өндөр хоруу чанартай вирусийг номхотгоход ашигласан эмт бодис бүрийг нэгбүрчилэн нарийвчлан судлах нь вакшин номхотгоход болон дархлаа хүчижүүлэхэд ашиглах өрнийн анагаах ухаанд шинэ, монголын анагаах ухаанд мартагдсан бодис, технологийг нээн олоход ч хүргэж болох нигууртай.

Цахар гэвш Лувсанцүлтим гэж хэн байв аа?

Цахар гэвш Лувсанцүлтэм арванхоёрдугаар жарны цагаан бичин жил буюу Манжийн Тэнгэр тэтгэгч хааны тавдугаар онд (аргын тоолоор 1740 онд) Цахарын Шулуун Хөвөөт Цагаан хошууны Сайханнуурын баруун хөвөөндаа буй Бортолгой хэмээх газар малчин ард Цэгонжалын ууган хүү болон мэндэлжээ. Эднийхэн уг нь Ордос долоон хошуунаас дээр үед Цахар нутагт нүүн ирсэн Уйгуд овгийн хүмүүс ажээ. Лувсанцүлтимиийг 7 настайл нь авга ах Хужим нь монгол бичиг зааж сургасан гэх бөгөөд тэр үеэс 28 насыг хүртлээ өөрийн хошуу нутгийн “Бодьтыв” хэмээгч сүмээс эхлээд Долооннуур, Бээжингийн Юн хэ гүн хийдүүдэл шавилан сууж будлын гүн ухаан, цанид, чойрын номд голлон суралцахын зэрэгшээ дуун ухаан, холбон нийаруулах эрдэм, зохист аялгуу болон анагаах ухаан, одон зурхайн эрдэмд боловсорчээ. 29 наснаас 71 настайлдаа (арванхоёр дугаар жарны төмөр эр морин жилийн хоёр сарын хорин гурвандаа буюу аргын тооллоо 1810 онд) наснаас нөгцөхийг хүртэл төрсөн нутаг хошуундаа аж төрж, бүтээж байжээ. Тэрээр олон савын эрдмээр 200 гаруй бүтээл туурьвиснаас 11 боть сүмбум бүтээсэн нь одоо үеийг хүрч ирсэн азтан юм. Цахар гэвшийн намтар, бүтээлийг сонирхогсод ШУА-аас энэ онд хэвлүүлсэн намтраас [4] нь дэлгэрүүлэн үзэж болно.

**П.Нямдаваа, Ш.Болд  
Монголын Анагаах Ухааны Академи  
Номзүй**

1. Болд, Ш., Амбага, М., Сараншээг, Б., Болоршээг, Ж. **(1999):** Монгол түүргатны анагаах ухааны алларт эмч, маарамба, мэргэдийн намтар, бүтээлийн тойм (МЭ VII зууны өмнөөс XIX зууны сүүлч хүртэл), Улаанбаатар, "Одсар Системс" ХХК, 138 х.;
2. Нямдаваа, П. **(2004):** Вакцин хэмээх ээлтэй "үхэржин", Улаанбаатар, "Согоонуур" ХХК, 104 х.;
3. ШУА, Хэл зохиолын хүрээлэн, "Номун гэрэл" Төв (2010): "Их эрдэмтэн цахар гэвш Лувсанцүлтим хийгээд Монголын уламжлалт анагаах ухаан, одон зурхайн шүтэлцээ" сэдэвт ОУЭШБХ-ын илтгэлийн хураангуй, Улаанбаатар, 48 х.;
4. ШУА, Хэл зохиолын хүрээлэн **(2010):** Лувсансамдүвням: Цахар гэвшин намтар (Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит бодга Сумалишилашрибадрагийн гэгээний ерөнхийн зохиол намтырг товчийн төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мөшөөлгөгч нарны гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив), Монгол бичгээс хөрвүүлж, удиртгал тайлбар бичсэн Д.Цэрэнсодном, Д.Нараншээг, ариутган шүүсэн академич Ш.Бира, Улаанбаатар, "Бэмби сан" ХХК, 638 х.;
5. Нямдаваа, П. **(2009):** Вакцин хэмээх ээлтэй "Үхэржин", Нэмэн засварласан хоёрдох хэвлэл, Улаанбаатар, "ADMON" Хэвлэлийн үйлдвэр, 174 х.;
6. Pasteur, L. **(1880):** De l'atténuation du virus du cholera des poules, Comptes Rendus des Séances de l'Academie des Sciences, T.XCI, №17 :673-680 ;
7. Карпухин, Г.И. Галитаров, С.С. **(1981):** Профилактика гриппа, Ленинград, "Медицина", 200 с.;
8. Смородинцев, А.А. **(1984):** Грипп и его профилактика, Ленинград, "Медицина", 383 с.;
9. Holmgren, J., Czerkinsky, C. **(2005):** Mucosal immunity and vaccines, *Nature Medicine* Supplement, 11(4):S45-53;



## **English abstracts og the original research articies**

### **Epidemiological and clinical features of Erysipelas registered in Mongolia**

*B. Saruul*

Recent years,  $33,4 \pm 0,1$  percentage prevalence of recurrent erysipelas and after that type of infection, we have detected 16-50% of them had a complicity for lymphoid stasis. The researchers confirm that when they use the one of the complex treatment of correction of the Immunosystem treamtment for prevent of re-infection of erysipelas.(Pasadin N.A., 1989; Emelianova A.N 2000; Vaselieva N.G 2006; Jarov M.A., 2007)

We detect the erysipelas in Mongolia, but until now, we still don't have a united network system of detection and communication system. The reason why, we haven't do the research study on distinctive of erysipelas epidemiology, prevalence and risk factors in encompass of Mongolia. Here, our mission is to designate of distinctive of erysipelas epidemiology, prevalence and risk factors among the Mongolia.

The result of data elaborate and analysis, used of Microsoft Excel, StatSoft Statistica 6.0 program in respcetive study (including patients' disease control card and history of diseases) for total patients of 1712 who had been diagnosed and treated Ulaanbaatar city and other 21 provinces between 1996-2008. The detected number of erysipelas cases in Mongolia it's from the many years of dynamic- the frequency of incidence is weak and frequency of erysipelas case are gets high in every 3-4 years. The high incidences of erysipelas's are detected in 1998, 2001, 2004, 2006 year. During the study, erysipelas cases are common detected in Ulaanbaatar. According to the dynamic of many years, the morbidity was  $14,9$  ( $45,6 \pm 1,8\%$ ) in 100.000 population in UB,  $1,2$  ( $22,6 \pm 1,4\%$ ) in Dornod aimag. During the time, in Bayan- Ulgii province has no incidence had been detected and  $0,1-0,5$  cases are detected in Gobisumber, Bulgan, Zavkhan and Hovd provinces per 100,000 people. In Mongolia, erysipelas cases are common in summer and fall time. Its starts usually middle of the June and the peak time is August (its Warringer's Index- 229, 9%) and continues until December. From the January, the cases are gets low and the lowest incidence detected is in May. The seasonally continuing time is 6,5 months( 205days).

The result of the study, infections of streptococcus like acute ear nose and throat infections, oral infections, kidney and urinary tract acute infections, skin damages, athlete's foot are the main causes of erysipleas. Those are more affected in erysipelas prevalence. The disease usually had an average course ( $75,8 \pm 1,3$ ), while 22% of all cases had severe course and 3.1% had mild course.

Unfortunately, when people have a mild flow of any kind of disease, they don't seem to bother to get medical help, which leads to the low number of registered cases.

During the 13 years of study, deteriorating erysipelas rate was  $1,8 \pm 0,2$  0/0000 or 0.9-3.1 cases per 100.000 people. The annual average increase was 12.7%, which indicates that deteriorating erysipelas has a tendancy to increase. The study showed that women were more tendant to develop this disease, thus 75% of all cases were women. According to age relevancy, the highest number of cases ( $29,6 \pm 0,3$  %) was registered among people aged between 40-49 years. One of the clinical characteristics of erysipelas in Mongolia is that the disease mainly affects facial area (53 %) .

Ciclopheron treatment was performed on 40 pateints (main group) that were diagnosed with primary erysipelas, while control group patients were treated with standart treatment and the recovery rates of both groups were evaluated. In the main group fatique symptoms was shorter for 1.8 days ( $p < 0.001$ ), localized immflammatiion was shorter for 1.4 days ( $p < 0.001$ ) while limphatitis lasted for 1.3 days less ( $p < 0.001$ ).

#### **Conclusion:**

1. The prevalence of erysipelas in Mongolia is high and has a tendancy to increase (increase rate 12,5%). The frequency of this disease is quite weak. The disease increases in summer and winter, while August is the peak of it's infection (Waringer's index 229.0%).

2. Tonsilitis, acute ear nose and throat infections, oral infections, kidney and urinary tract acute infections, skin damages, athlete's foot are the main causes of erysipleas.

3. Most of the cases of erysipelas registered in Mongolia have an average course and affect facial area (53.3%). Bullous erysipelas is likely to increase while haemorrogic erysipelas has not been over 1.0%. 52.6% of patients infected with deteriorating type of erysipleas were aged between 40-59 years. Sex ratio is 3:1, infecting more women.

4. Some symptoms that stay unchanged even after the recovery, such as a high flow velocity of erythrocytes ( $20,3 \pm 0,09$ MM/h) and an increased number of leucocytes in primary erysipleas may lead to a detorioration of this disease.

5. Ciclopheron treatment that was used in primary cases has dicreased the detorioration from 46%-11% and changes that occurred in peripheral blood were normalized withing a shorter time.

*Mongolian journal of Infections Diseases Research*

2010 №6(37):43-47

7 figures, 3 tables and 10 references

## ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ. №6(37). 2010ОН

- З.Уранчимэг, Р.Болор, А.Оюунчимэг, Б.Дариймаа **Олон эмийн дасалтай сүрьеэтэй эмчилүүлэгчийн тулгамдсан асуудлууд**
- Ж.Улаан, Д.Чимэдноров, Б.Батсүх **Цочмог вируст хепатит В-ийн халдвартай хүхдүүдийн маркерийн шинжилгээнд дүгнэлт өгөх нь**
- Д.Энхсайхан, Ч.Майшэцэг, В.Демкин, П.Нямдаваа, **2009 онд Монгол оронд илрүүлсэн салхиниэгийн вирусийн генотипийг тодорхойлсон дүн**
- Д.Алтанцэцэг, Д.Ану, М.Алтанхүү **BACTEC 9120 Машиныг нян шудалын шинжилгээнд хэрэглэсэн нь**
- Д.Алтанцэцэг, Д.Содбаяр, М.Алтанхүү, О.Баатархүү, Ж.Сарантуяа, Д.Булган, С.Бүжинлхам, Д.Нямхүү Г.Сүрэнханд **Бактерт менингит ба уушгины хатгаа өвчиний үүсгэгчийг тодорхойлох лабораторийн тандалт**
- Д.Алтанцэцэг, Д.Ану, М.Алтанхүү, С.Бүжинлхам, Ч.Уранжаргал **Тархи нугасны шингэнэ латекс наалдуулах урвалаар Neisseria meningitidis, Haemophilus influenzae, Streptococcus pneumoniae илрүүлсэн нь**
- Б.Буянхишиг, Т.Оюунтуяа, Б.Цэрэлмаа, Н.Наранбат, Ж.Сарантуяа, С.Митарай **Олон эмэнд дасалтай сүрьеэтгэг молекулябиологийн хурдавчилсан арга илрүүлж уламжлалт аргатай харьцуулан судалсан судалгааны дүн**
- Д.Абмэд, М.А.Хаснатинов, Ж.Батаа, Г.А.Данчинова, П.Нямдаваа, Д.Ану, М.Ууганчимэг, Б.Оюунбилэг, У.Өнөрсайхан, Х.Тунгалааг **Монголд ялгасан хачигт энцефалитын вирусийн томгуудын шинжүүд**
- Б.Батсүх, Г.Ариунболд, Ш.Чинбаяр, М.Ууганчимэг, Ж.Ариунбилэг **Элэгний цочмог дутагдалийн улмаас нас барагсын эмнэлзүй, лабораторийн онлог**
- Ц.Оюунчимэг, М.Оюунгэрэл, Ш.Чинбаяр, М.Ууганчимэг, Б.Батсүх **ХӨСҮТ-ийн Халдвартын клиникт нас барсан тохиолдолуудын судалгаа**
- Ц.Оюунчимэг.С.Энхтуяа **ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тасгугуудад 2005-2009 онд нас барсан тохиолдолуудын судалгаа**
- П.Энхтамир, О.Баатархүү, Н.Наранбат, П.Янжидулам С.Энхтуяа, Б.Мөнхзүл,Р.Болор, Г.Сарангоо, Р.Оюунгэрэл, С.Цогтсайхан, М.Алтанхүү **Сүрьеэтэй өвчтөнүүдэд дархлаа зүгшүүрүүэх эмчилгээ хийсэн дүн**
- Л.Тунгалааг, Д.Гончигсүрэн, А.Пүрэвсүрэн, С.Цацрал, О.Оюунчимэг **Томуугийн A(H1N1)v вирусийн халдвартын үеийн шээжийн рентген зураг дахь өөрчлөлтийг судалсан дүн**
- О.Баатарчuluун **Гялан хальсны үрэвслийн шингэнийг хэт авиан шинжилгээгээр оношлох нь**
- Ж.Түмэндалай, Э.Сүхээ, Б.Цагаан, П.Сэлэнгэ, Г.Ариунболд **Сүрьеэ өвчиний үеийн плеврит, асцит, перикардитийн ялаган оношлогоо**
- О.Жавзандулам, Э.Сүхээ, Г.Бор, М.Цэнгэлмаа **Холголт цооролтын эмчилгээнд хэрэглэдэг аргуудын үр дүнг харьцуулан судлах**
- Ц.Ариунаа, Ч.Тунгалааг, Б.Чимэдцэрэн, **Улаанбаатар хот дахь нохойн парвовирусын оношлогоо, тархалт**
- Д.Отгонзаяа, Ч.Тунгалааг, А.Баянзүл **Адууны ям өвчиний оношлогооны дүнгээс**
- ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ**
- Б.Саруул Монгол улсад бүртгэгдсэн ёлом өвчиний эмнэлзүй, тархвар зүйн онлог
- ТОЙМ, ЛЕКЦ, ЗӨВЛӨГӨӨ**
- В.В. Иванова, Г.Ф. Железнова, И.В.Шилова **Халдвартын үеийн хүүхдийн эсийн болон шингэний дархлааны байдал ба түүнийг иммуномодуляторуудын тусламжтайгаар зохицуулах нь**
- Д. Цэцэглэн Э. Баттөмөр **Гэдэсний халдварт өвчиний үед прообиотик бүтээгдэхүүний хэрэглэхийн ашиг тус**
- Г.Нандинцэцэг, А.Тунгалааг **Шээжийн рентген зургийн чанарыг дээшлүүлэх асуудалаа**
- ТОВЧ МЭДЭЭ, АЖИГЛАЛТ**
- Л.Энхбаатар **Томуугийн үндэсний зургадугаар зөвлөлгөөн ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛЭГИЙН АНГЛИ ТОВЧЛОЛ**

- **Problems of multidrug resistant tuberculosis patients by Oyunchimeg, R.Bolor, Z.Uranchimeg , B.Dariimaa**
- **Clinical picture of acute viral hepatitis A in Mongolian children with HBsAg by J. Ulaan, Y.Dahgwadorj, D. Chimednorov,B.Batsukh**
- **Genotypes of varicella-zoster virus detected in Mongolia in 2009 by D.Enkhsaikhan, Ch.Maitsetseg, V. Demkin, P. Nymadawa,**
- **BACTEC 9120 blood culture system using in bacteriological analyze by Altantsetseg D, Anu D, Altankhuu M**
- **Laboratory surveillance for the investigation of pathogens of bacterial meningitis and pneumonia by Altantsetseg D, Sodbayar D, Altankhuu M, S., Baatarkhuu O,Sarantuya. J Bulgan.D, Bujinlkham S, Nyamkhuu.D, Surenkhand G**
- **Detection of Neisseria Meningitidis, Haemophilus influenzae, and Streptococcus pneumoniae antigens in cerebrospinal fluid specimens by directigen latex agglutination test. by Altantsetseg. D, Anu ., Altankhuu. D M, Uranjargal. Ch, Bujinlam.S**
- **Rapid Molecular Testing for Multi-Resistant Tuberculosis in National Reference TB Laboratory, Mongolia by B.Buyankhishig, T.Oyuntuya, B.Tserelmaa, N.Naranbat, J. Sarantuya, S.Mitarai**
- **Characteristics of Tick borne encephalitis virus strains isolated in Mongolia by D.Abmed, M.A.Khasnatinoff, J.Bataa, G.A.Danchinova, P.Nyamdawa, D.Anu, M.Uuganchimeg, B.Oyunbileg, U.Unursaikhan, Kh.Tungalag**
- **Clinical and laboratory Specific characteristics of died patients with acute liver failure by B. Batsukh, G. Ariumbold, TS, Chinabayar, M. Uuganchimeg, J. Ariumbileg**
- **Study of died cases in the Infectious diseases department of National Center for Communicable Diseases by Ts. Oyunchimeg, M. Oyungerel, Ts. Chinabayar,M. Uunganchimeg, B. Batsukh**
- **Study of died cases in the Tuberculosis department of National Center for Communicable Diseases by Ts. Oyunchimeg, S. Enkhtuya**
- **Result of immune-regulating treatment in active new pulmonary TB patients in Mongolia by P.Enkhtamir, O.Baatarkhuu, N.Naranbat, P.Yanjindulam, S.Enkhtuya, B.Munkhzul, R.Bolor, G.Sarangoo, R.Oyungerel, S.Tsogtsaikhan, M.Altankhuu**
- **Chest X-ray findings in influenza A(H1N1)v viral infection by L Tungalag, D Gonchigsuren, O Oyunchimeg**
- **Diagnosis of pleural effusion by the method Ultrasonography by O.Baatarchuluun**
- **Differential Diagnosis of pleuritis, ascites, pericarditis in tuberculosis patients by J. Tumendalai, E.Sukhee, B.Tsagaan, P.Selenge, G. Ariumbold**
- **Compared Study of treatment approaches for skin pressure ulcer by O. Javzandulam, E. Sukhee,G. Bor, M. Tsengelmaa**
- **Diagnosis and spreads of Canine Parvovirus in the Ulaanbaatar city by Ts.Ariunaa, Ch.Tungalag, B.Chimedtseren**
- **Result of diagnosis equine glanders by D. Otgonzaya, Ch. Tungalag, A. Bayanzul**

### ORIGINAL RESEARCH ARTICLES

- **Epidemiological and clinical features of Erysipelas registered in Mongolia by B. Saruul**

### REVIEWS, LECTURES AND CONSULTATIONS

### SHORT COMMUNICATIONS AND OBSERVATIONS

- **National influenza workshop 6 (NIW6) recommendations by L.Enkhbaatar**

### ENGLISH ABSTRACTS OF THE ORIGINAL RESEARCH ARTICLES

Гарчиг

# ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ. №6(37). 2010ОН

## “Халдварт өвчин судалын Монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл

Ерөнхий эрхлэгч: П.Нямдаваа, ХӨТМҮХ-ны тэргүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор, академич, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, 99112306, nymadawa@gmail.com

Дэд эрхлэгч: Д.Нямхүү, ХӨСҮТ-ийн дарга, Анагаах ухааны доктор, профессор, 99100155

Эрхэлсэн нарийн

бичгийн дарга: Л.Энхбаатар, ХӨТМҮХ-ны гүйштэгэх захирал, анагаах ухааны доктор, 99780134, cmb1691@yahoo.com

### Гишүүд:

Д.Абмэд,

ХӨСҮТ-ийн тасгийн эрхлэгч, биологийн ухааны доктор, 99778211, 454188 abmed99@yahoo.com

З.Адяасүрэн,

БГХӨЭСГ-ын зөвлөх, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99166676, adiyas\_z@yahoo.com

М.Алтанхүү,

ХӨСҮТ-ийн лабораторын тасгийн дарга, анагаах ухааны доктор, 99297428, amurd@magicnet.mn

Д.Анхлан,

ХБНГУ-ын Мюнстерийн Их сургуулийн Үрэвслийн молекул биологийн төвийн Молекул вирусологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, анагаах ухааны доктор, (49)-251-83-52214, an-hlan@uni-munster.de

Б.Арьяа,

АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгийн Настан судалын институтийн Дархал судалын лабораторийн тэргүүлэх судлаач, биологийн ухааны доктор, biragina@mail.nih.gov

О.Баатархүү,

ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 99188386, baatarkhuu65@yahoo.com

Г.Батбаатар,

ЭМШУИС-ийн Био-анагаахын сургуулийн захирал, анагаах ухааны доктор, дэд профессор, 99081827 godibat@yahoo.com

Д.Даваалхам,

ЭМШУИС-ийн Тархвар судалын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 91990560, davaalkham@hsum.edu.mn

Я.Дагвадорж,

ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, дэд профессор, 91180537, dahgwah@yahoo.com

Д.Дандий,

Биологийн ухааны доктор, төрийн шагналт, 99881009

Ч.Долгор,

ЭМШУИС-ийн зөвлөх багш, анагаах ухааны доктор, профессор, ардын эмч, 99725670

Н.Дондог,

ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны албаны зөвлөх, клиникийн профессор, 362290, ndondog@yahoo.com

Т.Дэлэр,

ХӨСҮТ-ийн зөвлөх эмч, клиникийн профессор, хүний гавьяат эмч, 99170153

Г.Жамба,

ЭМШУИС-ийн захирлын зөвлөх, анагаах ухааны доктор, профессор, гавьяат багш, 458010

Г.Зулхүү,

ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, дэд профессор 99196772, zulkhuug@yahoo.com

Ч.Мөнхцэцэг,

ХӨСҮТ-ийн Тандалтын үндэсний нэгжийн дарга, анагаах ухааны доктор, 99136244, munkh828@yahoo.com

Н.Наранбат,

Анагаах ухааны доктор, 99099471, rnbat@yahoo.com

Д.Отгонбаатар,

БГХӨЭСҮТ-ын ерөнхий захирал, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99113549, 632859

Ж.Оюунбилэг,

НЭМХ-ийн захирал, биологийн шинжлэх ухааны доктор, профессор, 99762000, jobileg@magicnet.mn

Р.Оюунгэрэл,

ХӨСҮТ-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, ravjiroyun@yahoo.com

Ж. Сарантуяа,

ЭМШУИС-ийн Бичил амь-Дархлал судалын тэнхимийн багш, анагаах ухааны доктор 99092771, sarantuya@hotmail.com

Р.Түүл,

ХӨСҮТ-ийн Амьсгалын замын вирус судалын лабораторийн вирусологич, анагаах ухааны доктор, 99093674, rtuu@yahoo.com

Н.Хоролсурэн,

ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 99189309, khorolnaran@yahoo.com

Н.Хүрэлбаатар,

ЭМЯ-ний төрийн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, дэд профессор 99196656, khurel@nccd.gov.mn

С.Цогтсайхан,

ЭМШУИС-ийн Бичил амь-дархлал судалын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, дэд профессор, tsogt\_San@yahoo.com

С.Цоодол,

НЭМХ-ийн тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор,

Н.Цэнд,

ХӨСҮТ-ийн ХӨТСА-ны зөвлөх, анагаах ухааны доктор, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан 88858929

Д.Цээрнзоров,

БГХӨЭСГ-ын дэд захирал, биологийн ухааны доктор, 99883159, dnorov\_99@yahoo.com

Ч.Эрдэнэчимэг,

ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-тай тэмцэх албаны тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99263767, ch\_erdenechmg@yahoo.com

Ч.Эрхэмцэцэг,

АҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, анагаахын шинжлэх ухааны доктор, 99855572, erhemchunt@yahoo.com

### Редакцийн хаяг:

Улаанбаатар, Төв шуудан ш/х 119,

“Халдварт өвчин судалын монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл

Эрхэлсэн нарийн бичгийн дарга Л.Энхбаатар, ХӨСҮТ, Захиргааны байр, Амьсгалын замын вирус судалын лаборатори,

E-mail: cmb1691@yahoo.com; Утас:455847

Хэвлэлийн дизайнер: Л.Хаш-эрдэнэ, Д.Даваадорж

Цаасны хэмжээ: А4

Хэвлэсэн тоо: 300ш

“СПИЙД ВЭЙ” ХХК-д хэвлэв.